



СӨЙМБӨ



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2021.02.09 №06, 07 (10735, 10736)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн ахмад Д.МЭНДБАЯР



МЭНДЧИЛГЭЭ

хөгжлийн сангийн шинэ эх үүсвэрүүд бий болж, тодорхой хөрөнгө төвлөрүүлэх замаар Зэвсэгт хүчний өмнө тулгамдаад буй зэвсэглэл, техникийн шинэчлэлийг хийх, бэлэн байдал, сургалт бэлтгэлийн түвшнийг дээшлүүлэх, бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломж, нөхцөл нэмэгдэж байгаагаараа чухал ач холбогдолтой юм.

Мөн Монгол Улсын Зэвсэгт хүчинд Тусгай хүчний цэргийн командлал, Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийг удирдах газар шинээр байгуулагдаж, үндсэн үүргээ хэрэгжүүлж эхэллээ.

Улс оронд дэгдсэн цар тахлын аюулаас урьдчилан сэргийлэх, өвчлөлийн дэгдэлт, тархалтыг зогсоох, түүний хор уршгийг арилгахад Цэргийн төв эмнэлгийн эмч, эмнэлгийн ажилтнууд маань тэргүүн эгнээнд ажиллаж, өнөөдрийн байдлаар ажиглалт, тусгаарлалтад 1582 хүнийг авч, 550 хүнийг эмчлэн эдгэрүүлээд байна.

Энэ жил Монгол Улсад Цэргийн явдлын яам буюу Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгуулагдсаны 110, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн түүхэн их ойнууд тохионо.

Төр улс, түүх шастирт онцгойлон тэмдэглэгдэх эдгээр үйл явдлын агуулга, ач холбогдлыг сурталчлан таниулж, ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэх өндөр бүтээлийн аяныг өрнүүлж, ажлын үр дүн, чанарыг дээшлүүлэхийн төлөө алба хаагч бүр хичээн ажиллана гэдэгт миний бие итгэл дүүрэн байна.

Цаг үеийн нөхцөл байдлаас үүдэн монгол ёс заншлаа эрхэмлэсэн Сар шинийн баяраа уламжлалт ёсоор тэмдэглэх боломжгүй болсон хэдий ч "Эрхэм баян эрүүл мэнд" гэсэн ардын сайхан сургаалыг санаж, Засгийн газрын шийдвэр, зөвлөмжийг баримтлан шинэлэхийг Та бүхэндээ уриалж, хамгийн сайн сайхан бүхийг хүсэн ерөөе!

Эрхэм генерал, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч, ажилтан албан хаагч, хилийн чанадад үүргээ нэр төртэй гүйцэтгэж буй энхийг сахиулагч, эх орноо батлан хамгаалах үйлсэд хөдөлмөр зүтгэл, залуу насаа зориулсан бэлтгэл болон чөлөөнд байгаа үе үеийн ахмад дайчид Та бүхэндээ билгийн тооллын ХҮИ жарны "Цөөвөр" хэмээгч Цагаагчин үхэр жилийн сар шинийн баярын мэндийг дэвшүүлье!

Улиран одож буй "Хотол төгс" хэмээгч хулгана жил нь Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүний хувьд дэвшүүлсэн зорилго, зорилтуудаа бүрэн дүүрэн хэрэгжүүлсэн, ажил үйлс ундарсан, амжилт ололт бялхсан бүтээлч хөдөлмөрийн түүхэн он байснаараа онцлог юм. Тодруулбал, Улсын Их Хурлын 2020 оны хаврын ээлжит чуулганаар Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар "Зэвсэгт хүчин нь Хуурай замын цэрэг, агаарын цэрэг, барилга-инженерийн цэрэг, кибер аюулгүй байдлын болон тусгай хүчний цэргээс бүрдэнэ" гэдгийг хуульчилсан нь онцлох ач холбогдолтой шийдвэр байлаа.

Тэрчлэн монгол цэргийн нэр хүндийг дэлхийн тавцанд өндөрт өргөх, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч буйн зэрэгцээ Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 километр төмөр замын бүтээн байгуулалтын ажилд манлайлан оролцож, үүргээ амжилттай гүйцэтгэлээ.

Бид удахгүй Ардын журамт цэргийн анхны ялалтаас түүчээлэн алдар гавьяа, амжилт бүтээлийн түүхээр мөнхөрсөн орчин цагийн Зэвсэгт хүчнийхээ түүхт 100 жилийн ойг ёслол тэмдэглэх болно. Энэхүү түүхт ойг бид бүхэн эх орноо хайрлан дээдлэгч монгол хүмүүн бүрийн баяр, эрх чөлөөт орныхоо тусгаар тогтнолын төлөө амь биеэ үл хайрлан тэмцэж, улс



орныхоо хөгжил дэвшлийн төлөө залуу халуун насаа зориулсан үе үеийн эх орончид, тэдний залгамж халаа болсон өнөөгийн цэрэг эрсийн түүх, дайчин уламжлал, бахархлын баяр болгон улс орон даяар өргөн тэмдэглэх зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Монгол түмний уламжлалт их баяр болсон сар шинийн баяраар Та бид буян заяа нь тэгш дэлгэрсэн буурлууд, ахмадуудаа хүндэтгэн дээдэлж, аав, ээж, ахан дүүсийнхээ амар мэндийг асуун мэндчилж, амны бэлгэ-ашдын ерөөлийг нь бахдан сонсож, бахархан биширдэг эрхэм заншилтай.

Цар тахлын өнөөгийн нөхцөлд монгол хүмүүн бүрээс сахилга бат, хувийн болон нийтийн ариун цэвэр, халдвар хамгааллын хатуу чанд дэглэмийг нэн хариуцлагатайгаар шаардаж буй өнөө жилийн хувьд Улсын онцгой комисс, төр, засгийнхаа шийдвэрийг эрхэмлэн хүндэтгэж, холбоо, мэдээллийн технологи, цахим сүлжээг ашиглан зөвхөн өрх гэрийн хүрээнд өндөр соёлтойгоор уламжлалт баяраа тэмдэглэнэ гэдэгт итгэл төгс байна.

Та бүхний санасан бүхэн сэтгэлчлэн биелж, эрхэлсэн ажил үйлс тань амжилтаар дүүрэн, аз жаргал, инээд баяслаар бялхаж, айл хотлоороо амар түвшин байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье!

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ

МЭНДЧИЛГЭЭ



ЗЭВСЭГТ ХҮЧИН-100 ЖИЛ

Ц.Тогоо: ХЭДЭН БОР ЦЭРГЭЭ ИРАК РУУ УДЧИХЭЭД БҮТЭН НОЙРТОЙ ХОНОСОН ШӨНӨ ЦӨӨХӨН



Солонгост ажлын айлчлал хийх үеэр

Эх орноо батлан хамгаалах нэр хүндтэй, ариун үйлсэд хүчин зүтгээд тэтгэвэр чөлөөнд гарсан эрхэм хүндэт ахмадууд Та бүхэндээ учран золгож буй "Цөөвөр" хэмээх Улаагчин үхэр жилийн сар шинийн мэндийг өргөн дэвшүүлж, энх тунх, түвшин жаргалтай байхын өлзий төгс ерөөлийг айлтгая.

Улиран одож буй "Хотол төгс" хэмээх хулгана жилд тархсан цар тахал манай улсын нийгэм, эдийн засагт томоохон уршиг авчирсан хэдий ч төр, засгийн зүгээс бүхий л боломждоо тулгуурлан Монголын нийт иргэд, түүний дотор ахмад настнуудад үзүүлж ирсэн тусламж, хөнгөлөлтийн үр дүнд хямралд харьцангуй бага өртсөн гэж ойлгож байна.

Монгол Улсын Батлан хамгаалах яам ч энэ хүнд бэрх үед ахмад настны талаар авч хэрэгжүүлэх бодлогоо орхигдуулаагүй, харин ч эрчимжүүлсэн гэдгийг та бүхэн мэдэж байгаа.

Өнгөрсөн онд Олон улсын ахмадын өдрийг тэмдэглэх үеэр Батлан хамгаалахын сайдын тушаалаар "Батлан хамгаалах яамнаас ахмад настны талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" батлагдсан тухай миний бие та бүгдэд мэдээлж байсан.

Бодлого, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүд бодитоор хэрэгжиж эхэлснийг салбарын нийт ахмадууддаа дуулгахад таатай байна. Тухайлбал, Батлан хамгаалахын сайдын тушаалаар "Сайдын дэргэдэх ахмадын зөвлөл" байгуулагдаж, ажиллах журам нь батлагдлаа. Зөвлөлийн бүрэлдэхүүнд БХЯ, ЗХЖШ-ын газар, хэлтсийн дарга нар, Цэргийн төв эмнэлэг болон "Багабаян-Энхийн төлөө" цогцолбор төвийн удирдлага, зарим томоохон нэгжийн захирагч, ахмадын хороодын дарга нарын төлөөлөл багтсан бөгөөд хэрэгжүүлсэн ажлынхаа үр дүнг Батлан хамгаалахын сайдад танилцуулж, дэмжлэг авч байхаар шийдвэрлэсэн нь ихээхэн ач холбогдолтой юм.

Тус зөвлөл энэ ондоо багтааж харьяа анги, байгууллагуудын ахмадын хороо, зөвлөлийн нэгдсэн бодлого, удирдамжаар хангах, салбарын ахмад настны судалгаа хийх, мөрдлөг болгох журам, заавар боловсруулах, ахмад настны нийгмийн асуудлыг шийдвэрлэх нөөц боломжийг эрэлхийлэх гэх олон асуудлыг хэрэгжүүлэхээр жилийн төлөвлөгөөндөө тусган, зөвлөлийн гишүүд хуваарилан аваад ажиллаж байна. Мөн ахмадуудын маань дунд ихээхэн хүлээлттэй байгаа "Ахмадын хөгжлийн төв"-ийн барилгын зураг төслийн ажил хийгдэж байна.

Зөвлөлийн ажлын эцсийн үр дүн нь салбарын бүх ахмадын байгууллага хууль, эрх зүйн чадамжтай, нэгдсэн бодлого зорилттой байхад оршино. Энэхүү бодлого, зорилт хэрэгжих гол үндэс нь ахмадын байгууллага, ахмад настан та бүхний идэвхтэй оролцоо байх болно гэдгийг онцгойлон хэлэхийг хүсэж байна.

БХЯ, ЗХЖШ-ын харьяа байгууллага, командлал, нэгтгэл, ангийн удирдлага ахмадын байгууллагатайгаа нягт хамтран ажиллаж, ахмад настны эрүүл, урт наслах боломжийг бүрдүүлэх талаар тодорхой зорилт дэвшүүлэн ажиллана гэдэгт итгэж байна.

Батлан хамгаалах яам байгуулагдсаны 110, Монголын Ардын хувьсгалын болон орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100, Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ой энэ жил тохиож байна. Улс орныхоо хөгжил дэвшил, батлан хамгаалах үйл хэрэгт мэдлэг чадвар, хүч хөдөлмөрөө харамгүй зориулсан ахмад настнуудын хувьд эдгээр томоохон ой бахархан дурсах түүхэн үйл явдал билээ. Ахмадуудын эх орноо гэсэн чин сэтгэлийн хүчин зүтгэл, ариун цагаан хөдөлмөрийн үр шимийг залуу хойч үеийнхэн маань шударгаар үнэлж, бүрнээ залгамжлах болно гэдэгт итгэл төгс байна.

Та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, амжилтын дээдийг хүсэн ерөөе. Сар шинэдээ сайхан шинэлээрэй!

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН ДЭРГЭДЭХ
АХМАДЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Д.МАГСАРЖАВ

Монгол Улсын Зэвсэгт хүчин 100 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлэх түүхэн цаг үе ойртсоор. Энэ өдөр бол Зэвсэгт хүчинд сэтгэл зүтгэл, залуу халуун насаа зориулсан, зориулж яваа цэргийн алба хаагчдын баяр бахдалын өдөр юм. Тэдний чин зорилго нь Монгол Улсын Зэвсэгт хүчнийг чадварлаг, хүчирхэг, гаднын үйлс, орнуудад нөлөөтэй, нэр хүндтэй байлгахын төлөөх хөдөлмөр бөгөөд сэтгэл нь үлс хэрэг бүрт нь шингэж байдаг. Ийм л эх орны эрэлхэг хөвгүүдийн гавьяаг уншигч олондоо сурталчлах эрхэм үүргийг цэргийн сэтгүүлчид бид хүлээж, ЗХЖШ-ын үе үеийн дарга нарыг түүхэн ойн босгон дээр сонинхоо хойморт урьж буй. Энэ удаагийн зочин Монгол Улсын Зэвсэгт хүчнийг дэлхийд тоологч, данслуулсан нэгэн буюу дэслэгч генерал Ц.Тогоо юм.

2002-2009 он хүртэл долоон жил ЗХЖШ-ын даргын хариуцлагатай албыг хашсан тэрээр Өвөрхангай аймгийн Зүйл сумын Есөн зүйл хэмээх газар, бүр тодруулбал Өндөр гэгээн Занабазарын хүй цөглөсөн газар мэндэлжээ. Айлын том хүү багын сурлага сайтай, орос хэлний багш болох хүсэлтэй байсан хэдий ч тухайн жилд нь багшийн хуваарь ирээгүй тул Цэргийн дээд сургуульд орсон гэдэг. 1972 онд Цэргийн дээд сургуулийн Улс төрийн ангид элсэн орсноос өнөөдрийг хүртэл Зэвсэгт хүчний төлөө хоёргүй сэтгэлээр албаа хааж яваа энэ цаг үеийн цэргийн дарга юм. Тэрээр цэргийн хүний дамжих ёстой бүхий л шатны албан тушаалыг хашиж дэслэгчээс дэслэгч генерал хэмээх цэргийн дээд цолыг хүртэхдээ Монголын Зэвсэгт хүчнийг удирдаж, шинэ түвшинд гаргахын төлөө оюун санаагаа зориулан ажилласан шилдгүүдийн нэгд зүй ёсоор орно.

(Үргэлжлэл нь IV нүүрт)

ХУУЛЬ ТӨРЛӨӨ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ БАТАЛЛАА



УИХ-ын чуулганы 2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай” хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг эцэслэн баталлаа.

Манай улс сүүлийн жилүүдэд улсын эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх төмөр зам, автозам, газрын тосны үйлдвэр зэрэг стратегийн томоохон бүтээн байгуулалтыг өрнүүлж, үүнд дотоодын ажиллах хүчнийг оролцуулах, өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлэх бодлогыг баримталж байгаа бөгөөд энэхүү бүтээн байгуулалтад Зэвсэгт хүчний барилга-инженерийн цэргийн анги, салбар, цэргийн алба хаагчид амжилттай оролцож байна.

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулснаар энэхүү бүтээн

байгуулалтад гар бие оролцож байгаа цэргийн алба хаагч залуусын цалин, орлого нэмэгдэхийн зэрэгцээ Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн орлого нэмэгдэх шинэ эх үүсвэр бий болж, тодорхой хөрөнгө төвлөрүүлж, Зэвсэгт хүчний өмнө тулгамдаад байгаа зэвсэглэл, техникийн шинэчлэлийг хийх, бэлэн байдал, сургалт бэлтгэлийн түвшинг дээшлүүлэх, бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэх юм.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулагдаж байсан Зэвсэгт хүчний хөгжлийн сан нь найман төрлийн эх үүсвэрээр хөрөнгө бүрдүүлэхээр хуулийн зохицуулалттай хэдий ч сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд тус сан нь зөвхөн энхийг дэмжих ажиллагааны нөхөн төлбөрөөс хөрөнгө бүрдүүлж ирсэн бөгөөд улсын төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэрээс орлого бүрдүүлж байгаагүй юм.

Зэвсэгт хүчний хөгжлийн санд төвлөрүүлэх улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтаас олох орлогын эх үүсвэрийн тоо хэмжээг тодорхойлох боломжгүй тул тухайн жилийн төсөвт хамаарахгүйгээр Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.5-д “төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого” гэж заасантай нийцүүлэн түүний орлого, зарцуулалтыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн нэмэлт төсөв байхаар хуульчлан баталгаажуулж байгаагаараа онцлогтой.

“Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулиар “Зэвсэгт хүчний хөгжлийн сан”-г Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тусгай сангийн төрөлд хамааруулж, бүрдүүлэлт, зарцуулалтын онцлогтой холбогдсон харилцааг

Зэвсэгт хүчний тухай хуулиар, нийтлэг харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулахаар болж байгаа нь цаг үеийн шаардлагад нийцсэн, ач холбогдол бүхий эрх зүйн зохицуулалт болж байна.

Үүнээс гадна “Зэвсэгт хүчний хөгжлийн сан” нь улсыг батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хөгжлийн бодлого, зэвсэглэл, техникийн шинэчлэл, бэлэн байдал, сургалт бэлтгэлтэй шууд холбоотой байдгаас гадна гадаад улстай байгуулсан цэрэг болон цэрэг-техникийн хамтын ажиллагааны хүрээнд сангийн хөрөнгөөр Зэвсэгт хүчинд байлдааны зэвсэг, техник, тоног

төхөөрөмж худалдан авах тул энэхүү сангийн зарим орлого, зарцуулалтыг төрийн нууцад хамааруулахаар “Төрийн болон албаны нууцын тухай” хуульд нэмэлт орж байгаа юм.

“Зэвсэгт хүчний тухай” хуульд нэмэлт оруулснаар Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдэж, Зэвсэгт хүчний өмнө тулгамдаад байгаа зэвсэглэл, техникийн шинэчлэлийг хийх, бэлэн байдал, сургалт бэлтгэлийн түвшинг дээшлүүлэх, бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх, Зэвсэгт хүчний хөгжилд бодитой үр дүн үзүүлэх ач холбогдолтой юм.

БОДЛОГО, ЗОРИЛТ

Ш.Гантулга: ЦЭРГИЙН СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ТОГТОЛЦООНД ШИНЭЧЛЭЛ ХИЙГДЭНЭ

ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга, хурандаа Ш.ГАНТУЛГА

Энэ онд Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн гол бодлого юунд чиглэж байгаа талаар мэдээлэл өгнө үү?

“Зэвсэгт хүчний тухай” хуульд өөрчлөлт орж, Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтад Тусгай хүчний болон Кйбер цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар бий болсон. Энэ нь өөрөө Зэвсэгт хүчний сургалт бэлтгэлд тогтолцооны шинэчлэлийг зайлшгүй шаардаж байна. Тэгэхээр бид 2021 онд хамгийн эхний ээлжид энэхүү бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, тухайн командлал, нэгтгэл, анги, байгууллагынхаа гүйцэтгэх үүрэг чиглэл, онцлогт нийцсэн цэргийн сургалт бэлтгэлийн тогтолцоог шинэчлэх үндсэн зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Ингэхдээ мэдээж өмнө нь баримталж байсан Хуурай замын цэргийн болон Агаарын цэргийн командлалын сургалтын тогтолцоотой уялдуулна.

Мөн дээрээс нь цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангахын тулд төлөвлөгөөнд тусгасан ажил, арга хэмжээнүүдээ хэрэгжүүлээд зогсохгүйгээр шинээр боловсруулагдаж, шинэчлэн батлагдаж байгаа байлдааны болон төрөл мэргэжлийн цэргийн дүрэм журам, заавруудын дагуу цэргийн сургалт бэлтгэлийг явуулна. Тодруулбал, явагдаж байгаа үйл ажиллагаа маань хууль, эрх зүйн үндэслэлтэй, дүрэм журмынхаа дагуу явагдана гэдэг дээр гол анхаарлаа хандуулж цэргийн сургалт бэлтгэлээ төлөвлөн зохион байгуулж байна. Холбогдох албан тушаалтан, газар, хэлтэс, анги, байгууллагуудад ч энэ чиглэлийн үүргүүдийг өгч байгаа. Ингэснээрээ хийсвэр байлдааны дүрмийн хүрээнд гэдэг юм уу, өмнө нь ингэдэг байсан гэсэн уламжлалт хэлбэрээр биш, Монгол Улсын Зэвсэгт хүчин өөрийн гэсэн үндэсний цэргийн стратегийг боловсруулах, үндэсний гэсэн онцлогийг гаргаж ирэхэд сургалт бэлтгэлийн тогтолцоогоо чиглүүлье. Тэгээд болох, болохгүйг нь ялгаж салгаж, шинэчлэж, сайжруулъя гэсэн үндсэн зорилтын хүрээнд цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.

Цэргийн сургалт бэлтгэл хэвийн явагдах нөхцөл боломжийг цар тахлын дэгдэлт тодорхой хэмжээгээр хумьж байна. Үүн дээр ямар

зохицуулалт хийж байгаа вэ?

Тийм ээ, энэ жилийн хувьд цар тахлын нөхцөл байдлаас хамаараад цэргийн сургалт бэлтгэл уламжлалт хэлбэрээр явагдах боломжгүй болоод байна. Тийм учраас бид Зэвсэгт хүчний сургалт бэлтгэлд техник технологийн дэвшлийг ашиглахаас өөрцгүй. Цахим сургалтууд болоод хувь хүний өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзэл, эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалтын агуулга, технологи, орчин нөхцөл, арга зүйгээ сайжруулах хэрэгцээ шаардлага эндээс урган гарч байна. Үүнтэй уялдаад ЗХЖШ-аас сургалт бэлтгэлийн удирдлага технологийн системийг нэвтрүүлэх, цахим сургалт явуулах орчин нөхцөл, цэргийн алба хаагчдын бие даан суралцах боломжийг бүрдүүлэхэд түлхүү анхаарч ажиллана. Тодруулбал, ЗХЖШ-ын вэб сайтад сургалт бэлтгэлийн удирдлага технологийн системийг бий болгож, анги, байгууллагуудад цахим сургалт явуулах бүхий л боломжийг бүрдүүлнэ.

Цэргийн сургалт бэлтгэлийн стандартыг шинээр боловсруулж байгаа юм билээ. Энэ талаар тодруулахгүй юу?

Аливаа цэргийн сургалт бэлтгэлийг стандартын дагуу явуулах гэсэн үндсэн зарчмыг барьж байгаа бөгөөд энэ онд сургалт бэлтгэлийн орчны стандартыг шинээр боловсруулна. Ингэснээр буудлага, жолоодлого, дадлагын ямар талбайд, аюулгүй байдал, эрүүл ахуйн ямар шаардлага хангасан орчинд сургалт бэлтгэл явагдах ёстой вэ гэдэг стандарт, дүрэм, журам, зааврыг тогтоож өгөх юм. Түүнчлэн сургалтын хэрэглэгдэхүүний стандартыг мөн боловсруулж байна. Стандартыг боловсруулснаар тухайн ангид сургалт бэлтгэлийн чиглэлээр хэрэглэгдэх ном, гарын авлага, дүрэм журам, заавар, үзүүлэн таниулах материалууд ямар байх ёстой вэ, цаашлаад хичээлийн агуулга, хөтөлбөр, лекцийг хэрхэн яаж боловсруулах вэ, түүнд стандартын ямар шаардлага тавигдах вэ гэдгийг тодорхой болгож өгөх юм.

Энэ жил хэд хэдэн томоохон түүхт ой тохиож байгаа шүү дээ. Энэ хүрээнд нэлээдгүй тэмцэн, уралдаан төлөвлөгдсөн байх ...

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит маршийн тэмцээнийг Зэвсэгт хүчний 100 жилийн ойн хүрээнд нэлээд өргөн хэмжээнд зохион байгуулна.



Өөрөөр хэлбэл, урьд нь тасаг, салааны түвшинд явуулдаг байсан бол энэ жил салбар буюу мотобуудлагын ротын төрлийг нэмэхээр удирдамж заавраа боловсруулан бэлтгэлээ базааж байна. Мөн олон улсын цэргийн наадмын хүрээнд явагддаг “Аравт” морин цэргийн уралдааныг өөрийн оронд болон Цэргийн ралли уралдааны I шатны шалгаруулалтыг ОХУ-тай хамтран зохион байгуулах тухай Засгийн газрын шийдвэр гарсан. Түүнчлэн Танкын биатлонд ч баг тамирчдаа илгээнэ. Тэгэхээр эдгээр тэмцээн уралдааны бэлтгэлийг зохион байгуулагч болон оролцогч орны хувьд сайтар базаахад анхаарч байна.

Зэвсэгт хүчний олимп гэгддэг марш-тактик, тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээний тухайд тодруулахгүй юу? Шүүлт болон дасгал, нормативын хувьд зарчмын нэлээд өөрчлөлт орсныг нэгтгэл, анги, байгууллагуудын биеийн тамир хариуцсан албан тушаалтнуудын цахим цугларалтын үеэр танилцуулж байсан ...

Энэ жилийн хувьд цэрэгжлийн спортын жил гэж ойлгож болно. Энэ хүрээнд анги, байгууллагуудын хүлээдэг тэмцээн бол яах аргагүй марш-тактик, тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээн байдаг. Тус тэмцээнийг энэ жил мөн Зэвсэгт хүчний 100 жилийн ойн хүрээнд явуулна. Ер нь эл тэмцээнийг олон улсын жишигт нийцүүлэн зарчмын нэлээд өөрчлөлт оруулсан. Марш-тактик, тусгай бэлтгэл гэдэг утгаараа өмнө нь хийгдэж байсан маршийн дасгал, нормативуудыг бодит нөхцөлд илүү ойртуулсан, шинээр батлагдсан дүрэм журам, заавар, нормативуудыг боловсруулах чиглэл рүү түлхүү

хандуулж зохион байгуулдаг болно. Тодруулбал, оролцож байгаа цэргийн алба хаагчдын мэдлэг, тактикийн сэтгэлгээг шалгасан дасгал нормативуудыг голчлон оруулна. Салаа, тасгийн захирагч нар тэмцээний гарааны өмнө юу хийж чаддаг байх ёстой вэ гэдгээс эхлээд тактикийг хэрхэн боловсруулж байгаа нь харагдана. Үндсэндээ цэргийн алба хаагчийн тактикийн мэдлэгийн түвшин онолын болон дадлагын хувьд ямар байна вэ гэдгийг шалгаж байгаа хэрэг.

Аливаа уралдаан тэмцээнийг явуулахдаа манайхан торгууль, шагналын оноо өгөөд л явуулдаг. Энэ тогтолцоог бүр мөсөн халж байгаа. Өөрөөр хэлбэл, даалгаврын гүйцэтгэлээс хамаарч онц, сайн, дунд гэсэн үзүүлэлт байхгүй гэсэн үг. Тухайн цэргийн алба хаагч үүргээ биелүүлсэн, эсвэл үгүй гэдэг байдлаар дүгнэнэ. Энэ мэтээр тэмцээн уралдааны олон улсын жишигт нийцүүлэн илүү чанар, үр өгөөжтэй зохион байгуулдаг байхаар өөрчлөлтүүдийг хийж байна. Энэ бол цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах арга хэмжээний нэг том агуулга.

Нэгтгэл, анги, салбаруудын хэргийн гаралт хэзээнээс эхлэх вэ?

Үндсэндээ 3 дугаар сараас нэгтгэл, анги, салбаруудын хэргийн гаралт, полигоны дадлага сургууль эхлэнэ. Цар тахлын үеийн дэглэмийг сайтар сахиулж, богино хугацаанд үр дүнтэй зохион байгуулна. Болж өгвөл хэргийн гаралтын явцад төрөл мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн уралдаануудыг явуулахаар төлөвлөсөн. Төгсгөлд нь бүх нэгтгэл, ангиуд мотобуудлагын рот хүртэл хүч хэрэгслээр байлдааны буудлагыг төлөвлөн явуулах зорилттой ажиллаж байна. Яагаад гэхээр

цэргийн алба хаагч л бол та цэргийн тактикийн ажиллагаа гэдгийг мэдэж байх ёстой. Ямар ч мэргэжлийн анги, байгууллагын үндэс нь тактик. Ерөнхий цэргийн тактик мэдэхгүй холбоо, авто байж таарахгүй. Тиймээс бүх анги, байгууллага явган болон байлдааны техниктэйгээр мотобуудлагын ротын байлдааны буудлагатай тактикийн хэргийн сургуулийг өөр өөрийн дотоод нөөц боломждоо тулгуурлаад зохион байгуулна. Ингэснээр штабын болон бусад салбарын офицеруудын тактикийн сэтгэлгээ задарч, тактикийн ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах мэдлэг чадвар сайжирна. Ахлагч нарын гүйцэтгэх тактикийн мэдлэг, дадлагад тодорхой ахиц гарна гэж үзэж байгаа юм.

Төгсгөлд нь цогцолбор шалгалт, түүний тогтолцоонд орсон өөрчлөлтийн тухайд тодруулахгүй юу?

Шалгалтын тогтолцооны хувьд шинэчлэл хийгдэж байгаа. Үндсэндээ 2018 онд эхлэл нь тавигдсан гэж болно. Үүрэг гүйцэтгэх чадавхын шалгалтыг зохион байгуулаад анги, салбаруудын бэлэн байдал, сургалт бэлтгэл, цэргийн алба, байлдааны жигдрэлтийг шалгасан. 2020 оны сургуулийн жилийн төгсгөлд илүү бататгаад ХЗЦК-ын зарим нэгтгэл, анги, ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын харьяа зарим ангийг оролцуулан цогцолбор шалгалт явуулсан нь маш үр дүнтэй болсон. Удирдлага, штабаас анги, салбаруудаа хэрхэн удирдах, байлдааны ажиллагааг хэрхэн зохион байгуулах, байлдааны буудлагатай сургуулийг нэгдсэн болон хамтарсан хэлбэрээр яаж зохион байгуулах талаар харилцан туршлага судалсан, хоорондын уялдаа холбоо сайжирсан гээд маш үр дүнтэй болсон.

Шалгалтын тогтолцоо хэрхэн шинэчлэгдэж байгаа тухайд гэвэл ЗХЖШ анги, байгууллагын үүрэг гүйцэтгэх чадавх ямар байна гэдгийг нийтэд нь хамарсан цогцолбор шалгалтаар үнэлдэг байх, командлалууд нь харин тухайн нэгтгэл, анги, салбараа сонгоод бэлэн байдал, сургалт бэлтгэл, цэргийн алба ямар байна вэ гэдгийг дүгнэхийдэг, анги, салбарууд нь өөрийнхөө сургалт бэлтгэл, штабын бэлтгэл, салбарын жигдрэлт, хүн нэг бүрийн бэлтгэл, биеийн тамир, спортын арга хэмжээний үр дүн, бэлтгэлжилтийн үр өгөөж ямар байна вэ гэдгийг тооцож үнэлдэг байх гэх мэтээр шалгалтын тогтолцооны асуудал дээр шинэчлэл хийж байгаа юм.

Ахмад Д.МЭНДБАЯР

ЗАХИРАГЧ НАР ЯРЬЖ БАЙНА

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН АСУУДЛУУД ШАТ ДАРААТАЙ ШИЙДЭГДЭЖ БАЙНА

Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн захирагч, хурандаа Ц.БУЯНТОГТОХ

Юуны өмнө сахилгын зөрчилгүй хамт олноор шалгарсанд баяр хүргэе. Баярын сэтгэгдлээсээ хуваалцахгүй юу?

-Бид гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан олон ажил, арга хэмжээний биелэлтийг хангахын тулд идэвх санаачилгатай ажиллалаа. Хүн бүрийн идэвх зүтгэл өндөр байсныг онцлох нь зүйн хэрэг байх. Цэргийн хөдөлмөрийн болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм зэрэг сахилгатай холбоотой олон хууль тогтоомжийг мөрдөж, тушаал зааврын хэрэгжилтийг хангахын зэрэгцээ цар тахлаас урьдчилан сэргийлэх хүрээнд тодорхой 10 даалгаврыг хэрэгжүүлж ажилласны үр дүнд "Сахилгын зөрчилгүй хамт олон"-оор шалгарлаа. Захирагчийн хувьд хамт олондоо баярлаж байгаагаа уламжилъя.

Танай ангийн хувьд 2020 он



ямар жил болж өнгөрөв?

-Зэвсэгт хүчний 331 дүгээр анги 2020 оныг "Бэлэн байдлыг дээшлүүлэх жил" болгон зарлаж зорилго зорилтуудаа ханган ажилласан. Цар тахлын үе хэдий ч төлөвлөгөөт сургалт бэлтгэлүүдийг тасралтгүй явуулсан. Мөн Монгол Улс, ХБНГУ-ын Зэвсэгт хүчний хамтарсан Уулын явган цэргийн сургалтад амжилттай оролцлоо. Зэвсэгт хүчний Жанжин штабын цогцолбор шалгалтад сайн дүнтэй буюу үүрэг гүйцэтгэх боломжтой гэж шалгагдсан. ЗХЖШ-ын ХШҮГ-ын болон Хүний эрхийн үндэсний комиссын шалгалтаар сайн дүнтэй дүгнэгдсэн зэрэг ололт амжилт цөөнгүй бий.

2021 онд ямар зорилго, зорилт дэвшүүлсэн бэ?

-Нийт офицер, ахлагч, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх жил байх болно. Энэ хүрээнд хамгийн түрүүнд "Гэр" төслийг хэрэгжүүлэхээр хотхон байгуулах

саналаа уламжилсан. Цаашид "Хашаа байшин", "Орон сууц" зэрэг төслийг хэрэгжүүлэхийн төлөө ажиллана.

Ажилчдын автобус болон алба хаагчдын хүүхдүүдийн цэцэрлэгийн хангамж, хүрэлцээ бага зэрэг асуудал байсан. Эдгээр асуудал хэрхэн шийдэгдсэн бэ?

-Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабаас тулгамдсан асуудлуудыг шат дараатай шийдвэрлэж ирсэн. Тухайлбал, 2019 оны сүүлчээр ажилчдын шинэ автобустай болсон. Офицер, ахлагч нарын өмнө тулгамдсан асуудлуудын нэг нь цэцэрлэгийн хангамж, хүрэлцээ байсан. Байгууллагын дэргэдэх "Баясах ирээдүй" хүүхэд харах үйлчилгээ маань өнөөдөр цэцэрлэгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжоор хангагдаад байна. БХЯ, ЗХЖШ-ын удирдлагууд орчин нөхцөлтэй нь танилцсан. Удахгүй байр болон багш нарын цалингийн асуудал шийдэгдэх байх.

ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ОРЧИН НӨХЦӨЛӨВ САЙЖРУУЛЛАА

Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн захирагч, хурандаа Ж.ӨСӨХБАЯР

Танай хамт олон 2020 оныг ямар ажлуудаар үдэв. Өнгөрсөн оны ололт амжилтаасаа хуваалцахгүй юу?

-Манай ангийн хамт олон өнгөрөгч онд удирдах байгууллагаас өгсөн үүргийн болон ангийн дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлж, төлөвлөсөн ажил, арга хэмжээнүүдээ биелүүлэн ажиллалаа. Ер нь 2020 он бидний хувьд ажил хөдөлмөр буцалсан, өгөөжтэй сайхан жил байсан. Хамт олноороо чамлахааргүй ажлууд амжуулсан гэж болно. Тухайлбал, анх удаа "Ангийн хөгжлийн хөтөлбөр"-ийг хамт олноороо хэлэлцэн боловсруулж, Хуурай замын цэргийн командлагчаар батлууллаа.

Мөн анги тайван цагийн орон тооны шинэ бүтэц, зохион байгуулалтад шилжсэнээр алба, салбаруудын гүйцэтгэх үүрэг улам тодорхой болж, үндсэн хөдөлмөр болох цэргийн сургалт бэлтгэлийн чанарт ахиц гарсан. Тодруулбал, байнгын бүрэлдэхүүний сургалт бэлтгэл чанартай зохион байгуулагдаж, үр дүнд нь манай анги өнгөрсөн жилд бэлэн байдал, цэргийн сургалт бэлтгэлийн чиглэлээр Зэвсэгт хүчний хэмжээнд зохион байгуулагдсан "Штабын бэлтгэл сургалтаар тэргүүлэгч штаб шалгаруулах бэлэн байдлын үзлэг"-т тэргүүн байр эзэлсэн. Энэ бол бидний хувьд бахдам амжилт байлаа. Нэг түүх сөхөж сонирхуулахад 2006 онд явагдсан "Бэлэн байдлын үзлэг"-т мөн манай анги тэргүүлж, тухайн үеийн захирагч, хурандаа Н.Бумцэнд



автомашинаар шагнагдсан.

Бүтээн байгуулалтын маш олон ажил өрнүүлсэн юм билээ. Энэ тухайд тодруулна уу?

-Тийм ээ, чамгүй ажил өрнүүлсэн. Өнгөрсөн онд ангид хийгдсэн нэг чухал арга хэмжээ бол орон нутгийн хөрөнгө оруулалтаар ангийн штаб, цэргийн байр, 11 айлын орон сууцанд хийгдсэн их засварын ажил байлаа. Дээрх барилга байгууламжуудад иж бүрэн засвар, тохижилтын ажил хийгдсэнээр цаашид ашиглах хугацаа уртасч, мөн хамт олны ажиллаж, амьдрах ая тухтай орчин нөхцөл сайжирсан.

Үүнээс гадна манай хамт олон өөрсдийн хүчээр гэрэлтүүлэг, хяналтын системийг шинэчлэх, зам талбайг

сайжруулах зэргээр тохижилт, бүтээн байгуулалтын чамгүй ажил өрнүүлж, бодит хөрсөнд буулгасныг дурдахад таатай байна.

Мөн тодооддоо зохион байгуулсан "Дэвээр" төслийн хүрээнд артиллер, зэвсгийн албадын техник хадгалах агуулахын дээврийг шинэчилж, хадгалалтын орчныг сайжруулсан. Цэргийн алба, сахилгыг бэхжүүлэх чиглэлээр албад, салбарын дунд олон аян, уралдаан тэмцээнийг тодорхой давтамжтайгаар орон нутгийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, үр дүнд тооцож ажилласан. Үүний үр дүнд манай ангид албаны холбогдолтой гэмт хэрэг гараагүй бөгөөд сахилгын

зөрчил дутагдлын тоо буурсан нь хамт олны минь амжилтын нэг гол үзүүлэлт болсон. Эргээд харахад энэ мэтчилэн олон ажлыг манай хамт олон өрнүүлжээ.

Та бүхний өнөө жилийн зорилго зорилт, төлөвлөгөө юунд чиглэж байна вэ?

-2021 онд тус ангийн бие бүрэлдэхүүн дэвшүүлсэн зорилго, зорилтоо дүүрэн хангалттай биелүүлэхийн төлөө чармайн ажиллаж байна. Энэ хүрээнд удирдлага, төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулж, цэргийн сургалт, бэлтгэлийг чанартай, тасалдалгүй зохион байгуулна. Мөн цэргийн албыг хэвшүүлэх, албаны сахилга, дэгжурмыг сайжруулахад гаргасан амжилтаа ахиулах, материал, техникийн хангалт, хадгалалт хамгаалалтыг тасалдалгүй хэрэгжүүлэхэд болон удирдлагаас өгсөн үүрэг, дэвшүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллана. Түүнчлэн бие бүрэлдэхүүнийхээ эрүүл мэндийг хамгаалах, тэднийг чийрэгжүүлэх, гэр бүлийн хөгжил, хамгаалалд анхаарлаа хандуулах болно.

Мэдээж аймаг, орон нутагтайгаа хамтран ажиллана. Ялангуяа энэ жил Ардын хувьсгалын 100, БХЯ-ны 110, Зэвсэгт хүчний 100, Монгол хүн сансарт ниссэний 40 гээд түүхт тэгш ойн жил тохиож байгаа учраас энэ хүрээнд Батлан хамгаалах бодлого зорилт, Зэвсэгт хүчнийхээ үйл ажиллагааг орон нутгийн ард иргэд, хүүхэд залууст сурталчлан таниулах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх чиглэлээр аймгийн удирдлага, тэр тусмаа ЗДТГ-ын Цэргийн штабтайгаа уялдаа холбоотой ажиллана.

АЖИЛ, АМЖИЛТ УНДАРСАН ЖИЛ БАЙХ БОЛНО

Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн захирагч, хурандаа Н.МЯГМАРЦООЖ

Ангийнхаа сонин сайхнаас хуучлахгүй юу?

-Манай ангийн хувьд 2020 он амжилт бүтээлээр баялаг жил болж өнгөрлөө. Өнгөрсөн онд 130 ажил төлөвлөснөөс 122 нь биелсэн. Цар тахлын нөхцөл байдлын улмаас 8 ажил хэрэгжээгүй. Хамгийн чухал нь ЗХЖШ-ын даргын цогцолбор шалгалтад амжилттай шалгагдаж, үүрэг гүйцэтгэх чадамжтай гэж дүгнэгдлээ. Хөдөлгөөнт удирдлагын байрыг шинээр тохижуулсан нь гол нөлөөг үзүүлсэн. Мөн сахилгын зөрчилгүй, тэргүүний тохижилттой 8 ангийн нэгээр шалгарлаа. Цар тахалтай байгаа хэдий ч офицер, ахлагч нар сургалт бэлтгэлүүдээ тасалдуулсангүй. Хууль, эрх зүй болон Зэвсэгт хүчинд ашиглагдаж байгаа зэвсэг техникийн талаарх гарын авлагагч хэвлэл бие бүрэлдэхүүнд тараасан. Ямар ч үед тэрхүү гарын авлагаас мэдээллээ түргэн шуурхай авч байна. Цар тахлын нөхцөл байдлын үед сургалтын энэ арга хэлбэрийг ашигласан нь нүдээ олсон зөв шийдэл хэмээн бие бүрэлдэхүүн ам сайтай байгаа.

Дараагийн дугаарт, "Сахилгын талон" гэх шинэ жишгийг тогтоосон. Ингэснээр ангийн бие бүрэлдэхүүн сахилгын гэрчлөөс ангид байх бололцоо нэмэгдсэн гэж үзэж байна. Нууц, архивын хэрэг хөдөлтийн үзлэгт амжилттай

шалгагдаж Зэвсэгт хүчний хэмжээнд гуравдугаар байранд шалгарсан амжилт үзүүлээ. Малын тоо толгой эрчимтэй өсөж байна. Ангийн хувьд энэ онд 12 мянган толгой мал тоолууна гэж тооцоолсон. Гэхдээ 18 мянгад хүрч сүүлийн жилүүдэд эвдэгдээгүй амжилтыг үзүүлээ. Үүнийг ангийн нийт бие бүрэлдэхүүний идэвх зүтгэл, санаачилгын үр дүн гэж харж байна.

Нийгмийн хамгаалал болон иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх чиглэлд хийгдсэн ажлуудаас сонирхуулбал ...

-Нийгмийн хамгааллын чиглэлд хийсэн ажлуудаас нэрлэвэл, офицер, ахлагч нарын байрны гадна, дотор талд засвар хийж, шугам сүлжээг шинэчлэн сольсноос гадна алба хаагч, ажилтнууд автомашины гражтай болсон. Машинтай хүн бүр гражтай болсон гэсэн үг.

Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгээд ирсэн зарим алба хаагчийн хувьд ипотекийн зээлд хамрагдаж, орон сууцтай болох боломж бүрдсэн сайхан мэдээ байна. Орон нутагт суурьших, хүнсний ногоо тариалах хүсэлтэй офицер, ахлагч нарт Дэлгэрхаан сумын захиргаа дэмжлэг үзүүлсээр ирсэн гэдгийг хэлэх нь зүйтэй. Өнгөрсөн онд гэхэд 2 ахлагч өөрсдийн гэсэн хашаа байшинтай болсон бол 3 ахлагч хамтраад төмс, хүнсний ногоо тариалж эхэлсэн. Дэлгэрхаан сумын захиргаа газрын асуудлыг шийдэж өгсөн. Хүнсний ногоо тариалсан 3 ахлагч 10



гаруй сая төгрөгийн ашигтай ажиллалаа. Ангиас гавьяаныхаа амралтад гарсан ахмадуудад төрөл бүрийн дэмжлэг тусалцааг үзүүлж байна. Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, Зэвсэгт хүчний сурталчлах чиглэлд тус сумын хүүхдийн

цэцэрлэгийг тохижуулж, Зэвсэгт хүчний 100 жилийн ойг угтан ЕБС-д "Зэвсэгт хүчин" хэмээх шинэ танхим байгуулахаар тохиролцож, гэрээ байгуулаад ажиллаж байна.

2021 онд их ажлын жил байх болов уу, ямар дүр зураглал бууж байна вэ?

Бие бүрэлдэхүүний сурч, боловсрох таатай нөхцөлийг бүрдүүлэх, сургалт бэлтгэлийг дээшлүүлэх, бэлэн байдлыг хангах, алба хаагчдын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд анхаарч ажиллана. Зорилго зорилтуудаа тодорхойлоод ажлуудаа төлөвлөсөн. Хэнтэй аймгийн МСҮТ-тэй хамтраад зарим ахлагч нараа мэргэжил олгох сургалтад хамруулахаар болоод байна. Цар тахлын нөхцөл байдал сайжирвал энэ ажил хэрэгжиж эхлэх байх. Батлан хамгаалахын сайд Ардын хувьсгалын 100 жилийн ойн Төрийн далбааны өдрөөр морин цэргийн ёслолын жагсаалыг зохион байгуулах үүрэг чиглэл өгснөөс гадна энэ онд "Аравт" олон улсын морин цэргийн уралдаан болно. Манай ангийн хувьд хүн нэг бүрийн үүрэг оролцоо өндөр байх болов уу. Тиймээс бид бэлтгэл ажлыг хангаж эхэлсэн. Энэ мэтчилэн томоохон ажил, арга хэмжээ биднийг хүлээж байна. 2021 он үндсэндээ их ажил, амжилт ундарсан жил байх.



Ц.Тогоо: ХЭДЭН БОР ЦЭРГЭЭ ИРАК РУУ ҮДЧИХЭЭД БҮТЭН НОЙРТОЙ ХОНОСОН ШӨНӨ ЦӨӨХӨН

(Түрүүч нь I нүүрт)

Монгол Улсын Зэвсэгт хүчнийг дэлхийд тоолгож, данслуулсан гэсэн нь учиртай. Дэслэгч генерал Ц.Тогоо Зэвсэгт хүчнийг удирдаж эхэлсэн 2002 оноос Монголын Зэвсэгт хүчин зөвхөн дотооддоо сургалт, бэлэн байдлаа хангах бус гадаад ертөнцтэй хөл нийлүүлэх эхлэлийг тавьсан. Гадаадад үүрэг гүйцэтгэх, энхийг сахиулах ажиллагаа, энхийг сахиулагч хэмээх нэр томъёог анх Монгол оронд оруулж, нутагшуулсан бөгөөд энэ цаг үеэс л монгол цэрэг, дайчдыг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах, тэдэнтэй дүйцсэн хэмжээнд боловсрол эзэмших, цэргийн мэргэшил олгох боломжийг дэслэгч генерал Ц.Тогоо болон түүний удирдлагад ажиллаж байсан баг хамт олон нээсэн юм. Тодруулбал, 2002 оны 10 дугаар сард ахмад Ч.Ерөөлцэнгэл, Р.Даваадорж гэх хоёр залуухан офицер Баруун Сахарт жилийн хугацаатай үүрэг гүйцэтгэхээр явсан нь Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагч гадаадын энхийг сахиулах ажиллагаанд оролцохын эхлэл байлаа. Дараа жилээс нь Ирак улсад цэргийн бага илгээн үүрэг гүйцэтгэж эхэлсэн бөгөөд өнөөдрийн арван мянга хол давсан энхийг сахиулагчдын үйл ажиллагааны эхлэл болж чадсан. Энэ талаар тэрээр "Одоо эргээд бодоход бид маш зоригтой алхам хийж залуусаа Ирак руу илгээж байлаа. Явуулах гээд бэлтгэл хангаж байхад бидэнд агсамж, дуулга гээд юу ч байгаагүй. Өвдгөвч, тохойвч ч гэж мэддэггүй байлаа. Энэ бол Монголын Зэвсэгт хүчнийг шинэчлэх, нийгэмд таниулах, олон улсын түвшинд гаргах ганц зам байсан учраас тийм зоригтой алхам хийсэн. Хэдэн залуусаа Ирак руу явуулчхаад бүтэн нойртой хоносон шөнө цөөхөн дөө. Анхны халдлага болох үед энд өдрийн цайны цаг таарсан. Утас авахад "Дарга аа! Энд халдлага боллоо" гэхэд хамгийн түрүүнд "Цэргүүд бүрэн үү" гэж асуусан. Түүний ар дээр юу болсон талаар лавлаж байгаа юм. Нүднээс нулимс гарахаар тийм их хариуцлага, сахилгатай дайчин цэргүүд бол монгол цэргүүд. Үүнийг Иракт үүрэг гүйцэтгэж байсан цэргүүд дээрээ очихдоо мэдэрч, тэднээрээ бахархаж байсан. Яг очих өдөр халдлага болсон байсан.

Найм, есөн орны 2000 гаруй цэргийн алба хаагчдаас манай цэргүүд л цагийн байдалд дасан зохицож шаардлагатай арга хэмжээг авч, хийморь золбоотой, авхаалжтай үүрэг гүйцэтгэж байсан. Хүний газар нутгаа санасан цэргүүд, тэднийгээ санасан дарга бид хэд яг л аав, хүү шиг уулзалдаж байлаа. Энэ цаг мөч бол миний амьдралд төдийгүй Монгол Улсын Зэвсэгт хүчинд мартагдашгүй цаг үе болж үлдсэн. Үүний дараа бид НҮБ-ын сонгомол ажиллагаанд явах эрхтэй болсон. Сьерра Леоны ажиллагаанд явах мандатаа авчихаад байдаг. Гэтэл Засгийн



Ирак, Аль Хилла бааз. Хошууч генерал Г.Рагчаагийн хамт

жигдэрч, энхийг сахиулагчдын ээлж солигдоход ам.долларын ханш хэлбэлзэж, хөдөө орон нутаг руу шинэ машины цуваа явдаг болсон. Энэ хэдий жигж зүйл мэт боловч цэргийн алба хаагч, тэдний ар гэр цаашлаад улс орны эдийн засагт эергээр нөлөөлсөн чухал үйл явдал болсон юм. Энэ том ажлын ард гарахад ч эрх зүйн хувьд боловсронгуй болгоход ч үе үеийн Батлан хамгаалахын сайд нар, тэр дундаа Батлан хамгаалахын сайд асан Ж.Гүррагчаа, хошууч генерал Р.Гаваа, Г.Рагчаа, Б.Шагдар нарын хүчин чармайлт их байсан" гэж дурссан. Энэхүү гарцаас улбаатайгаар гаднын улс орнуудтай харилцаа холбоотой болох, урд, хойд хөрштэйгөө цэрэг, армийн харилцаагаа сэргээн өргөжүүлэхэд ихэд анхаарч, тогтвортой харилцаатай болох эхлэлийг мөн л түүнийг ЗХЖШ-ын даргын албыг хашиж байх үед эхлүүлж байсан юм. Мөн энэ үед зэвсэг, техникийн тусламжуудаар хангагдаж, хамгийн чухал болох боловсон хүчнээ гадаад улсад сургах талаар хамтын ажиллагаа нэлээд өргөжиж, хоёр хөршөөс гадна бусад улсад цэргийн эрдмийн чиглэлээр манай алба хаагчид суралцаж эхэлжээ.

Үүнээс гадна дэслэгч генерал Ц.Тогоо хамгийн анх АНУ-ын БХЯ, ЗХЖШ-тай хамтран ажиллаж эхэлсэн. Өөрөөр хэлбэл, хөрш хоёр гүрнээс илүү гардаггүй байсан манай улсын Зэвсэгт хүчин гуравдагч оронтой хамтын ажиллагаа тогтоож, энэ хүрээнд олон цэргийн алба хаагч АНУ-д цэргийн эрдмийн чиглэлээр суралцаж, гадаадын цэргийн алба хаагчидтай хамтарсан сургууль, дадлага хийж эхэлсэн юм. Энэ тухайд тэрээр "Монголын цэрэг НҮБ-ын мандаттай болоод

ачаалалтай ажиллаж байлаа. Монгол Улсын гадаад улс төрийн харилцааны бүрэлдэхүүн хэсэг болох Батлан хамгаалах салбарын гадаад харилцааны гол зорилго нь улс үндэснийхээ аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх юм. Түүнээс гадна цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, Батлан хамгаалах, гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэх, олон улсын хэмжээнд Монгол Улс, Зэвсэгт хүчнийхээ нэр хүндийг өргөх, байр суурийг бэхжүүлэх, бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулах, салбарын хөгжилд гадаад хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх, эдгээрийн эрх зүйн үндсийг бүрдүүлэх явдал.

Миний хувьд ажиллах хугацаандаа гадаад харилцаа, мэдээллийн албаны эрх зүйн үндэс болсон хуулийн төслүүдийг боловсруулан батлуулахаас гадна Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, цэргийн хамтын ажиллагааны үндсэн чиглэл, Монгол Улсаас Орос, Хятад, Америк, Герман, Польш, Болгар, Украин, Казахстан, Беларусь зэрэг улстай Засгийн газар хооронд болон яам хооронд байгуулсан гэрээ хэлэлцээрүүдийг боловсруулсан. Эдгээр нь өдий хэр нь манай улсын Зэвсэгт хүчний нэрийн хуудас болж, хамтын ажиллагаа улам бүр батжиж байгаа нь тухайн үед надтай хамт мөр зэрэгцэн алба хааж байсан нөхөд, Монголын төрийн удирдлагуудын хамтарсан гавьяа байлаа.

Би амьдралынхаа 15 жилийг сурахад зориулсан. Төр намайг ийм хэмжээнд бэлдэж байж Жанжин штабын дарга хэмээх албан тушаалд томилсон хэрэг. Яагаад гэвэл цэргийн алба бол

алба хаагчийг хариуцдаг. Харин Жанжин штабын дарга бол хэдэн мянган хүнийг хариуцахын зэрэгцээ улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгааг хариуцдаг. Тийм түвшинд бэлтгэгдэж байж тухайн албыг хашдаг" хэмээн тодотгов.

Боловсрол эзэмшинэ гэдэг түүний баримталдаг гол зарчмын нэг бөгөөд бусад алба хаагчдыг сургах тал дээр эдгээр жилүүдэд ихээхэн хүчин чармайлт гаргаж, үр дүнгээ ч өгсөн биз. Учир нь түүний байнга шинийг эрэлхийлж байдаг, шинэ санаа, чиг хандлага, шинэ бүхнийг Монголын Зэвсэгт хүчинд нэвтрүүлэх юмсан гэсэн

хөдөлмөрөөрөө бусдыгаа хошуучилж, бусдадаа үлгэр болж чадсанаа төлөө орон сууц, унаа тэргээр шагнуулж байв. Энэ нь нийт цэргийн дарга, удирдагчдын үйл ажиллагааг эрчимжүүлсэн бодит ажил болж байлаа. Мөн энэ үед Монголын Зэвсэгт хүчний олон ангийг үлгэр жишээ анги болгохын төлөө уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулж, алба хаагчдын ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад анхаарал тавьж байсан юм. Түүнчлэн цэргийн алба хаагчдыг орон сууцжуулах төслүүдийг хэрэгжүүлсэн нь өнөөдөр бодит ажил болж олон мянган цэргийн алба хаагчийн нийгмийн асуудлыг шийдэх нөхцөлийн эхлэл байлаа. Энэ мэт ажил нь түүнийг шилдэг сайн зохион байгуулагч, менежер гэдгийг харуулж чадсан гэлтэй.

Тэрээр өөрийгөө хэд хэдэн удаа "Хүний тэнгэртэй, их хувьтай хүн" гэж тодотгож байсан. Учир нь Зэвсэгт хүчин хэмээх их айлд 40 гаруй жил ажиллахдаа олон сайхан цэргийн дарга нараас үлгэр дуурайл авч амьдралынхаа туршид барьж явах зарчимд суралцсан аж. Тухайлбал, анх сонсогч болдог жил ЗХЖШ-ын дарга асан, хурандаа генерал Ж.Ёндонгоос цэргийн хүн ямар байх бүхий л зарчимд суралцсан бол, хошууч генерал Р.Гаваагаас сурч мэдэхийн төлөө цэргийн хүн өөртөө хэрхэн өндөр шаардлага тавьдгийг, хошууч генерал Г.Рагчаагаас англи хэл сурах хэчнээн чухал болохыг, Л.Дамбийням багшаасаа хүн хэрхэн тэмүүлэлтэй амьдрах, эрдмийн дөртэй болох замналыг, хошууч генерал Ч.Цэрэндвагваас өдөр бүр 10 гаруй км гүйдэг зэрэг олон сайхан чанарыг өөртөө дадал болгож амьдралынхаа турш хэрэгжүүлж яваа гэнэ. Том дарга уу, эгэл нэг цэрэг байх нь ялгаагүй, хүн бүрт өөрийн гэсэн нэг давуу тал, сайн чанар байдаг.



ОХУ-ын Жанжин штабын дарга, армийн генерал Н.Е.Макаровын хамт

чин хүсэл нь Зэвсэгт хүчний офицер, ахлагч нарыг бусад орны алба хаагчидтай харьцуулж, дүйцүүлэн сургах, гадаад хэлний мэдлэг олгох талаар нэг түвшин ахиулж чадсан юм. Тэр үеэс Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдад зориулсан англи хэлний сургалтын төвүүдийг нээж, жинхэнэ утгаараа дэлхийн цэргүүдийг бэлтгэж эхэлсэн юм.

Мөн тэрээр гайхалтай менежер. Тодорхой чиглэсэн зорилго руу Зэвсэгт хүчнийг чиглүүлэн хөгжүүлэх, өөрт байгаагаас хязгаарлагдмал нөөц бололцоог зөв тооцоолон төлөвлөж, хэрэглэх, цэргийн алба хаагчдын үйл ажиллагааг бодитоор дүгнэж, манлайлагчдын хөдөлмөрийг өндөрөөр үнэлж эхэлсэн. Энэ л үед анх ангийн захирагч нар ажил

Тэр бүгдээс суралцаж, өөртөө дадал болгох нь эргээд өөрийгөө бүтээх хамгийн том сэдэл болдог гэж энэхүү эрхэм хүмүүн захиж байлаа.

Төгсгөлд нь "Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид бол дэлхийд нэрээ дуурсгаж чадсан эрхэм гавьяатай хүмүүс. Үүнийг бид хийж чадсан. Зэвсэгт хүчний өмнө хөгжлийн том, дардан зам нээлттэй байна. Тиймээс тангараг өргөсөн цэргийн алба хаагчид та бүхэн идэвх санаачилгатай байж, сайн сайхны төлөө нэгэн санаа бодлоор илүү өндөрлөгт гаргахын төлөө зүтгэх хэрэгтэй" хэмээгээд Монгол Улсын Зэвсэгт хүчний нийт алба хаагчдадаа Зэвсэгт хүчний 100 жилийн ой, Монгол цэргийн өдрийн мэндийг дэвшүүлээ.

Хошууч Д.ОЮУНГЭРЭЛ



Өвөрхангай аймгаас төрсөн генералууд

газар төсөв байдаггүй. Тухайн үед 200 гаруй сая төгрөг болж байсан. Үүнийг нь бид Зэвсэгт хүчний урсгал зардлаа хойшлуулан байж шийдвэрлүүлж явах гарцаа гаргаж байлаа. Ингэж ажиллагаа

бусад цэргийн үйл ажиллагаанд өргөн оролцдог болсон явдал бол түүхэнд арилахгүй тод мөр. Зэвсэгт хүчний гадаад харилцаа маш сайн хөгжсөн. Заримдаа хурдаа гүйцэхээргүй өндөр

онцгой хариуцлага шаарддаг алба. Энэ хариуцлагыг дагаад маш өндөр боловсрол шаарддаг. Учир нь цэргийн хамгийн бага нэгжийн дарга болох салааны захирагч нь доод тал нь 30 гаруй

Миний аав Н.Түдэв дэлхийн II дайны жилүүдэд 5 жил 6 сар цэргийн алба хаасан Хувьсалт тэмцлийн ахмад зүтгэлтэн байлаа. 1940 оны хавар 18 настайдаа цэрэгт татагдаж, мориор Ховдоос Улиастай, Хэнтий орж алдарт 6 дугаар морин бригадад халагдах хүртлээ алба хаажээ. Баруун хил будилаантай байсан он жилүүдэд Хэнтийгээс морин маршаар 2000 гаруй км замыг хаврын хатуу цагаар туулж Үенчийн Улаан үзүүрт очсон тухайгаа нүдэндээ оч бадруулан хуучилдаг сан. Хамгийн хүнд хэцүү нь Шаргын говийг туулах замдаа унаа хөсөг нь эцэх, өвөлжих, гэдэсний халдварт өвчин тархаж хэдэн арваараа амь үрэгдэх зэрэг олон бэрхшээлийг давж баруун хилээ төвхүүлэн 1945 оны намар тэндээсээ мөн л мориор Улиастай орж бэлтгэлээр халагджээ.

Би 1963 онд Ховд аймгийн Мөст сум Боорж голын хөвөөнд төрсөн. Есөн хүүхэдтэй айлын найм дахь нь. Сургуульд орох хүртлээ хөдөөгийн хүүхэд яаж өсөж бойждог билээ тэр л янзаар хурга ишигтэй тоглох, тугал бяруу эргүүлэх, аргал түлээ түүх, ус цас дөхүүлэх, хонь ямаа хариулах, бод мал эрэх, тэмээгээр нүүж Алтайн даваа давах, ирсэн гийчдийн морь аргамжих, эмээллэх, ан гөрөө хийх, сур элдэх, мал төллүүлэх зэргээр ижий аавдаа туслах гээд юу эсийг хийх билээ.

1971 онд Мөст сумынхаа сургуульд орж 1981 онд Манхан сумын 10 жилийн сургууль төгссөн. Манайх мал малын захтай, малын хөл дагаж жилийн дөрвөн улиралд нутаг сэлгэн нүүдэллэж явдаг болохоор би ихэнхдээ дотуур байранд амьдарч, тэр хэрээр харьцангуй бие даасан. Сурагч байхдаа бүх хичээлдээ жигд сайн, хажуугаар нь юм юм сонирхдог, номоос салдаггүй хүүхэд байлаа. Дунд сургуулийн 6-7 дугаар ангидаа тэр үеийн монгол романуудын ихэнхийг уншихсан, дэлхийн сонгодог зохиолын амтанд орж явлаа. Аравдугаар ангиа төгсөөд МУИС-д элсэн орж багш болно гэж мөрөөддөг байв.

1981 он гарлаа. Нэг өдөр багш нар “Монгол хүн өнөөдөр сансарт нисэх гэнэ, радио өргөн нэвтрүүлэг шөнийн 02 хүртэл ажиллах юм байна” хэмээн ярьж байхыг сонслоо. Хөдөө телевиз байхгүй. Аймгийн төв орж монгол хүн сансарт нисэхийг зурагтаар харлаа. Маргааш өглөө нь гудамжаар дүүрэн зурагт хуудас. Сансрын нисэгчийн цэрэг хувцастай, ахмад цолтой зурагнууд гоё харагдаад ер нь цэргийн хүн болох бодол төрлөө шүү. Миний нагац ах дэд хурандаа С.Дашдорж, төрсөн ах, дэд хурандаа Т.Лхагважав хоёр цэргийн хүн байсан нь ч нөлөөлсөн.

Аравдугаар ангиа төгсөөд сурлагаараа долоод жагсаж, Цэргийн сургуулийн хуваарь аваад хотод ирлээ. “1981 оны 7 дугаар сарын 1-ний өглөө БХЯ-ны Боловсон хүчний газарт бэлэн бай” гэсэн болохоор бүртгүүлэх санаатай очтол шууд машинд суулгаад цэргийн халуун ус руу, тэндээсээ Улиастайн гадаадын цэргийн карантин руу шилжүүлчихээ. Ингэж л анх байлдагчийн мөрдэс зүүсэн дээ.

Дараа нь эрүүл мэндийн үзлэгт хамрагдлаа. Офицеруудын ордонд тоо, физик, орос хэлний хичээлээр конкурс өглөө. Адестатын 15, гурван шалгалтын 45 нийлээд 60 оноо авахаас орос хэлний билетээ тааруухан хариулж 47.5 оноотой Одесса хотын Цэргийн нэгдсэн дээд сургуулийн зенит-артиллерийн командын ангийн хуваарь авлаа. Үзэсгэлэнт Хар далайн эрэгт дөрвөн жил суралцсан он жилүүд амьдралын минь сайхан дурсамжуудын нэгээхэн хэсэг болж үлдсэн. Тэнд 1981-1988 онд сурч төгсөхдөө олон арван хөвгүүдтэй үерхэж нөхөрлөж явсан бөгөөд тэдний дундаас хожим нь цөөнгүй шилдэг дарга нар тодрон гарсан байдаг. Хушууч генерал А.Ганбат, Р.Хушбат, бригадын генерал Х.Даваацэрэн, П.Жаргалан, О.Энхбаяр, хурандаа н.Бор, н.Батаа, Ч.Баттулга, Ш.Энхбат, Ж.Алтангэрэл, Д.Батсуурь зэрэг дарга нарыг нэрлэж болно.

1985 онд төгсөж ирээд БХЯ-ны коллегийн хурлаас дэслэгч цол авч, Ардын Армийн 138 дугаар ангийн Зенитийн пуужинг-артиллерийн батареины захирагчийн техникийн орлогчоор томилогдлоо. Улмаар салбарын

захирагч, албаны дарга, пуужингийн инженер, аймгийн Цэргийн штабын даргын албан тушаалд томилогдож 37 жил тасралтгүй батлан хамгаалах салбарт ажилласан байна. Аливаа анхны юм бүхэн содон бөгөөд дурсгалтай. Анх ажлын гараагаа эхэлсэн анги маань 1993 онд бүтцийн өөрчлөлтөд орсон ч танкийн хорооны хамт олон одоо ч холбоотой мэнд усаа мэдэлцэж явдаг нь сайхан.

Их говийн гарнизонд найман жил алба хаахдаа залуу насны эрчээр нэлээд ачаалалтай ажиллаж байж дээ. Тухайн цаг

байх, аливаа эд ангиудыг задалж угсрах, чадварлаг жолоодох шаардлага гарна. Зэвсгийн бэлэн байдлыг хангаж өндөр цэцтэй байлгахын тулд түүний бүтэц, ажиллах зарчим, сумны төрөл, агаарын даралт, цаг уурын байдлыг нарийн мэдэх хэрэгтэй. Пуужинг аюулгүй харвахын тулд харвах механизм, харвах суурь, байлдааны пуужингаа шалгах, засварлах, техникийн үйлчилгээг цаг тухайд нь хийж тэмдэглэл хөтлөх нь зайлшгүй.

Нисэх онгоц, нисдэг тэрэг илрүүлж байрлал, хөдөлгөөнийг нь хянаж тэмцэл явуулахын тулд

урт дараалалд зогсож, олон залуу ганзагын наймаанд мордлоо.

Шинэ Үндсэн хуульд нийцүүлэн Батлан хамгаалах багц хуулиуд ар араасаа батлагдан гарлаа. Түүнийг хэрэгжүүлэх нөр их үүрэг хариуцлага бидний үеийнхний нуруунд буулаа. Алхам тутамд саад бэрхшээл, байхгүйн зовлон тулгарч байсан ч бид бууж өгөөгүй юм. 1990-2000 оны будилаантай цаг үед Зэвсэгт хүчний ачааны хүндийг манай үеийнхэн үүрч гарсан. 1992 оны намар шинээр эмхлэн байгуулагдсан 318 дугаар ангид шилжиж ирлээ. Ингээд миний “их

стратегийн дамжааг дүүргэлээ. Хүн цаг үргэлж суралцаж өөрийгөө хөгжүүлэх нь цаг үеэсээ хоцрохгүй байх шалгарсан арга юм. “Хүн ямар нэгэн юмыг тухайн цагт нь сураад авчих хэрэгтэй, хэзээ нэгэн цагт хэрэг болдог” гэж аав минь захиж байсныг би өр мартдаггүй.

2015 онд Хэнтий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын сургалтын офицерын албан тушаалд томилогдлоо. Нүүдэл үргэлжилсээр. Хэчнээн ч удаа нүүсэн юм бэ дээ. Нүүдэл бүрийн араас байр орон сууц, гэр бүлийн хүний ажил, хүүхдүүдийн сургууль

Т.Баяраа: БИ ӨНӨӨДРӨӨРӨӨ БАЙХЫГ ИЛҮҮД ҮЗДЭГ



үед анги, салбарууд байлдааны цагийн орон тоогоор бүрэн хангагдсан, цэргийн алба хаах хугацаа гурван жил, байнгын бэлэн байдлыг хангахад өндөр шаардлага тавьдаг байв. Манай салбар сүүлийн үеийн зэвсэглэл техниктэй, бэлэн байдлын хувьд бусдаас онцгой, 50 шахам түрүүч байлдагчтай, 20 шахам офицер, ахлагчтай томоохон нэгж байлаа. Манай батареины хамт олны дундаас Д.Отгон-Ерөөлт, Г.Ганзориг нарын хурандаа цолтон гурав төржээ. Жилийн дөрвөн улиралд хээрийн дадлага, сургууль, буудлага, харвалтад гарч Зүүнбаян-Налайх, Зүүнбаян-Чойрын чиглэлд газраар болон төмөр замаар зэвсэг, техникээ тээвэрлэж явахад техникийн бэлэн байдал хамгаас чухал. Зүүнбаянгаас Хонхор өртөөн дээр гурван есийн жавар тачигнасан үүрээр ирээд, тэс хөлдүү авто хуягт техникийг асаах, буулгахад юм бодогдуулдаг л юм.

1986 онд Ардын хувьсгалын 65 жилийн ойн баярын техникийн парадад “Шильк”, “Стрела-1м”-ээ Зүүнбаянгаас төмөр замаар тээвэрлэн ирж оролцлоо. Сүхбаатарын талбайд 20 хонго өдөр шөнөгүй бэлтгэсэн. 11-ний өглөө парадын дараа техникээ парклаад баяр үзэх ухааны юм бодож байтал “Амгалангийн цэргийн зам дээр платформ тавигдсан байгаа шууд ачаалаад Зүүнбаян гар” гэдэг байгаа. Тушаал бол тушаал. Наадмын өдрүүдэд Чойр, Сайншандын замын өртөөнүүд дээр л өнжиж хонож явлаа. Манай зенитчдийн хээрийн гаралт дандаа Цагаан сар, Эмэгтэйчүүдийн баярын үеэр таарч, хэд хэдэн жил хээр байж дээ.

Ахлах даргын өгсөн үүрэг цэргийн хүнд хууль, өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь яв цав биелүүлэх нь миний ерөнхий зарчим байв. Манай дарга нар тэгж төлөвшүүлсэн, тийм байдлаар доод албан тушаалтнаа шаардаж шахдаг байсан. Өнөөдөр бол өчигдөр, маргаашийн холбоос тул би өнөөдрөөрөө байхыг илүүд үздэг.

Миний үндсэн мэргэжил зенитчин, радиотехник, радиолокацын станцын ашиглалтын инженер. Салбарын зэвсэглэл техникийн бүтэц, албан тушаалын үүрэг, орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, техник, технологийн дэвшлээс хамаарч өөрийгөө хөгжүүлэх, бүр илүү ихийг судлах шаардлага байнга гарч байдаг тул өөртэйгээ ажиллах нь өнөө цагийн залуу дарга нарын эн тэргүүний зорилго байх хэрэгтэй. Авто хуягт техникийн бэлэн байдлыг хангахын тулд жолооч механик нартайгаа ойр

радиолокацын станц бүрэн хүчин чадлаараа ажиллаж эрэлтийн оператор хэд хэдэн онгоцны өгөгдөхүүнийг зэрэг уншиж, планшейтчин түүнийг планшейт дээр алдаагүй буулгах хэрэгтэй. Ийм байхын тулд Налайх, Чойрт байрлах Зөвлөлтийн нисэх хүчний ангиудыг бараадаж тэдний нислэгийг ашиглан дадлага сургууль явуулж, толин эргэлтийн буудлага, нам өндрийн пуужингийн харвалтыг хэд хэдэн удаа хийсэн.

Идэр есийн хүйтэнд түгшүүр зарлахад манай салбар 30 минутын дотор 16 нэгж техникээ асаагаад, бүх буу аранзаа агсаад байнгын байрлалаа орхиод цуваа татаж марш эхлүүлэхэд бэлэн болдог байлаа. Ингэхийн тулд хамт олны гар нийлэмжтэй, нэг нэгнийгээ орлож ажиллах чадвар дадлага чухал юм. Тэр бүхнийг манай хамт олон амжилттай гүйцэтгэж, жил дараалан онц, сайн салбараар шалгарч, тавигдсан үүргийг нэр төртэй биелүүлж ирсэн.

1989 он гарч дэлхийн улс орнуудад өрнөсөн үйл явдал манайд ч нөлөөлж армийн бүтцэд өөрчлөлт орж цомхотгол хийгдлээ. Нийгэм өөрчлөгдөж зах зээлийн эдийн засагт шилжин Монголд байрлаж байсан Зөвлөлтийн анги, салбарууд ээлж дараалан буцлаа. Эдийн засгийн хүндрэлийн улмаас тэдний тохилог хотхонуудыг өөд

нүүдэл” эхэллээ. Өмнөх нийгмийн үед байсан бүх зүйл 20 дугаар тогтоолтой хамт алга болов. 1993 онд Ховд дахь Зэвсэгт хүчний 123 дугаар ангид очиж Радиолокацын станцын салбар шинээр байгуулах ажлыг зохион байгууллаа. Арай гэж төвхнөж байтал Баян-Өлгий аймгийн Улаанхус суманд шилжин байрлах шийдвэр гарлаа. Энэ удаад тийшээ биш буцаад хот руу нүүх саналаа өгөв.

1996 онд эргээд 318 дугаар ангид дахь шилжин ирж, Пуужинг-артиллерийн Зэвсгийн албаны дарга, пуужингийн инженерийн албыг хашлаа. Зэвсэгт хүчний амьдрал, ажил үйлс өдрөөс өдөрт өөдлөн дэвжиж байгаа нь илт. Манай залуучууд олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцож Монголынхоо нэрийг дэлхийн түвшинд гаргалаа.

2002 онд анги бүтцийн өөрчлөлтөд орж татан буугдав. Дахиад л нүүдэл. Бүх зэвсэглэл, техник, сум галт хэрэгслээ хүлээлгэж өгөөд Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын тоо бүртгэл, нөхөн хангалтын офицерын албан тушаалд томилогдов. Энэ удаагийн албан тушаал тэс өөр. Орон нутагт батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах, хэрэгжүүлэх ажил бол Цэргийн штабын бүрэлдэхүүний үндсэн үүрэг. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд аймгийн бүх сумаар явж холбогдох албан тушаалтан, иргэдтэй уулзах, газар нутгаа бүрэн судлах, цэргийн бүртгэлийг цахим санд бүрэн оруулахын тулд цаг наргүй ажиллаж компьютерын бүх программ дээр бичиг баримт боловсруулах, нууцын горим сахиж, байгууллагын дотоод сүлжээ, интернэт, тоног хэрэгслийг ашиглаж сурах хэрэгтэй болов.

Цэргийн бүртгэл, татлага зохион байгуулах, шат шатны сургалт, дайчилгааны тодотгол хийх, иргэн-цэргийн харилцааг хөгжүүлэх, хүүхэд, залуучуудад эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх, орон нутгийн хамгаалалтын тогтолцоо бий болгох, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэх гээд олон ажил ар араасаа цуварна. Сонгууль бүрийн дараа шинээр томилогдсон албан тушаалтнуудыг сургалтад

Хүн цаг үргэлж суралцаж өөрийгөө хөгжүүлэх нь цаг үеэсээ хоцрохгүй байх шалгарсан арга юм. “Хүн ямар нэгэн юмыг тухайн цагт нь сураад авчих хэрэгтэй, хэзээ нэгэн цагт хэрэг болдог” гэж аав минь захиж байсныг би өр мартдаггүй.

хамруулна. Гарын авлага, унших судлах материал бэлтгэнэ, цэргийн мэргэжлийн удирдлагаар хангаж, шахаж шаардана.

Дээрх ажлыг амжуулахын зэрэгцээ Төрийн захиргааны удирдлагын академий төгслөө. Төрийн захиргааны байгууллагад ажиллаж төрийн жинхэнэ албан хаагчидтай ажиллахын тулд олон хууль судлах шаардлагатай болов. Батлан хамгаалах асуудлыг дараагийн түвшинд боловсруулах мэдлэг, чадвартай болохын тулд Батлан хамгаалах удирдлагын академийн

соёлын асуудал дагаад “нүүж явдаг”. Энэ бүхэнд цэргийн хүн эртнээс бэлтгэлтэй байх хэрэгтэй.

Манай гэр бүлийн хүн Л.Энхцэцэг бид хоёр нэг голынх. Завхан аймгийн Худалдааны техникум төгсөөд Төв аймгийн худалдааны трест, Зүүнбаянгийн Цэргийн худалдааны трестэд ажиллаж байсан. Нүүдэл дагаад, янз бүрийн ажил хийж үр хүүхдээ өсгөн, бат бэх ар тал минь болж явсны ачаар би гэдэг хүн өдий зэрэгт хүрсэн. Харин орон сууцны асуудал бол шийдэх амаргүй. 1985 онд нэг өргөдөл өгсөн, тэр нь хаа ч үдээтэй байдаг юм бүү мэд. 2013 онд дахин нэг хүсэлт гаргасан ч таг чиг.

2017 онд Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын даргын албан тушаалд томилогдлоо. Сэлэнгэ аймаг ажиллаж байсан он жилүүдэд манай аймаг, Тамгын газрын хамт олон ажил үйлсээрээ шалгаран тэргүүний болж, улсад найман удаа нэг, хоёрдугаар байранд шалгарсан байдаг. Зэвсэгт хүчний эгнээнд олон жил ажиллахад олон ч сайхан дурсамж үлджээ. Тэр бүхнийг тоочвол нэлээд цаг цаас зарна биз. Тэндээс Зүүнбаян, Сэлэнгэд ажиллаж амьдарч байсан үе хүндтэй байрыг эзэлдэг юм.

Би сурагч цагаасаа номд дурдсан утга зохиол сонирхдог байсан болоод ч тэр үү сонсогч байхаасаа эрээчиж эхэлсэн. Монгол орныхоо баруун, зүүн, өмнөд, хойд хязгаарт ажиллаж амьдарч, бүх аймгийн нутгаар явж үзсэн болохоор очсон газар нутгийнхаа тухай нийтлэл, дуу шүлэг бичих дуртай. “Зүрх рүү урссан аялгуу” шүлгийн түүвэрээ хэвлэлтэд бэлэн болгосон бол одоо “Үүлнээс өндөр нутаг”, “Шатрын хөгжлийн хатуу хуулиар” ном дээрээ ажиллаж байна.

Хэнтий нутгаар хөндлөн гулд явахдаа дөрвөн мөрт бичсэнийг гавьяат Ц.Түвшинтөгс үзээд “Энэ чинь сайхан дуу болох юм байна” гээд Хан Хэнтий чуулгын хөгжмийн багш Бя.Энхбаярт өгснөөр “Амар мэндийн дуу” төрсөн юм. Сэлэнгэ аймгийн Орхон сумын Соёлын төвийн дарга О.Батдоржтой хамтран “Мөнх тэнгэрийн харуул”, “Үүлнээс өндөр нутаг минийх”, “Хүлээлтэй дуу” дуугаа ч бичлээ.

Би өр нь бүх төрлийн тоглоом, шатар, шагай, хөзөр, даалуу, хорол тоглох дуртай, тэшүүрээр гулгаж, ууланд алхаж, сагс, гар бөмбөг хөөх сонирхолтой. Гурван настай байхад аав надад шатрын нүүдэл зааж байлаа. Ээжтэй шатар тоглохоор ээж бодож бодож нэг нүүдэг, тэр нь надад залуутай санагддаг, тэгсээр байгаад би хожигддог байж билээ. Эртнээс уламжлагдан ирсэн шагайн тойромд очиж, харваачидтай зэрэгцэн суугаад уухайн дуу сонсож, сум тавьж суух ч зүгээр шүү.

Аймгийн ЗДТГ-аас тэтгэвэрт гарсан ахмадуудыг нэгтгэж “Түшээ тулга” төрийн бус байгууллага байгууллаа. Ажил амьдралын арвин их туршлагатай тэднийг залуу үетэйгээ холбоотой байхыг бодсон хэрэг. 2019 онд “Бэлт-Боорж” ХХК үүсгэн байгуулж, гүйцэтгэх захирлаар нь ажиллаж байгаа ч олныг хамарсан хөл хорионы үеийг эрсдэл багатай давах тухайд бодол оюунаа чилээж явна. Ер нь цэргийн байгууллагад ажиллаж байх явцдаа энгийн амьдралд шилжих бэлтгэлээ хангаж ямар нэгэн мэргэжил эзэмших хэрэгтэй гэдгийг нийт уншигчдадаа захъя.



Бид яагаад Манлайбаатар Ж.Дамдинсүрэн гэдэг хүнийг Монгол Улсын тусгаар тогтнолын төлөөх тууштай тэмцэгчдийн нэг хэмээн нэрлэх болсон бэ?

-Монгол Улсын тусгаар тогтнолыг авчрахад олон шилдэг удирдагч нөлөө үзүүлсэн гэдгийг хүн бүр мэднэ. Тэгэхдээ Манлайбаатар Ж.Дамдинсүрэн тэдгээр удирдагчдаас тусгаар тогтнолын үнэ цэнийг илүү өндөрт өргөж чадсан төрмөл жанжин байсныг түүх гэрчилнэ. Тэрээр 1871 онд Хөлөнбуйрын Шинэ Барга Зүүн гар Шулуун цагаан хошууны нутаг "Цагаан хошуу" хэмээх газар (өнөөгийн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Шинэ Барга Зүүн хошуу)-ын Хүйцэлэг овгийн Өлзийн Жамсрангийн гурав дахь хөвгүүн болон мэндэлсэн. Эцэг, эх нь түүнийг 7-8 настайд нь гэрийн багшаар монгол, манж бичиг заалгасан бөгөөд тэрээр 14 настайдаа Шинэ Барга Зүүн гарын Бүгдийн даргын яамны монгол, манж үсгийн туслах бичээчээр ажиллах болжээ. Улмаар 18 настайдаа хуяг цэрэг болж, цэргийн эрдэмд суралцсан бол 20 настайдаа Бүгдийн даргын яамны орлон бичээч, жинхэнэ бичээч, тэргүүн бичээчийн албанд тус тус дэвшин ажиллаж байгаад 39 насандаа сумын занги болжээ. Тэр цагийн хууль ёсны дагуу сумын занги болмогц Манжийн эзэн хаанд бараалхдаг байж.

Тэр уламжлалаар Ж.Дамдинсүрэн Бээжин хотод очиж үеэрээ Халхын Түшээт хан аймгийн Чин ван Ханддоржтой танилцан монгол үндэстэн эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэх цаг болж байгаа тухай ярилцан, санаа сэтгэл нэгдсэн талаар түүхийн сурвалжид бий. Монголчууд 1911 оны 12 дугаар сарын 29-нд Манжийн ноёрхлыг устган, Богд Жавзандамбыг хаанд өргөмжилж, тусгаар тогтнолоо сэргээн тунхагласнаар монгол үндэстнүүд эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэлд босов. Дараахан нь буюу 1912 оны 1 дүгээр сарын 15-нд Хөлөнбуйрын монголчууд манж, хятад түшмэд, цэргийг нутгаасаа хөөн гаргаж, газар орноо эзлэн авсан. Энэ тэмцэлд идэвхтэй оролцон, удирдсан хүний нэг нь сумын занги Ж.Дамдинсүрэн байв.

Баргын ноёдын хурлаас тусгаар тогтносон Монгол Улстайгаа нэгдэхээр шийдвэрлэж, сумын занги Ж.Дамдинсүрэн, түшмэл Пунцаг, бичээч Гайхасу нарын долоон хүнийг хүсэлт бичгийн хамт Нийслэл Хүрээ рүү илгээсэн байна. Тухайн үед Богд хаан Хөлөнбуйрын монголчуудын хүсэлтийг ёсоор болгон, тулгар төрд хүчин зүтгэхээр ирсэн занги Ж.Дамдинсүрэнд Улсад туслагч гүнгийн зэрэг олгож, Гадаад Хэргийг Бүгд Эрхлэн Шийтгэгч Яамны дэд сайдаар томилжээ. Энэ үеэс Ж.Дамдинсүрэнгийн үлс төр, цэргийн үйл ажиллагаа эрчимжиж, Баргын эрх чөлөөний төлөө тэмцэгчээс нийт монгол үндэстний эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалан тэмцэгч болох их үйл хэргэ эхэлсэн гэж үздэг.

Манлайбаатар Ж.Дамдинсүрэнгийн Монголын түүхэнд оруулсан гол хувь нэмэр юу вэ?

-Монголын түүхэнд оруулсан түүний хувь нэмрийг гурван хэсэгт хувааж үзье. Нэгдүгээрт, Манлайбаатар Ж.Дамдинсүрэн бол жинхэнэ монгол цэргийн домогт жанжны замналаар амьдарсан. Учир нь тэрээр ХХ зууны монгол цэргийн түүхэнд томоохон байр суурь эзэлдэг хоёр том байлдааныг удирдсаны эхнийх нь Ховд хотыг Манж-Хятадын цэргээс чөлөөлсөн 1912 оны байлдаан юм. Тус байлдаанд харийн түрэмгийллээс чөлөөлөх уриалга гаргахад 3000 орчим монгол цэрэг нэгдэж, улмаар Ховд хотыг чөлөөлсөн

байдаг. Энэ байлдаан бол Монгол орон Манжийн эрхшээлд орсноос хойш 200 гаруй жилийн дараа болсон анхны томоохон байлдаан бөгөөд Монгол Улсын тусгаар тогтнолыг баталгаажуулсан чухал үйл явдал болсон. Богд хааны зарлигаар Ховдыг чөлөөлөх байлдааныг удирдсан С.Магсаржавт Хатанбаатар цол, үе улиран залгамжлах бэйсийн хэргэм, хоёр нүдний тогосын отго, хүрэн жолоо, Ж.Дамдинсүрэнд үе улиран залгамжлах засаг төрийн бэйлийн хэргэм, хоёр нүдний тогосын отго, Манлайбаатар буюу анхны Цэргийн жанжин цолоор шагнажээ.

Хоёр дахь нь Өвөр Монголыг чөлөөлөх "Таван замын байлдаан" юм. 1913 оны 7 дугаар сарын 1-нд Манлайбаатар Ж.Дамдинсүрэнг өмнө зүгийн хязгаарыг захирагч жанжнаар томилж тэр үеэс эхлэн Өвөр Монголыг чөлөөлөх байлдааныг удирдсан. Энэ байлдаан цаг хугацааны хувьд жил шахам үргэлжилсэн, газар нутгийн хувьд Өвөр Монголын өргөн уудам тал нутгийг хамарсан учир байлдаан гэхээсээ илүү дайн байсан хэмээн сүүлийн үед судлаачид үзэж байна. Энэ үйл явдлын гол үр дүн нь Монголын тусгаар тогтнол, монгол цэрэг эрсийн байлдах чадвар, хүч чадлыг үл тоон басамжилж байсан Бээжингийн эрх баригчдад томоохон цохилт, сануулга өгч, Монголыг цэргийн хүчээр эзлэн захирах боломжгүйг харуулан, тэднийг аргагүйн эрхэнд хэлэлцээр хийхэд хүргэсэн юм. Тиймээс Манлайбаатар Ж.Дамдинсүрэн яахын аргагүй домогт цэргийн жанжин мөн.

Хоёрдугаарт, тэр бээр Монгол төрийн гадаад харилцааг хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулсан ХХ зууны Монголын анхны дипломатчидын нэг гэдгээрээ алдартай. Тэрээр 1913 онд байгуулагдсан Монгол, Төвөдийн гэрээнд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн оролцож, 1914 оны Монгол, Орос, Хятад гурван улсын хэлэлцээрт Монгол Улсын төлөөлөгчдийн зөвлөхөөр оролцож байсан. Монгол, Төвөдийн гэрээ бол шинээр тусгаар тогтносон хоёр улс бие биеэ хүлээн зөвшөөрч, аливаа аюул занал тохиолдвоос харилцан тусалцах үүрэг хүлээн, холбоотны харилцаа тогтоосон олон улсын эрх зүйн баримт бичиг байсан юм. Монгол Улсаас гадаад улстай байгуулсан анхны олон улсын эрх зүйн баримт бичигт Ж.Дамдинсүрэнгийн гарын үсэг мөнхрөн үлдсэн нь Монгол Улсын гадаад харилцааны түүхэнд түүний гүйцэтгэсэн үүрэг, эзлэх байр суурийг илэрхийлэн харуулах баримт болж үлдсэн.

Гуравдугаарт, тэр бээр монгол цэргийн шинэчлэлийн үзэл санааны анхдагч байсан. Манлайбаатар Ж.Дамдинсүрэн нь Монгол Улсын нийгэм, эдийн засаг, цэрэг, аж ахуй, хууль цаазыг шинэчлэн хөгжүүлэх тухай бодрол бичгийг 1912, 1913 онд Богд хаанд өргөн барьж, улс төр, эдийн засаг, эрдэм боловсрол, гадаад харилцааг хөгжүүлэх, цэргийн болон хууль эрх зүйн шинэчлэл хийх, орон нутгийг засан тохинуулж, ард олны амьдрал ахуйг сайжруулах талаар тодорхой саналууд дэвшүүлсэн байдаг нь сонирхол татдаг.

Манлайбаатар цэргүүдэд удирдан зохион байгуулах талд ямар тактик ашигладаг байсан бэ? Тулааны стратеги нь өрсөлдөгчөөсөө юугаараа илүү байв?

-Түүний цэрэг зохион байгуулах гол онцлог нь маш хатуу сахилга бат байсан гэж үздэг. Тэр бээр өөрөө хууль дүрэм гаргаж байсан. Жишээ дурдахад, дайснаасаа айж болохгүй, удирдлагын зааваргүйгээр ухарч болохгүй зэргээр цэргүүддээ байлдаанд орохоос нь өмнө сануулга өгнө. Хэрвээ зөрчөөл

тодорхой ял шийтгэл онооно гэх жишээтэй. Ухарсан, айж мэгдсэн цэргүүдийг барьж шийтгэдэг тусгай хүмүүсийг хүртэл томилгоожуулдаг байсан нь энэ хүний цэрэг удирдан зохион байгуулах чадвар ямар өндөр түвшинд байсныг харуулдаг.

Ер нь ХХ зууны эхэн үеийн дайн байлдаанд монгол цэргүүд ямагт өөрсдөөсөө хэд дахин давуу хүчтэй тулгардаг байсан. Тиймээс тэр үеийн цэргийн жанжид ХХ зууны монголчуудын байлдааны арга ухааныг ашигладаг байсан нь батлагдсан. Жишээ нь, "Галзуу барын дайралт", "Хорт могойн оролт" зэрэг байлдааны тактикийг ашиглаж байсан талаар өөрсдийн дурсамжид тэмдэглэн үлдээсэн. Мөн дайснаа гэнэдүүлэх, хууран мэхлэх, морьт цэргийн хурд хүчээр гайхуулах зэрэг арга тактикийг ашигладаг байж. Дээрээс нь байлдах бүрдээ ялдаг нэг чухал гаргалгаа нь дайсныхаа зүрхээр тугаа тахидаг байсан явдал гэж түүхэн сурвалжид тэмдэглэсэн нь бий. Энэ бол цэргүүдээ зоригжуулж дайны ялалтад хөтлөх сэтгэл зүйг бэлддэг ач холбогдолтой байсан хэрэг.

Ямар зан чанартай хүн байсан бэ?

-Манлайбаатарын удирдлага дор цэрэг байсан эсвэл түүнийг харж байсан хүмүүсийн бичиж тэмдэглэсэн сурвалжаас үзэхэд, Ж.Дамдинсүрэн бол маш эр зоригтой, хурц ширүүн, чанга хатуу, өөртөө итгэлтэй, эрэмгий нэгэн байжээ. Мөн тухайн үеийн ноёд харьяат ардаа дарладаг, эзэрхдэг тэрхүү нийгмийг шүүмжилдэг нэгэн байсан нь түүнийг хэр шударга зан чанартайг илтгэн харуулна. Мэдээж шударга, эрэмгий, зоригтой хүн байсан учир цэргүүдийнхээ итгэлийг хүлээж, тууштай эх оронч гэж цоллогдоход хүргэсэн.

Түүний Хятадын шоронд босоогоороо нас нөгчсөн талаарх түүх олон хүнийг эмзэглүүлдэг ч жинхэнэ эх оронч хүн ямар байх ёстойг мэдрүүлдэг гэж боддог. Энэ тухайд та юу хэлэх вэ?

-Манлайбаатарын Хятадын шоронд босоогоороо нас нөгчсөн нь хэн нэгний зохиосон түүх биш. Энэ бол бодит түүх юм шүү гэдгийг юуны өмнө хэлмээр байна. Тэр ч бүү хэл Маршал Х.Чойбалсан 1945 онд Ж.Дамдинсүрэнгийн түүхийг бичих асуудлаар тухайн үеийн Шинжлэх ухааны академийн захирал Н.Дүгсүрэн гэдэг хүнтэй уулзахдаа онцлон хэлсэн байдаг. Сурвалжуудад тэмдэглэсэнээр Манлайбаатар шоронд байхдаа "Би энэ хятадуудын дунд хэвтээгээрээ үхэхгүй. Намайг хана түшүүлээд аль. Хэрэв эндээс амьд гардаг юм бол Маймаа (Амгаланбаатар) хотоос Бээжин хүртэл хүйс тэмтэрнэ" гэж хэлээд ханаа түшсэн чигээрээ амьсгал хураасан байдаг. Эцсийн амьсгалаа хураатал эх орныхоо тусгаар тогтнолын төлөөх тэмцлээ үргэлжлүүлж байсан гэдгээрээ гайхамшигтай. Нас барсных нь дараа нутгийн ард иргэд шарилыг нь шоронгоос нууцаар гарган Үүлэнхан уулын Шинэбулаг гэдэг газар оршуулсан. Тэр газар нь одоогийн Дорнод аймгийн Гурванзагал сумын нутагт бий. Судлаачийн хувиар дүгнэхэд, жинхэнэ эх оронч гэж ямар хүн байдгийг Манлайбаатар Ж.Дамдинсүрэнгийн түүхээс бэлхнээ харж болно.

Өнөө цагт энэхүү түүхэн хүнтэй холбоотой эд өлгийн зүйлсээс юу өвлөгдөж ирвэ?

-Эд өлгийн зүйлс гэвэл Монголын үндэсний музейд түүний малгай, буу зэрэг хадгалагддаг бол Монгол цэргийн музейд хаш тольтой суран бүс, Дорнод аймгийн музейд Манлайбаатарын хошууны туг бий. Ер нь түүнтэй холбоотой архивын баримт бичиг түүхэн сурвалж Монголын үндэсний төв архивд маш их байдаг. Жишээ нь, өөрийнх нь бичсэн бодрол бичиг, Өвөр Монголд байлдаж байхдаа

Г.Мягмарсамбуу: МАНЛАЙБААТАР Ж.ДАМДИНСҮРЭН ЭЦСИЙН АМЬСГАЛАА ХУРААТЛАА ТУСГААР ТОГТНОЛЫН ТӨЛӨӨХ ТЭМЦЛЭЭ ҮРГЭЛЖЛҮҮЛСЭН

Монголын эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэгчдийн нэг, Богд хаант Монгол Улсын цэргийн жанжин, Манлайбаатар Жамсрангийн Дамдинсүрэнгийн мэндэлсний 150 жилийн ой энэ онд тохиож байна. Эл түүхэн үйл явдалтай уялдуулан ШУА-ийн Түүх, угсаатан судлалын хүрээлэнгийн салбарын эрхлэгч доктор, профессор, бэлтгэл хурандаа Г.МЯГМАРСАМБУУТАЙ ярилцлаа.



Зүүн гар талын хоёр дахь хүнээс: Хорчин хошууны, Жирмийн чуулганы Ерөөлт ван Раашминжүүр, Манлайбаатар Жамсрангийн Дамдинсүрэн, Жирмийн чуулганы Горлос хошууны Энхбилэгтийн Тогтох тайж, Азийн морин дивизийн адууг маллагч Богд хаант Монгол Улсын түшмэл Жамбалон, Халхын хэцүү То вангийн ач төрийн Жүн ван Манжбазарын Доржпалам, Өвөрлөгч ван Цагаанхүүгийн Пунцагравдан нар. 1916 он



Манлайбаатар Ж.Дамдинсүрэн өөрийн амь сахигч хоёр солоон баргын хамт



Манлайбаатар Ж.Дамдинсүрэн

Богд хаан, Халхын Сайн ноён хан Т.Намансүрэн нарт бичсэн захидал зэрэг нь хадгалагддаг. Хөшөө дурсгал гэвэл Дорнод аймгийн Гурванзагал суманд 1971 онд түүний хөшөө босгосон. Энэ нь Манлайбаатарын цор ганц хөшөө юм. Эд өлгийн зүйлсээс илүүтэйгээр Манлайбаатарын хөлсөн хэд хэдэн үгс хойчийн залууст маш том үлгэр дуурайлал болж чадахуйц санагддаг. Жишээ нь "Төр улсын хэргийг амьд хүмүүс хөдөлгөдөг авч тогтсон суурь нь амь бие хайргүй зүтгэж, үхэж үргэдэгсдийн яс, чөмгөн дээр тогтодог юм" гэдэг түүний хэлсэн гайхамшигтай үг үүний нотолгоо мөн. Аливаа хүн үхэж үргэдэвч үйл хэрэг нь мөнх оршдог гэсэн нэгэн санаа, төр улсыг удирдан залж буй хүмүүс түүхэн уламжлалаа эргэн санаж байх учиртай гэсэн бас нэг санаа, ерөөс аливаа юмс үзэгдэл өмнөх уламжлалдаа суурилж, өнөөг дамжин ирээдүй өөд хөгжин дэвждэг гэсэн гүн ухааны үзлийг Дамдинсүрэн дээрх үгэндээ товч бөгөөд тодорхой, уран яруу томьёолон хэлсэн нь түүхийн сонирхолтой баримт болон үлджээ.

Манлайбаатарын гурван хүү хэлмэгдүүлэлтийн үед цаазлагдсан байдаг. Яагаад энэ хүний үр удмыг "хавчих" болов?

-Ер нь улс төрийн хэлмэгдүүлэлтэд ихэвчлэн Монгол үндэстнийг нэгдсэн тусгаар улс болгоход тууштай хүчин зүтгэсэн монголчууд, Орос Улсын тулалцаагүйгээр өөрсдийн улсаа удирдан жолоодох ёстой гэсэн үзэл санааг гаргаж байсан төрийн зүтгэлтнүүд болон тэдгээрийн үр удмыг хамруулж байсан.

Манлайбаатар Ж.Дамдинсүрэн энэ үйл хэргийг манлайлагчдын нэг байсан болохоор түүний гурван хүүгийн хоёрт нь цаазын ял оноосон бол нэг нь ор сураггүй алга болсон гэдэг. Харин том хүү Д.Долсонгийн охин Д.Ламжав гэдэг хөгшин одоо амьд сэрүүн бий.

Ер нь тухайн үеийн цэргийн удирдагч нарын үзэл санаанаас маш хүчтэй эх оронч зан чанар ажиглагддаг. Тэгвэл орчин үеийн залуус голдуу гадаад оронд амьдрахаар сэтгэл шулуудаж байна. Энэ нь эргээд бидний өвөг дээдсээс үлдээсэн эх оронч сэтгэлгээнд хэр харшилдаг гэж та боддог вэ?

-Харшлахын дээдээр харшилж байна. Эх орончдын амиа зориулан байж хамгаалсан газар шороо, байгалийн баялгийг гадаадад худалдана чинээ хэн санах билээ. Тэгэхээр энэ хоёр зүйлийг харьцуулшгүй эсрэг зүйлс болж хувирна. Монголын төрийн түшээдийн мөс чанар хэр их өөрчлөгдөж байгааг үүнээс харж болно. Монгол орны хойч ирээдүй болсон залуус эх орноосоо дайжихад хүрч байна. Энэ хамгийн буруу зүйл. Тусгаар тогтнол, эх орны үнэ цэн одоо үед үнэгүй шахуу болсон байна. Тиймээс залууст хандаж хэлэхэд, өнгөрсөн түүхээ бид хэнээс ч илүү мэддэг байх хэрэгтэй. Тусгаар тогтнол гэж юу байдаг, эх орны үнэ цэн гэж чухам юуг хэлж байгааг бага ч гэсэн ойлгох хэрэгтэй. Бидэнд боловсрол хамгийн чухал мэтээр ярьдаг. Гэтэл эх орноо гэсэн ухамсар үгүй бол би боловсон хүн гэж цээжээ хэчнээн дэлдээд ямар ч нэмэргүй.

Дэд ахлагч Т.ИДЭР



ЗЭВСЭГТ ХҮЧИН-100 ЖИЛ

МОНГОЛЫН ЗЭВСЭГТ ХҮЧИН БҮХ НИЙТЭЭРЭЭ БИЧИГ ҮСЭГТ СУРАЛЦСАН НЬ

БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн дарга, доктор (Ph.D), хошууч Т.СҮХБААТАР

Монгол оронд 1921 онд өрнөсөн Үндэсний ардчилсан хувьсгалын дараа хүн амын ихэнх нь үндэсний бичиг үсгийн боловсрол муутай байсан нь улс орны хөгжил дэвшилд ихээхэн саад болж байв. Лам нар ч мөн ялгаагүй төвөд үсгийг мэдэхээс монгол бичиг огт мэдэхгүй байсан нь улс орны цаашдын хөгжилд томоохон тээг болж байв. Тухайн үед Оросын эрдэмтэн И.Майский монголчуудыг "Бичиг мэдэхгүй байна. Хүн амын дөнгөж 1.0 хувь нь монголоор уншиж бичиж байна" гэж өгүүлж байсан юм.

Иймд 1923 онд хуралдсан МАХН-ын II Их хурлаас ард түмнийг бичиг үсэг ба бусад олон зүйлийн эрдэмд боловсруулах шийдвэрүүдийг удаа дараа гаргав. Уг компани ажилд бүх шатны байгууллагууд хамрагдсаны нэг нь эдүгээ 100 жилийн ойгоо тэмдэглэх гэж буй Монголын Зэвсэгт хүчин юм. Эр цэргийн албыг хэзээнээс нааш хүдэр чийрэг, шалгарсан сайн эрчүүдийн алба гэж үзэж ирсэн ч XX зуун гараад бичиг үсэг хэчнээн чухал болохыг мэдрүүдсэн үйл явдал болжээ.

Тиймээс Цэргийн яамнаас цэргийн албанд татагдан ирсэн залууст дан ганц цэргийн эрдэм заах бус хажуугаар нь бичиг үсгийн боловсрол олгох асуудалд анхаарах болжээ. Нөгөө талаар Монголын Зэвсэгт хүчин орчин цагийн цэргийн онол, түүх, зэвсэг, техникийг эзэмшихийн тулд заавал бичиг үсэг сурах шаардлага урган гарсан юм. Гэвч хүн амын боловсролын түвшин, эдийн засгийн хүч бололцоотой уялдан бодит бэрхшээлийн улмаас чухам цэргийн эрдэмд боловсорсон хүмүүс маш цөөхөн бөгөөд цэрэг, даргын 90 хувь нь бичгийн болон цэргийн хэргийн мэдлэг муу байсныг МАХН-ын III Их хуралд Цэргийн яамны ажлын талаар С.Данзангийн тавьсан илтгэлд тэмдэглэж байв. Энэ бүхэн нь шинэ Монгол Улсад цэргийн даргалах боловсон хүчин бэлтгэх шаардлага үлэмж их байсныг илтгэн харуулж байсан бөгөөд энэ талаар 1924 онд хуралдсан улсын ба намын Их хурлаас онцгой ач холбогдолтой шийдвэрийг гаргаж хэрэгжүүлжээ.

Уг илтгэлд бичиг үсэг сургалал зохих цэргийн нийт тоог заагаагүй хэдий ч 1 дүгээр морьт бригадын хоёр, пулемёт ба их бууны тус бүр нэг, бүгд дөрвөн хороонд сайн, дунд, муу гэсэн үнэлгээтэйгээр нийт 512, түүнээс гадна номын хоёр багш, 120 хүн бичиг үсэг зааж байгааг дурдсан бол Улсын анхдугаар хурлын шүүмжлэлд "Нийслэлийн цэргийн 70 хувь нь эрдэмд боловсорсон" тухай мэдээ буй. Мөн үед хязгаарын цэргийн гурван хороо, дивизион, суманд 414 хүн бичиг үсэг сурч байсан бөгөөд Ховдыг оролцуулахгүйгээр уг ажилд хамрагдагсдын тоо 982-д хүргэжээ.

Бичиг үсэгтэй болж халагдсан цэргийн тоо ч цөөнгүй байжээ. Иймд дээр дурдсан тоог бүх цэргийн тоонд харьцуулан бичиг үсэгтний хувийн жинг гаргах боломжгүй бөгөөд гагцхүү 1924 оны зунаас эхлэн цэргийг бичиг үсэгт сургах ажил сайжирсан гэсэн дүгнэлтээр уг ажлын дүн нурууг гаргаж болох талтай юм. Мөн үед бичиг үсэгт



сургахдаа багш нарын болон суралцагсдыг гарын авлагаар хангахад багагүй анхаарч байжээ. Үүний хамт цэргүүд хичээлийн цагийг хийдүүлдэг, залуу, сахилга сул зэрэг дутагдал Их хурлын шүүмжлэлд туссаныг анхаарахгүй өнгөрөөж үл болно.

Цэргүүдэд 1925 оноос жагсаалын сургууль ба бичиг үсгийн хичээлийг өдөр бүр найман цагаар зааж байсан хэдий ч байр сууц муу, бэлтгэсэн дарга нар цөөн байгаа нь бэрхшээл учруулж байгааг Бүх цэргийн зөвлөлөөс Улсын Бага хуралд илтгэж байв. 1926 онд халагдсан цэргүүдийн 10 хувь нь сайн, 21 хувь нь дунд бичигтэй, 31 хувь нь бага төсөөлөн мэдэх, 38 хувь нь үл мэдэгчид байжээ.

1926 онд хуралдсан Улсын III Их хурлаас Ардын улсын цэргийн 70 хувийг бичиг үсэгтэй болгох зорилт дэвшүүлэв. Улсын 1927 онд хуралдсан IV Их хурлын үеэр гаргасан тоон мэдээгээр бичиг үсэг мэдэх болсон хүмүүс нь 77 хувь болж, 1928 оны 10 дугаар сар гэхэд энэхүү үзүүлэлт 85 хувь болсон байна. Бага дарга,

бэлтгэлээр халж орон нутагт нь буцаажээ. Дараагийн жил гэхэд халагдсан бага дарга, цэргүүдийн 60 хувь нь бичиг үсэг сайн мэддэг, 36 хувь нь бага, дөрвөн хувь үл мэдэгч байв. Эдгээр арга хэмжээний үр дүнд МАХЦ нь цэрэг, дарга нарыг бичиг үсэгт сургах соёлын томоохон сургууль болж, цэргээс халагдсан бичиг үсэг бүхий олон зуун хүн улс орны хөгжилд дорвитой хувь нэмэр оруулж эхэлсэн юм.

Гучаад оны эх гэхэд МАХЦ-ийн бие бүрэлдэхүүнийг үндэсний монгол бичигт сургах тогтолцоо үндсэндээ тогтож байлдааны болон улс төрийн бэлтгэлийн чанарыг дээшлүүлэхэд чухал хүчин зүйл болжээ.

Монгол оронд 1937 онд өрнөсөн хэлмэгдүүлэлтийн хар шуургад бичиг үсэгтэй сэхээтнүүдээс гадна МАХЦ-ийн бичиг үсэгт боловсорсон олон дарга өртсөн байна. Ийнхүү Монголчуудыг бичиг үсэгтэй болгох эхний давлагаа энэ хүрээд зогссон гэж үзэж болно.

Дайны үед бүх нийтээр кирилл үсэгт шилжих үед Зэвсэгт хүчин мөн л хүчин

Дайны дараачаас Зэвсэгт хүчнийг цомхотгох үйл явц ард түмнийг бичиг үсэгтэй болгох давлагаатай огтлолцсон юм. Энэхүү цомхотгол нь улс төр, зохион байгуулалтын томоохон арга хэмжээ байсан бөгөөд Зэвсэгт хүчнээс халагдсан олон мянган дайчин материаллаг үйлдвэрлэлийн хүрээнд ажилчин малчдыг шинэ хүчээр сэлбэхийн хамт сэхээтэн, албан хаагчдын эгнээг өргөтгөж, улс ардын аж ахуй, соёл, боловсролын байгууллагын өмнө тулгамдсан зорилтуудыг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлсэн байна. Түүнчлэн халагдсан дайчдын дотор нам, эвлэлийн гишүүн олон байсан нь орон нутгийн нам, эвлэлийн байгууллагыг бэхжүүлэхэд сайн нөлөө үзүүлжээ.

Цэргээс халагдагсдын дотор төрөл бүрийн мэргэжил эзэмшсэн олон хүн байсан бөгөөд тухайлбал, номын багш 317, кино механикч 52, хүн эмнэлгийн бага мэргэжилтэн 436, мал эмнэлгийн бага мэргэжилтэн 187, холбооны 1394, автын 2423, аж ахуйн 392, барилгын мэргэжилтэн 3390-ийг улс ардын аж ахуйд, 150 гаруй даргыг хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйн удирдах албанд шилжүүлжээ. Сүхбаатар аймгаар жишээлэхэд МАХЦ-ээс халагдан очсон дайчдын 85.7 хувь нь нам, олон нийт, засаг захиргааны байгууллагад, 14.3 хувь нь мал аж ахуйд ажиллаж байв. Энэ хэрээр ард түмнийг бичиг үсэгтэй болгох хоёр дахь үе шатанд Зэвсэгт хүчин оролцсон юм.

1969 оны хүн амын тоо бүртгэлийн мэдээгээр нийт хүн амын 82.4 хувь нь бичгийн боловсролтой болсны дотор эрэгтэйчүүдийн 88.7, эмэгтэйчүүдийн 76.6 хувь нь бичигтэн болсон байлаа.



Шинэ үсэгт суралцаж буй хүмүүс. 1940-өөд оны сүүл. (ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Түүхийн баримт мэдээллийн төв)

цэргүүдийг бичиг үсэгт сургах ажил МАХЦ-ийн хэмжээнд өргөн далайцтай өрнөж, ном давтэр, багшлах боловсон хүчин, номын багшаар хангах зэрэг арга хэмжээ авсны үр дүнд бичиг үсэг мэдэх хүмүүсийн эзлэх хувь жил дараалан өсч ирэв.

Цэргийн албанд 1930 онд татагдан ирсэн шинэ цэргүүдийн 85 хувь нь бичиг үсэг үл мэдэгчид байсан бол тухайн жилд анхан шатны сургуулийн багш 12, соёлын довтолгооны ба хоршооны зэрэг ажилд 3000 тооны бичиг үсэг бүхий хүнийг

зүтгэх болжээ. Ялангуяа, 1945 оны 10 дугаар сард болсон Тусгаар тогтнолын төлөөх бүх нийтийн санал асуулгын өмнө санал өгөх цэргийн алба хаагч нарт хэрхэн гарын үсгээ зурах талаар заагаад зогсохгүй шинэ үсэг заасан нь бас нэг томоохон үйл явдал болсон юм. Уг ажлын хүрээнд хамгийн өндөр ирцээр эх орныхоо тусгаар тогтнолын төлөө Зэвсэгт хүчний албан хаагчид санал өгсөн нь бичиг үсэг сурсны ач гавьяа юм.

Дараагийн хоёр дахь давлагаа дэлхийн II дайны дараах жилүүдэд эхлэв.

Манай хүн амын гэгээрлийн энэхүү амжилтыг ЮНЕСКО өндрөөр үнэлж 1970 онд Н.К.Крупскаягийн нэрэмжит олон улсын шагналыг олгосон юм.

Энэ нь ард түмнийг бичиг үсэгтэн болгох ажилд хүчин зүтгэсэн Монголын Зэвсэгт хүчний гүйцэтгэсэн үүргийн нэг юм. Манай Зэвсэгт хүчин шиг бүх нийтийг бичиг үсэгт сургасан салбар өөр хаана ч байгаагүй гэхэд хилсдэхгүй. Цаашид ч Монголын Зэвсэгт хүчин ард түмнээ соён гэгээрүүлэх ажлаа үргэлжлүүлсээр байх болно.

Редакцын шууданд

УВС АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ

Тус аймгаас цэргийн жинхэнэ албанд татагдан Зэвсэгт хүчний болон Хилийн ангиудад хугацаат цэргийн алба хааж байгаа байлдагчдын ар гэрт дэмжлэг үзүүлж, тэднийг эргэх, алба хааж буй орчин нөхцөлтэй танилцах ажлыг зохион байгууллаа. Мөн энэ үеэр "Ковид-19" цар тахлын нөхцөл байдлаас улбаалан улсын эдийн засаг, иргэдийн амьдрал ахуй хүнд үед зарим цэргийн алба хаагчдын ар гэр, зорилтот бүлгийн 48 өрхөд 2.4 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүний дэмжлэг үзүүлэв.

Хошууч Ө.СОЁМБО

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЦЭРГИЙН ШТАБ

Б а т л а н хамгаалахын сайд, Аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээний дагуу "Ковид-19" цар тахлын хорио цээрийн дэглэмтэй байгаа энэ үед хүнс тэжээлийн дэмжлэгт хамрагдах шаардлагатай зорилтот бүлгийн өрхүүдэд тусламж үзүүлэв. Тодруулбал, тус аймгаас хугацаат цэргийн албанд мордсон 21 байлдагчийн ар гэрт тус бүр 100 мянган төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлэв.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 110 ДУГААР АНГИ

*Ангийн бие бүрэлдэхүүн нийгмийн хариуцлагынхаа хүрээнд "Covid-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлыг гүйцэтгэж буй Орхон аймгийн Онцгой комиссын бүрэлдэхүүнд 1000 ширхэг амны хаалт, 500 мянган төгрөгийн мөнгөн хандив өргөлөө.

*Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд байнгын бие бүрэлдэхүүний дунд "Цэвэр монгол бичигтэн" уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд 30 гаруй цэргийн алба хаагч оролцож, тэргүүн байрт ахлах ахлагч Ч.Ганзам, дэд байрт дэд ахлагч У.Отгонзаяа, гутгаар байрт дэслэгч Ц.Ууганбаяр нар шалгарав.

Дэслэгч Б.ХАЛИУН

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 017 ДУГААР АНГИ

2020 оны 2 дугаар ээлжээр татагдан ирсэн хугацаат цэргийн алба хаагчдад Техник технологийн политехник коллежтэй хамтран Барилгын өргөн мэргэжлийн 2-4 шатны зэрэг олгох сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж байна. Энэхүү сургалт 5 дугаар сарын 1-нийг хүртэл явагдах бөгөөд мэргэжил эзэмшсэн дайчид алба хаах хугацаандаа эх орон, Зэвсэгт хүчний томоохон бүтээн байгуулалтад оролцон, мэдлэг чадвараа дадлагаар бататгах юм.

Ахмад С.УЛАМБАЯР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 234 ДҮГЭЭР АНГИ

*Ангийн эмэгтэйчүүдийн зөвлөлийн гишүүд өвлийн хэргийн гаралт, дадлагын үед хэрэглэх өнгөлөн далдлалтын 62 хос хувцсыг, уутны хамт оёж, ангийн ажиллагааны удирдлагын тасагт хүлээлгэн өглөө.

*Х ө д ө л г ө ө н и й дутагдлаас урьдчилан сэргийлж цэргийн алба хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх, дархлааг дэмжих зорилгоор гүйлт, гимнастик, дасгал хөдөлгөөнийг цар тахлын үед тасаг, бүлгээр нь хэсэгчилсэн хэлбэрээр зохион байгуулж байна.

Ч.ОЮУНЧИМЭГ

БАЙЛДААНЫ ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН БОЛОН АЛТАН ГАДАС ОДОНТ БНМАУ-ЫН МАРШАЛ Г.ДЭМИДИЙН НЭРЭМЖИТ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 186 ДУГААР АНГИ

85

МЭНДЧИЛГЭЭ

Түүхэнд Матадын 8 дугаар морьт дивиз хэмээн алдаршсан Маршал Г.Дэмидийн нэрэмжит Байлдааны гавьяаны улаан тугийн одонт, Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн анхны тулгын чулууг 1936 онд тавилцаж, 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайнд оролцож, эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалах ариун үүргээ нэр төртэй биелүүлж, амь биеэ үл хайрлан тэмцэж явсан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид, азай буурлууд аа!

Энх цагийн бүтээн байгуулалт, Зэвсэгт хүчин, анги, байгууллагын маань хөгжил дэвшилд эрдэм мэдлэгээ зориулж ирсэн үе үеийн офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчид, ажилтан алба хаагчид аа!

Тус ангийн залуу халаа бид өвөг дээдсийн халуун амь, бүлээн цусаараа гэрээслэн үлдээсэн Монгол Улсынхаа халдашгүй дархан байдлыг батлан хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлж, Төр засаг, Зэвсэгт хүчин, ангийнхаа зорилго, зорилтыг хэрэгжүүлж, даян дэлхийд энхийг сахиулах эрхэм



үйлсэд хүчин зүтгэж, олон арван амжилт бүтээлтэйгээр ангийнхаа түүхт 85 жилийн ойтой золгож байна.

Өнөөдрийн ангийн маань өнгө төрх, амжилт бүтээл нь үе үеийн чадварлаг олон дарга, захирагч нар, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчид, ажилтан, алба хаагчдын минь хүч хөдөлмөр, сэтгэл зүтгэлийн үр дүн бөгөөд ажил албандаа сэтгэл зүрхнээсээ, бүтээлчээр хандаж ирсэн эрхэм хүндэт ахмадууд, одоо ажиллаж байгаа нийт бие бүрэлдэхүүн Та бүхнээрээ үргэлж бахархаж байдгаа энэ дашрамд илэрхийлэхэд таатай байна.

Та бүхэндээ "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жил, ангийн түүхт 85 жилийн ойг тохиолдуулан тус ангийн үе үеийн удирдлага, ахмадууд болон генерал, офицер, ахлагч, хилийн чанадад үүрэг гүйцэтгэж буй энхийг сахиулагчид, ажилтан алба хаагчид, тэдний гэр бүлд баярын мэнд дэвшүүлж, ажил хөдөлмөрт тань өндөр амжилт, амьдралд тань эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.



Тус ангийн бие бүрэлдэхүүн өмнөө тавигдсан үүргийг амжилттай биелүүлж, цэргийн шинэчлэлийг хэрэгжүүлж, Орхон аймгийн бүтээн байгуулалтын ажилд оруулсан хувь нэмрийг төр засгаас өндөрөөр үнэлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2016 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 21 дүгээр зарлигаар "Алтангадас" одонгоор тус тус шагнав.

МАХЦ-ийн дотор Халхын голын байлдаанд гарамгай үүрэг гүйцэтгэсэн 8 дугаар морьт дивизийг БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчид, Сайд нарын зөвлөлийн 1939 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн хамтарсан хурлын 60 дугаар тогтоолоор "Байлдааны гавьяаны улаан тугийн одон"-гоор,



БИДНИЙ ТҮҮХЭН БАХАРХАЛ

Манай ангийн бие бүрэлдэхүүн өмнөө тавигдсан үүргийг амжилттай биелүүлж, цэргийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг төр, засгаас өндөрөөр үнэлж, БНМАУ-ын Маршал Г.Дэмидийн мэндэлсний 100 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор тус бригадыг маршал Г.Дэмидийн нэрэмжит болгосон юм.



БАЙЛДААНЫ ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН БОЛОН "АЛТАНГАДАС" ОДОНТ БНМАУ-ЫН МАРШАЛ Г.ДЭМИДИЙН НЭРЭМЖИТ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 186 ДУГААР АНГИЙН ЗАХИРАГЧ, ХУРАНДАА Д.ЖИГЖИДСҮРЭН

АНГИЙН ҮЕ ҮЕИЙН ЗАХИРАГЧ НАР



Хошууч генерал Төмөрийн ТУНААВААНЖАВ /1979-1981/



Хурандаа Дамдинсүрэнгийн РЭНЦЭННАЦАГ /1981-1991/



Хурандаа Дагвын ГОМБО /1991-2002/



Бригадын генерал Бужиновын АМГАЛАНБААТАР (2002-2005 он)



Хурандаа Балжавын ГАЛБАДРАХ /2005-2010/



Хурандаа Өндөгний ЭРДЭНЭ-ОЧИР /2010-2016/

АЛДАРТ НАЙМДУГААР ДИВИЗИЙН ХАЛУУН АМ БҮЛЭЭС ТӨРСӨН АЛДАРТНУУД



8 дугаар морьт дивизийн захирагч Д.НЯНТАЙСҮРЭН



Их бууны салааны дарга В.ШАРАВ



8 дугаар морьт дивизийн захирагч Л.ДАНДАР



8 дугаар морьт дивизийн 23 дугаар морьт хорооны захирагч Ч.ДУГАРЖАВ



Пулемётчин байлдагч Д.САМДАН

ТҮҮХЭН ЗАМНАЛААС

ЭХ ОРНЫХОО ТУСГААР ТОГТНОЛЫГ ХАМГААЛАХААР ... ДУГААР МОРЬТ ДИВИЗ БАЙГУУЛАГДСАН НЬ

Монгол Улсын гадаад байдал 1930-аад оны эхнээс түгшүүртэй болж Япон Улсаас алс Дорнод ялангуяа, Манжуурт явуулж эхэлсэн үйл ажиллагаа нь Монгол Улсыг батлан хамгаалах хүчээ бэхжүүлэх арга хэмжээ авахад хүргэсэн. Улсыг Батлан хамгаалах тусгай комиссын 1935 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн хуралд Цэргийн явдлын яамны сайд бөгөөд Бүх цэргийн жанжин Маршал Г.Дэмид тус улсын гадаад байдалтай уялдуулан МАХЦ-ийн бүтэц бүрэлдэхүүнийг өөрчлөх, өргөтгөх, хүчин чадлыг зузаатгах төлөвлөгөөг танилцуулсан. Энэ төлөвлөгөөний дагуу МАХН-ын Төв хорооны Тэргүүлэгчдийн 1936 оны 1 дүгээр сарын хурлаар "Цэргийн тоо хэмжээг олшруулах ба зохион байгуулалтыг өөрчлөх буюу шинэчлэн гүйцэтгэх, МАХЦ-ийн ангиудыг шинээр байгуулах" шийдвэр гарчээ.

Шийдвэрийн дагуу 1936 оны 2 дугаар сарын 11-нд БНМАУ-ын ЦЯЯ-ны сайд бөгөөд Бүх цэргийн жанжны Ар Жаргалант хэмээх газрын орчимд ... дугаар морьт дивизийг байгуулах тушаал гарч, ... дугаар морьт дивизийг 22, 23, 24 дүгээр морьт хороо, холбооны суман, моторт отрядтайгаар байгуулахаар шийдвэрлэсэн. 1936 оны 2 дугаар сарын 12-нд ЦЯЯ-ны сайдын 16 тоот тушаалаар ... дугаар дивизийн захирагч бөгөөд комиссар, штабын дарга, бэлтгэлийн дарга нарыг томилсон. Гэвч 1936 оны 2 дугаар сараас Монгол Улсын гадаад байдал улам хурцдасан тул ... дугаар дивизийг байгуулах ажлыг түр хойшлуулсан.

Цагийн байдал бага зэрэг тайван болсон тул ЦЯЯ-ны сайд бөгөөд Бүх цэргийн жанжны маш нууц 18 тоот тушаал 1936 оны 6 дугаар сарын 13-нд гарч, ... дугаар морьт дивизийг Матад сумын нутаг "Хадан хөв" гэдэг газарт 22, 23 дугаар морьт хороо, ... дугаар моторт хороо, холбоо сумантайгаар байгуулахаар шийдвэрлэж, 6 дугаар морьт дивизийн дарга М.Гомбыг ... дугаар дивизийн даргаар, Цэргийн сургуулийн штабын дарга, хурандаа Д.Цолмонг штабын даргаар, 6 дугаар сарын 22-ны 98 тоот тушаалаар 6 дугаар морьт дивизийн 16 дугаар морьт хорооны ажлын туслах н.Бямбыг бэлтгэлийн даргаар тус тус томилжээ.

НАЙМДУГААР МОРЬТ ДИВИЗ ХАЛХЫН ГОЛЫН ДАЙНД

Монгол Улсын эсрэг Япон, Манжийн зүгээс хийх зэвсэгт өдөөн хатгалга 1939 оны 1 дүгээр сараас эхлэн идэвхжиж 5 дугаар сард Халхын гол орчмоор цэргийн томоохон хүчээр халдан довтолсноор "Халхын голын дайн" эхэлсэн. Наймдугаар морьт дивиз дайнд эхнээс нь оролцоогүй ч Баянцагааны болон Халхын голын зүүн эрэгт болсон 7 дугаар сарын байлдаанууд, ерөнхий давшилтад оногдсон үүргээ амжилттай биелүүлж, дайны туршид Монгол-Зөвлөлтийн цэргийн баруун жигүүрийг бат найдвартай хамгаалж ирсэн бахархам түүхтэй.

Халхын голын дайн эхлэхэд ... дугаар морьт дивиз



"Матад" дахь байнгын байрлалдаа байсан бөгөөд 1936 оны 6 дугаар сарын 25-ны шөнө фронт руу хөдөлж, Буйр нуурын баруун талд Булан дэрс, Ухаа худгийн орчимд байрлаж, тэр чиглэлд дайсныг нэвтрүүлэхгүй хориглон хамгаалах үүрэг авсан.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн ба Сайд нарын зөвлөлийн гишүүдийн 1939 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 60 дугаар тогтоолоор "Өөрийн эх орныг гадаадын эзэрхэг түрэмгийлэгчдийн довтолгооноос шийдвэртэй батлан хамгаалах баатарлаг байлдаанд шалгарсан Дорнод хязгаарын Матадын 8 дугаар морьт дивизийг Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор шагнаж, Бага хурал, Засгийн газраас "Улаан туг"-аар баяр хүргэхээр шийдвэрлэсэн байна.



Халхын голын дайнд оролцогчдын гавьяа дурсгалыг хүндэтгэж ... дугаар морьт дивизийн дарга, хурандаа Дүгэрийн Нянтайсүрэн 1971 онд, 23 дугаар морьт хорооны дарга, хурандаа Чойн Дугаржавыг 1969 онд, Их бууны салааны дарга, дэслэгч Ванчинжавын Шаравыг 1984 онд, Пулемётчин байлдагч Дуламдоржийн Самданд 1973 онд, Л.Дандарт (1943-1944 онд 8МД-ийг командалж байв) БНМАУ-ын баатар цол шагнасан.

... дугаар морьт дивиз 1939-1945 онд Халхын голын дайн Монгол-Зөвлөлтийн цэргийн ялалтаар төгссөн ч 1939 оны 9 дүгээр сард Европт дэлхийн II дайны гал дүрэлзэж, Ази тивд Япон Улс цэргийн хүчирхэг гүрэн болж улмаар фашист Германы холбоотон болсноор бүс нутгийн аюулгүй байдал хийгээд Монгол Улсын аюулгүй байдалд ноцтой аюул занал учруулж байв.

Гитлерийн Герман 1941 оны 4 дүгээр сарын 22-нд ЗХУ-д гэнэт халдан довтолсноор Эх орны аугаа их дайн эхэлсэн. Энэ үеэс БНМАУ-ын нам, төр, Засгийн газар улс, эх орныхоо тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг сахин хамгаалахад онцгой анхаарч, Зэвсэгт хүчнийхээ байлдах чадвар, байлдааны болон байдлыг дээшлүүлэх, боловсон хүчин, зэвсэг, байлдааны техникээр хангахад чиглэсэн нэлээд арга хэмжээ авсан нь ... дугаар морьт дивизийн түүхтэй салшгүй холбоотой.

1939-1945 оны үед ... дугаар морьт дивизийн даргаар

Дүгэрийн Нянтайсүрэн, Цагааны Самдангэлэг, Лодонгийн Дандар, Мядагийн Одсүрэн, штабын даргаар н.Самдан, Т.Лувсандугар, Ч.Цэнджав, С.Рэнцэн, Ч.Янжив, Комиссараар н.Санж, н.Орших, Д.Гомбодорж, бэлтгэлийн даргаар н.Дамбадаржаа, н.Лувсан, Д.Намсрай нар дараалан ажиллаж байв.

ЭХ ОРНЫХОО ТУСГААР ТОГТНОЛЫН ТӨЛӨӨ ... ДУГААР МОРЬТ ДИВИЗ ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНД

Дэлхийн II дайны төгсгөлд Монгол Улсын Засгийн газар Нэгдсэн үндэстнүүдийн талд байж, Японы эсрэг дайнд оролцох бэлтгэлээ хангаж байлаа. Нэг талаас "Монгол овогтон нэгэн гэр улс" болж нэгдэх нөхцөлийг бүрдүүлэх, нөгөө талаас БНМАУ-ын тусгаар тогтнолыг дэлхий даяар хүлээн зөвшөөрүүлэхэд чухал түлхэц болно гэж үзэж байсан юм. Ийм учраас БНМАУ-ын ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжин маршал Х.Чойбалсангийн тушаалаар 1945 оны 7 дугаар сарын 10-нд ... дугаар морьт дивиз Өндөрхаанаас хөдөлж 325 км марш үйлдэж, Сүхбаатар аймгийн Онгон сумаас урагш 25 км-т байрлан байлдааны бэлтгэл сургуулиа хийж байв.

БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчид ба Сайд нарын зөвлөлөөс 1945 оны 8 дугаар сарын 10-нд "Японд дайн зарлах Тунхаг бичиг" гаргасан.

МАХЦ-ийн "Өмнөд" бүлгийн командлагч, генерал И.А.Плиевийн тушаалаар ... дугаар морьт дивиз 1945 оны 8 дугаар сарын 8-ны өглөө марш үйлдэн Дарьганга сумын нутаг Хар нуурт байрлаад 9-ний өглөө хил давж 10-ны өдөр Хамба ламын хийдийг, 12-ны өглөө Арцагаан нуурын орчмыг эзлэн авсан. Улмаар Цахарын элсэн цөлийг гаталж Долоннуур хотыг эзлэн авах тушаал авч генерал Ю.Цэдэнбал, С.Равдан нарын удирдлагад хөдөлсөн. Энэ тушаалыг ... дугаар морьт дивизийн бүрэлдэхүүн амжилттай биелүүлж Яндуу сумийг эзлэн Цахарын цөлийг туулан 17-нд Долоннуур хотыг эзлэн авчээ.

Байлдааны ажиллагааны 2 дугаар шат 8 дугаар сарын 15-20-нд үргэлжилж, ... дугаар морьт дивиз Квантуны армийн үндсэн хүчийг Манжуурын талд бут цохисон нь япон цэрэг үйл олноороо бууж өгөх эхлэл болсон. ... дугаар морьт дивиз ялалтын баяраа 9 дүгээр сарын 3-нд Луаньпин хотод хийж энэ баярт маршал Х.Чойбалсан оролцожээ. ... дугаар дивизийн байлдааны ажиллагааг хурандаа Мядагийн Одсүрэн, улс төрийн орлогч, хурандаа Дэндэвийн Гомбодорж, штабын дарга, хурандаа Чойжоогийн Янжив нар, Морьт хороо, дивизионы захирагчаар Жавын Балдандорж, Чойны Дугаржав, Балжирын Сүрэнхорлоо, Бямбажавын Бухаа, Дагвын Уламнэмэх, улс төрийн орлогчор Минжүүрийн Дамжин, Дамирангийн Халзахүй, Тогтохын Дэндэв, Дашзэвэг, Мөнхийн Дамдин, штабын даргаар Луузангийн Батаа, Дарийн Бүтэмж, Дарьжавын Мижид, Дашдоржийн Цоож, Намсрай Гэндэн нар удирдаж ялалт байгуулсан баатарлаг гавьяатай.


Дайны дараа МАХН-ын Төв хороо, Засгийн газар, Цэргийн дээд командлалын 1945 оны 11 дүгээр сарын 7-ны "МАХЦ-ийн зохион байгуулалтыг тайван цагийн орон тоонд шилжүүлэх тухай" тушаалын дагуу Матадын ... дугаар морьт дивизийг 1949 оны 1 дүгээр сарын 1-нээс татан буулгажээ.

ДУРСАМЖ

1990 оны 10 дугаар сард миний бие сонины газар ажиллаж "Хэвлэлийн редактор" гэсэн бяцхан улаан үнэмлэхийг Нарийн бичгийн дарга, сэтгүүлч Ч.Дашдорж гуайн мутраас гардаж аваад хөл газар хүрэхгүй шахам хөөрцөглөж байсан санагдана. Тэр үед "Нийслэлийн сонин бичиг" сонины эрхлэгчээр Л.Чулуунбат гэж эрдэм номд чамгүй боловсорсон, эрдмийн зэрэг цолтой, дөлгөөн, тайван хүн ажиллаж байлаа.

Харамсалтай нь, миний бие сонин уншихдаа нэг бус алдаа гаргаж, анхааруулга авчхаад байсан үедээ "Гай газар дороос" гэгчээр эрхлэгчийн Хятад Улсаар явсан аян замын тэмдэглэлийн нэрийг "Л.Чулуунбат" гэж гаргаснаас болж бүтэн нэг жил ч ажиллаж амжилгүй цаашдын зам мөр шулууддаг юм байна. Тэр нь 1991 оны 6 дугаар сарын сүүлч үе байсан юм. Маргааш нь Хэвлэлийн комбинатаас ойр зуурын юмаа аваад Д.Сүхбаатарын талбайгаар алхаж явтал шог зохиолч Ш.Галсанбаатар, надтай хамт 1980 онд ЦЕДС-ийг улс төрийн мэргэжлээр төгсөөд,

зээл" сониныг эрхлэн гаргаж байгаа, хамтран ажиллаа" гэж урихад юуны нь татгалзах билээ. Ийнхүү Худалдаа, аж үйлдвэрийн танхимын 8 дугаар давхарт, хожмоо "Улаанбаатар" сонинд багагүй хугацаанд хамт ажилласан, сэтгүүлч, анд О.Лхагвадоржтойгоо нэг өрөөнд агаараа хуваалцан суух боллоо. Ажлын ачаалал харьцангуй гайгүй. Завсар чөлөөнд нь Эрэн явж бусдын адил гахай үүрнэ. Ер нь тэр он жилүүдэд гахай үүрээгүй хүн бараг хүн биш шиг санагддаг байсан юм уу даа! Гурван сар илүүтэй л ажилласан байх, ОХУ-ын Пенза хотын Зэвсгийн инженерийн дээд сургуульд суралцаж байсан цэргийн анд Г.Лувсанпүрэвтэй гудамжинд санамсаргүй таарч баахан хууч хөөрлөө. Тэр бээр суралцаж буй хотдоо Хятадын бараа чамгүй үнэ хүрдэг гээд, Эрэнээс жаахан бараа дараад хамт явахыг ятгав. Эрхүүгээс цааш гарч үзээгүй байсан надад Москвага дамжаад бүр баруун хязгаар нутагт хөл тавина гэдэг дахин олдохгүй алтан боломж учраас шууд л явахгаар шийдлээ. Г.Дагвадорж эрхлэгчээс 14 хоногийн чөлөө



"НУМ МИНЬ, АМЬД ИХ ЮМ" ГЭЖ БИЛЭЭ

улмаар Москва хотод Цэргийн улс төрийн академи дүүргэсэн, цэргийн анд Б.Ганболд нартай таарч, тэд Чөлөөт хөдөлмөрийн намын "Чөлөөт хөдөлмөр" сонин гаргах зорилготой редакция бүрдүүлж байгаа гээд намайг шууд л хөтлөөд явдаг юм байна. Ингэж гуравхан хоногийн дотор "Чөлөөт хөдөлмөрийн нам"-ын даргын тушаалаар тус сонины сурвалжлагчаар томилогдож, Ч.Дөл гэдэг хээ балгүй сайхан хүнтэй хамтран ажиллах хувь тохиосон юм. Энэ сонины үргэлжилсэн үгийн зохиолч Ш.Шажинбат, шог зохиолч Ш.Галсанбаатар, хүүхдийн зохиолч Сан.Жаргалсайхан нарын журмын нөхөдтэйгөө гар, сэтгэл нийлэн нэг жил орчим хамтран гаргаж байтал сонины эрхлэгч өөрчлөгдөж, Х.Маам гэдэг эрдэмтэн эрхлэгчээр ирсэн юм. Тэгээд төдий л удалгүй Чөлөөт хөдөлмөрийн нам маань МҮДН-тай нэгдсэнээр сонин ч татан буугдлаа. Лааз өшиглөх араандаа орчихоод явж байтал "Залуучуудын үнэн" зэрэг сонин, сэтгүүлийн газар олон жил ажилласан Г.Дагвадорж гэдэг ахмад сэтгүүлчтэй таарч, "Зах

аваад явсан би бээр бүтэн гурван сар гаруйн хугацаанд Оросын нутгаар тэнээд, яг л уулынхан шиг хууз, сахландаа баригдсан амьтан 12 дугаар сарын сүүлчээр эх орондоо ирэв ээ. Алжааж ядарсаныг ч хэлэх үү, хэд хоног гэртээ тухалж амраад, яг тэр хэвээр Г.Дагвадорж эрхлэгчийн өрөөнд ороход, үнэхээр айсан уу эсвэл зэвүүрсэн үү, царай нь барайгаад, хэл нь зэрч байсан нь одоо ч нүдэнд харагдаж, өрөвддөг юм. Мэдээж, ажил тасалсан хүнийг яах нь ойлгомжтой. Дашрамд тэмдэглэхэд, холын аяны энэ явалтаар би өөрийгөө наймааны ямар ч дэргүй нэгэн гэдгээ бүрэн ойлгож тэр чигтээ хөндийрсөн дөө. Ямар сайндаа хоёр том гахайтай явсан хүн чинь нэг жижигхэн хар цүнхтэй, мөнгө төгрөг гэж юу ч байхгүй амьтан гэртээ ирэхэд, гэргий минь үүнийг үл тоон "За яах вэ, Нум минь, амьд ирсэн чинь л их юм" гэж байсан нь ямар уужуу сэтгэл байж вэ гэж өнөө хэр бодогддог юм. Одоо цэргийн анд Г.Лувсанпүрэвийнхээ талаар бяцхан тодруулъя. Танихгүй нэгэнд бол манай хүн үг ярианаасаа эхлээд л нэлээд

пээдгэрдүү гэмээр нөхөр л дөө. 1987 онд миний бие олноо "Улиастайн" хэмээн алдаршсан 016 дугаар дивизийн 229 дүгээр ангийн штабын орлогчоор томилогдсон юм. Одесст зэвсгийн мэргэжлээр сургууль дүүргэж ирсэн түүнтэй эхний удаа хэг ёг харьцаатай байлаа. Яагаад гэвэл тэр пээдгэрдүү, би бас "Энэ ноён ямар янзаар угтана..." гэдэг шиг зантай нөхөр. Тэгээд хоёр пээдгэр сүүлдээ ойртон дотносож, нутаг нугаа мэдэлцвэл, аав нь манай сумын уугуул, "Ов" хэмээх хочтой Гомбосүрэн гэгч байв. Энэ хүнийг танихгүй ч нэрээр нь бол хэзээний мэдэх. Өөрөөр хэлбэл, ус нутгийн маань тэр хүн Гуравдугаар Төв эмнэлгийн дарга, агсан С.Дүгэржав, зохиолч Д.Маам агсан нарын ойрын садан төрлийн хүн байсан юм.

Бид хоёр Эрхүүгийн галт тэрэгний буудалд ганц хоёр юмаа борлуулаад цааш шуударч билээ. Москва ортол бүтэн тав хоног, мэдээж зам зуураас шар айраг сэлтээр ходоодоо баясган, дэгэнтэй догонтон явсаар Ярославский вокзалд хөл тавилаа. Газар мэдэхгүй, хүн танихгүй нөхөр Лууяа хаашаа,

тийшээ явсаар метро гэдэгт нь сууж үзлээ. Москвагийн сонин сайхныг хараачлан, 30 гаруй минут яваад нэг буудалд буусан нь Красногвардский гэдэг газар байв. Тэнд В.И.Чайковскийн нэрэмжит Хөгжмийн их сургуулийн Цэргийн хөгжмийн факультетэд суралцаж байсан н.Бямбадорж гэдэг залуугийнд буулаа. Жар нэлээд гарсан ээж нь нутгаас хүн ирсэнд баярлаад л... Маргаашаас нь Москвагаар танилцах ажилдаа орлоо, мэдээж Улаан талбай... Орой нь Танкийн академид сурч байсан, хожмоо хурандаа болсон С.Дарьзавын зочиллоо. Бас Нэхмэлийн дээд сургуульд сурч байсан ангийн охин Д.Цэцгээтэй уулзахаар... гэх мэтчилэн тэнэсээр байтал нэг мэдсэн долоо хоног ард хоцорчээ. Москва ч бага зэрэг гадарлахтайгаа болов. Лууяа ч "Хичээл сургууль болохоо байлаа" гээд л түргэн авлаа. Шөнө дөлөөр Пенза орох галт тэргэнд сууж, маргааш өглөө нь Эх орны дайны хүнд үед Германы цэрэг хөл тавьж чадаагүй, битүү модон дунд оршдог тэр сайхан хотод битүү цаснаар очиж байж билээ.

Пензагийн цэргийн сургуулийн багшаар ажиллаж байгаад чөлөөндөө гарсан Саша хэмээх Лууяагийн найз, бэлтгэл дэд хурандаагийн дэвхнөлөө. Гэргий нь сайхан зантай Лариса гэдэг эмэгтэй. Тэднийд бараг хоёр сар болсон. Орос хэл бага сага гадарладаг тулдаа болоод л байх. Лууяа хичээлдээ орчихсон, зав чөлөө гэж бараг гарахгүй. Сүүлдээ зах руу нь ганцаараа гараад л туучихна, хотоор дэмий тэнэж тэнэж оройхон хэрд ирнэ. Саша маань "Ингэж хамаагүй явж болохгүй дээ л" гэж. Миний авч гарсан хоёр гахай бараа тэр захаар нэг хөглөрөн байх. Авах хүн ч олдохгүй, сүүлдээ бушуухан далд оруулахын түүс болж, хямдхан зараад зогсохгүй, заримыг нь бүр зүгээр өгдөг боллоо. Пензагийн цэргийн сургууль үнэхээр чанд хатуу дэглэмтэй юм билээ. Тэнд хоёр сар орчим болоход ганцхан удаа л тэр сургуулийн босгыг нэг цагийн хугацаатай алхаж байх жишээний. Ийм нэг наймаачин найзаа нутаг буцаахаар Лууяа анд маань хоёр хоногийн чөлөө арайхийн аваад Москва ороод буцахдаа хоёр эр хүн Ярославский вокзалаас уйлан хайлан байж хоёр тийш салж байсан нь 28 жилийн тэртээх өдий үе байжээ. Мань Нум гэдэг нөхөр нэг л их ажилтай хүн шиг мөнөөх буусан айлаасаа өглөөгүүр гадагш гарна. Хүү нь сургуульдаа явчихна. Гум, Цум, Улаан талбай гээд л... Москвагаар дэмий тэнэсээр байтал 10 гаруй хоног алсарсан байв. Ийнхүү паянтай явж ирснээ дээр цухас дурдсан. Аль бүрийг бичиж барах вэ, улирсан баларсан юмыг. Харин Г.Лувсанпүрэв анд маань дараа жил нь сургуулиа дүүргэн ирж, Зэвсэгт хүчний анги, байгууллагад ажиллаж байгаад биеийн байдлын улмаас чөлөөлөгдөж, цэргийн тэтгэвэртээ гарсан билээ. Тэгээд "Хэлж ирдэггүй, хийсэж ирдэг" өвчин хэмээх дайнтай тэмцэлдэж байгаад хэдэн жилийн өмнө бурхны орноо одсон доо, анд минь. Цагтаа эр хүн шиг эрвэлзэж, эмээлт морь шиг дэрвэлзэж явсан энэ офицерийг таних хүн Зэвсэгт хүчинд цөөнгүй. ЗХЖШ-ын даргаар ажиллаж байсан хошууч генерал А.Ганбат, мөн штабын орлогч дарга, асан, эдүгээ ОХУ-ын ЭСЯ-ны Цэрэг, агаарын цэргийн атташегаар ажиллаж байгаа хошууч генерал Р.Сүхбат, түүнчлэн олон арван хурандаа нартай нэгэн үед Пенза хотноо суралцаж байсан даа. Сайн андаа санан дурсахад самсаа шархирч л байна. Үр хүүхдүүд нь аавынхаа замналыг үргэлжлүүлэн Зэвсэгт хүчний анги, салбарт нэр хүндтэй ажиллаж байгаа гэсэн.

Бэлтгэлд байгаа дэд хурандаа Гомбын БААТАРНУМ

БОГД ХААН ШАР ОРДОН РУУ ЗАЛАРЧ БАЙГАА НЬ

Монгол Улсын хаан наймдугаар Богд Жавзандамба хутагтын хөсгийн аяллыг дүрслэн харуулсан нэгэн сонирхолтой зураг Монгол цэргийн музейд хадгалагдаж байна. Тус музейн сан хөмрөгийн

дээр Өндөр Гонгорыг дүрсэлсэн байдаг гэхээс өөр зүйл мэдэхгүй байсан хэмээн тухайн үеийн Монгол цэргийн музейн үзмэр худалдан авах комиссын хурлын тэмдэглэлд дурджээ.

явцыг улам бүр эрчимжүүлж байсан бололтой.

Монгол цэргийн музейд хадгалагдаж буй "Богд хаан Шар ордон руу заларч байгаа нь" хэмээх энэхүү бүтээл нь Богд хааны

Богд хааны ордон музейд буй "Их хөсгийн аялал", "Бага хөсгийн аялал", Г.Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музейд буй "Хөсгийн аялал" зургууд нь зохиомж, дүрслэлийн хувьд

Харин Богд хааны ордон музейд буй "VIII Богдын хөсгөөр аялж буй нь" зурагт зөвхөн наймдугаар Богд Жавзандамба хутагтыг сүйхэнд залсан гурван эгнээ жагсаалын хоёр талд туг хиур барьж, буу агссан цэргүүд нэгэн эгнээгээр сөхрөн сууцгаах ба цэргүүдийн зарим нь морь хөтөлсөн байдаг. Энд мөн өндөр Гонгорыг мэдэгдэхүйцээр дүрсэлсэн байна. Тэгвэл Монгол цэргийн музей дэх "Богд хаан Шар ордон руу заларч байгаа нь" зурагт Богд хаан Эх дагины хамт төвийн Шар ордыг зорин хөсгөөр заларч буй жагсаалыг дүрслэхдээ зургийн баруун хэсэгт Шар ордын төрх байдлыг нэлээд тодорхой дүрсэлснээс гадна Шар ордын үүдэнд жагсаалыг угтахаар ёслол үйлдэж буй лам, ноёдыг, зургийн дээд хэсэгт тахил өргөж буй үүл хөлөглөсөн ханд дагинасыг, зургийн доод хэсгээр жагсаалыг сонирхон эгнэн зогссон лам, хар ардууд болон таван хошуу мал хөтөлсөн хүмүүсийг, харин зургийн гол хэсэгт зүүнээс баруун тийш Шар ордын зүг чиглэн айсуу жагсаалыг дүрслэн харуулжээ. Хэдийгээр түүхэн бодит үйл явдлыг харуулж буй ч энэхүү зурагт дүрслэгдсэн дүрүүдийг хэмжээний хувьд том, жижиг харилцан адилгүй дүрсэлсэн нь бурхны шашны шүтээн зургийн нөлөө тод туссаныг илтгэнэ.

Монгол цэргийн музейн лабораторийн эрхлэгч-археологич Э.ТҮВШИН



ерөнхий бүртгэлд бүртгэгдсэн, 39x180 см хэмжээтэй "Богд хаан Шар ордон руу заларч байгаа нь" хэмээх зургийг даавуу, гуаш зэрэг материалаар бүтээсэн хэмээн тэмдэглэжээ. Харин зураачийн нэр болон бүтээсэн он цаг тодорхойгүй агаад Богд хаант Монгол Улсын үед бүтээгдсэн хэмээн тодорхойлсон байна.

Зургийг 1995 онд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн I хорооны иргэн Ц.Эрдэнэ Монгол цэргийн музейд санал болгосны дагуу 150.000 төгрөгөөр тус музейн сан хөмрөгт худалдан авчээ. Уг зургийг эзэмшигч нь өөрийн өвөг эцгээсээ өвлөн авсан бөгөөд зурган

XIX зууны сүүл үеэс XX зууны эхэн үед Их Хүрээний урчууд Их хүрээний байр байдал, Их хүрээнд өрнөдөг чухал баяр ёслолыг илтгэн харуулсан сэдэв бүхий уран зургуудыг эрчимтэй туурвих болсон. Ялангуяа наймдугаар Богд Жавзандамба хутагт Олноо өргөгдсөн хааны сэнтийд заларсны дараахан 1912 оноос Хүрээний зураач нар Богд хааны зарлигаар буюу Их хүрээний сав газар, түүний ойр орчимд байгаа тэр үеийн нийгэм, амьдралын олон талын үйл явдлуудыг тусгаж харуулсан сайхан цуврал зургуудыг том, жижиг хэмжээгээр зурсан нь уран бүтээлчдийн бүтээж туурвих үйл

хөсгийн аялал хэмээх ижил төрлийн бусад зурагтай сэдэв агуулгаар төстэй боловч ихээхэн өвөрмөц дүрслэл, баялаг агуулгатай дээр зохиомжийн хувьд ч тодорхой ялгаатай болох нь сонирхол татдаг. Ийм төрлийн жагсаалыг дүрслэн үзүүлсэн зураг Монголын музейнүүдийн сан хөмрөгт мэр сэр хадгалагдаж байна. Тухайлбал Богд хааны ордон музейн сан хөмрөгт "VIII Богдын хөсгөөр аялж буй нь", "Их хөсгийн аялал", "Бага хөсгийн аялал", Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд "Хөсгийн аялал" гэсэн Богд хааны жагсаалын үйл явдлыг дүрсэлсэн зургуудыг дурдаж болно. Үүнээс

ижилхэн байдаг нь нэг зураачийн бүтээл байх магадлалтай. Эдгээр зургийн зохиомж нь зүүнээс баруун тийш хөвөрсөн төрийн жагсаалыг дүрслэн үзүүлэхдээ бодит дүрслэлд тулгуурлан бүтээжээ.

Зураг дээрх төрийн жагсаалд Богд хаан болон Улсын Эх дагина нарыг тус тусын сүйх тэргэнд төрийн ёслолын хувцастай заларч буйгаар дүрслэн харуулсан. Эдгээр зурагт дүрслэгдсэн Богд хаан, Эх дагина нарын төрийн ёст хувцас, Их Британиас захиалан авч ирсэн хос сүйх тэргэг, хаан хатны ард залж явдаг шүхэр тэргүүтэн нь эдүгээ Богд хааны ордон музейн сан хөмрөгт хадгалагдаж байна.

ЗӨВЛӨЛТИЙН "ТИТАНИК" ЗӨНГӨӨРӨӨ ЖИВСЭН ҮҮ, ЭСВЭЛ...

/"Наяад оны тэмдэглэл" цувралаас/

Сэтгүүлч П.БАТНАЙРАМДАЛ

Манай үеийнхэн сурагчийн ширээний араас сугарч, манан будант амьдралын далай руу алхах 1980 он гарлаа. Үзэл сурталжсан нийгэмд юу элбэг вэ, улаан туг, уриа лоозон. Зоогийн газрын хананд ч намын хоёр лоозон зоолттой шүү дээ. Гадаад мэдээллийг ганцхан сувгаар буюу ЗХУ-ын төв телевизийн дахин дамжуулах Орбит станцын нэвтрүүлгээр авдаг байв. Оросын ардын кино хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн, гадаад киноны Оскарын шагналт "Амьдрал нулимсанд дургүй" түүнчлэн үзэгчдийг хамгийн ихээр татаж хөгжөөж байсан "Ийм нэгэн явдал"-ын эрин үе эхэлсэн цаг. Кино гэснээс, "ХХ зууны далайн дээрэмчин" киноны билет авах гэсэн залуусын дараалал шахцалдаан, түлхэлцэн, эмх замбараагүй байдал үүсгэж, Нийтийн ахуй үйлчилгээний техникумын хичээлийн байрны клубын үүдэнд олны хөлд гишгэгдэн оюутан охин амь эрсэдсэн эмгэнэлт явдал ч 80-аад оных. Бидний үеийнхэн барууны хувцас, дуу хуур, соёлыг ихэд хүсэмжилж байсан ч үзэл суртлын хувьд тас хориотой. Гадаад ертөнц маань ердөө ЗХУ-аар хязгаарлагдаж байв. Оросоос ирсэн хүний

бүтээж, хамгийн энэрэнгүй зэвсэг хэмээн сурталчилж байв. Энэрэнгүй гэдэг нь уг зэвсэг байшин барилгыг сүйтгэхгүй, зөвхөн коммунистуудыг л устгана. Баруун Германд байрлуулсан гэх нейтроны бөмбөг коммунизмыг булшлах найдвартай зэвсэг гэгдэж байсан ч ЗХУ ганхах яагаа ч үгүй, хүчирхэг хэвээрээ. Үе үе "Правда" сонины эхний нүүрэнд Афганистанд гарамгай гавьяа байгуулсан цэрэгт ЗХУ-ын баатар цол шагнасан зарлиг хэвлэгдэж байсан цаг. Гэхдээ ихэвчлэн хашилтад посмертно /нэхэн/ гэсэн тодотголтой.

Афганистанд цэрэг оруулсан гэх шалтгаанаар барууны орнууд хориг тавьж, тамирчдаа оролцуулаагүй ч 1980 оны 7 дугаар сарын 19-нд Москвагийн олимп дуулиант нээлтээ хийж, улсыг аюулаас хамгаалахын ил, далд хатуу хараа хяналтын дор явагдаж, социализмын давуу талыг дэлхий дахинд илтгэн харуулсан онцгой үйл явдал боллоо гэж сөрөг сурталчилгаа ч хийж байлаа. Тэгтэл олимпын тоглолтын ид үеэр нэгэн эмгэнэлт явдал тохиолдсон нь Оросын дахин давтагдашгүй гайхалтай содон авьяастан, ардын дуу хоолой хэмээн алдаршсан, нэрт дуучин, яруу найрагч В.Высоцкий насан эцэслэж, Москва

сүйрчээ. Энэ ослын тухай нам, засгийн "Үнэн" сонины "Хөрөнгөт ертөнцийн нүүр царай" буланд хоёр өгүүлбэр мэдээ нийтлэгдсэн байдаг.

1986 оны 4 дүгээр сарын 26-нд ЗХУ-ын төдийгүй дэлхийн түүхэнд нэн харамсалтай, хор уршиг, аюулт үр дагавар нь хэмжээлшгүй их сүйрэл гарсан юм. ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтсан бүгд найрамдах улсуудаас хамгийн хүчирхэгт тооцогдож байсан Украин улсын Припять хотын нутаг дэвсгэрт дэх Чернобылийн /хар цагааны/ атомын цахилгаан станцын сүйрэл нь хүн төрөлхтний түүхэнд гарсан хамгийн аймшигт цөмийн эрчим хүчний үйлдвэрийн осол бөгөөд олон улсын цөмийн үзэгдлийг судлах хэмжээгээр 7 дугаар зэрэглэлд багтах цорын ганц осол юм. Миний суралцаж байсан Львов хотоос холгүй орших Припять хотын оршин суугчдыг нүүлгэн шилжүүлж, цөмийн цацрагийн тархалт Зүүн Европыг бүхэлд нь хамарсан ослын үршгаар олон зуун мянган хүн цаг бусаар үрэгдэж, насан туршийн өвчинд нэрвэгдэж, байгаль орчинд зуун жилдээ ч нөхөн сэргэшгүй сүйтгэл авчирсан юм.

1986 оны 8 дугаар сарын 31-нд Хар тэнгисийн Новороссийск боомтоос хөдөлсөн "Адмирал Нахимов" зорчигч тээврийн хөлөг онгоц Цемесс булангийн боомтоос 7 мил, хамгийн ойрын эргээс 2.2 мил зайд ачаа тээврийн "Пётр Влаев" хөлөг онгоцтой мөргөлдөн 7-8 минутын дараа живжээ. Хөлөг онгоцонд 1243 хүн /897 зорчигч, хөлгийн багийн 346/ хүн байжээ. Албан ёсны мэдээллээр 423 хүн нас барсан гэх боловч үнэн бодит тоог гаргаж чадаагүй. Энэ осол гарсан өдөр би ЗХУ-д буюу тодруулбал, Украинд байсан ч осол гарсан тухай радио, телевиз, сонин, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлагдаагүй, огт яригдаагүй. Зөвлөлтийн нам засаг, цэргийн дээд удирдлага мэдээлэхгүй байх шийдвэр гаргажээ. Яагаад гэвэл, Украинд Чернобылийн сүйрэл гараад ард иргэдийн айдас хуйдас, гашуудал

зовлон бүдгэрээгүй байхад бас нэг осол, үхэл хагацал. Нөгөөтэйгүүр социализмын давуу талыг харлуулах таагүй явдал. Дөнгөж танилцаад байсан, сэтгүүл зүйн багш В.Колотило:

"Би сонсоогүй явахад чи яаж сонсох вэ. Хар далайд хөлөг онгоц живчихжээ. Барууны сэтгүүлчид биднээс шуурхай юм гээч. Германы хэвлэлд энэ тухай гарсан байна гэж ярьсан юм. Тэгэхдээ бур:

"Манай сонин хэвлэл хяналттай, мэдээллийг хоцроож, нууж дарж, бүдгэрүүлж цацдаг. Бодит үнэнийг мэдэх эрх бүх нийтэд байх ёстой гэсэн сэн. Олон нийтийн мэдэх эрх гэдэг ойлголтыг би 1986 онд анх сонсож, сэтгүүлч мэргэжлээр суралцаж байсны хувьд сайтар ухаж төнхсөн гэх үү дээ. "Адмирал Нахимов" хөлөг онгоцны сүйрлийг барууны хэвлэлд "Зөвлөлтийн титаник" хэмээн бичиж байж. Тэгтэл ёстой нөгөө мэдэх эрх маань охордлоо. Оросын их нэвтэрхий толь сөхөж байж "Титаник" гэж юу болох тухай мэддэг юм. Сонирхол татаж байна аа. В.Колотило багшийн заавар, зөвлөгөө, тусламж дэмжлэгтэйгээр "Адмирал Нахимов" хөлөг онгоц хийгээд ослын тухай мөчид боловч материал цуглуулж билээ. Үүнийхээ үр дүнд сэтгүүл зүйн онолын хичээлийн семинарт би энэ хөлөг онгоцны сүйрлийн тухай нийтлэл маягийн бичвэрээ хэлэлцүүлсэн юм. Зөвлөлтийн цэрэг Афганистанд интернационалч үүргээ амжилттай биелүүлж байгааг ямагт сурталчилж байсан цаг дор шударга, үнэнийг бичиж өөрчлөн байгуулалтын нэгэн өвөрмөц дуу хоолой болж байсан дэслэгч генерал Д.Волкогоновын шуугиант нийтлэл нөлөөлсөн байх. Уг нийтлэлд, зөвлөлтийн цэрэг Афганистанд ихээхэн хохирил амсаж, ялагдах хүлээсээр байгааг баримтаар илчилж, Афганистанаас цэргээ татах нь зүйтэй гэсэн байдаг.

Миний бичсэнийг анхааралтай сонсож суусан В.Колотило багш:

"Чамд хувийн дүгнэлт байна уу гэдэг юм. Ингэж асуухыг нь таамаглаж суусан би "сэжигтэй" нэг гаргалгаа хийгээд байсан ч багшийн өөрийнх нь хэлдгээр "Сэтгүүлч хүн олборлосон материалынхаа сул 60 хувийг л бичих хэрэгтэй. Ороогдоод ирвэл жинтэй 40 хувийг гаргаж ирдэг байхгүй юу" гэдгийг баримталж, бичвэрт оруулаагүй "сэжигтэй"-гээ хэллээ.

"Дорнын зурхайд сарны түлхэлт гэсэн ойлголт байдаг. Байгалийн тайлагдашгүй, давагдашгүй хүчин зүйл,

үзэгдлийг сарны тоололтой холбон тайлбарладаг. Энэ хөлөг онгоц 31-ний өдөр хоёр удаа живсэн, эхнийх нь 13 метрийн гүнд. Төрсөн өдрийн төөрөг, гарсан өдрийн гараг ч гэж ярьдаг. 31-ийн тоог эргүүлж бичвэл 13 болно. (13-ын тоо нь оросуудын ихэд сэжиглэдэг, чөрт тринацать нь шүү дээ) гэхэд В.Колотило багш цэнхэр гараг шиг нүд эргэлдүүлэн зальжин инээмсэглэж:

"Интерсно, может быть гэсэн сэн. Би яагаад энэ ослыг сонирхон ухаж төнхсөн бэ гэвэл, бидний үеийн сонсож байсан гадаад, дотоод мэдээлэл үзэл сурталжсан, хасагдсан, танагдсан, нуусан, дарсан, мэдэлтэн дархтан, албан тушаалтны эрх ашиг, таалалд нийцүүлэн засварлаж зохиомжилсон, яг таг хайрцаглагдсан байдгийг гадаргаж эхэлсэнтэй холбоотой юм. Бас тухайн цагийн гэрэл гэгээ, содон үзэгдэл болж байсан М.С.Горбачевын "Престройка и новое мышление" ("Өөрчлөн байгуулалт ба шинэ сэтгэлгээ") номын үндсэн өгүүлэгдэхүүн нь "Өөрчлөн байгуулалт үнэнийг хэлэхээс эхэлнэ" гэсэн байдаг шүү дээ. Намч, зарчимч, социалист аж төрөх ёсоор сурч, хүмүүжсэн 80-аад оныхны оюун санаанд эргэлт авчирсан өөрчлөн байгуулалтын үзэл санаа нь үнэнийг үнэнээр нь хэлэх, үйл явдал олон ургалч үзлээр хандах, олон нийтийн мэдэх эрхийг хангах явдал байв даа.

Далайн зорчигч тээврийн аварга том хөлөг онгоцны анхны нэр нь Берлин-3 байсан бөгөөд 1925 онд Германы Бермин боомтод бүтээгдэж, мөн ондоо Бремерхафен-Нью-Йорк чиглэлийн аялалд гарчээ. 1939 оны 8 дугаар сараас Германы тэнгисийн цэргийн эмнэлгийн зориулалтаар ашиглагдаж байгаад 1945 оны 1 дүгээр сарын 31-нд Гвиней голын эхэнд 13 метрийн гүнд живсэн. Цэргийн нөхөн сэргээлтийн үр дүнд ЗХУ-д шилжин "Адмирал Нахимов" нэртэй болжээ. 1949-1957 онд засвар шинэчлэл хийгдэж, Хар тингэсийн тээврийн Одесса компанид шилжсэн аж. "Адмирал Нахимов" хөлөг онгоц цэргийн зориулалтаар тоноглогдсон, найдвартайд тооцогдож, цэргийн тусгай үүргийн тээвэрлэлтийг удаа дараа амжилттай гүйцэтгэж байв. 1962 онд Карибын тэнгисийн хямралын үеэр Зөвлөлтийн цэргийн алба хаагчдыг Куба руу тээвэрлэсэн бол 1978 онд Кубын цэргийн бүлгийг Этиоп руу, мөн онд Алжираас Гавана руу цэрэг тээвэрлэжээ. Тухайн цагтаа дэлхийд хүчирхэгт тооцогдож байсан Зөвлөлтийн тэнгисийн цэргийн флотод тээврийн зориулалтаар ашиглагдаж байсан "Адмирал Нахимов" хөлөг онгоц Хар тэнгист живж олон зуун хүний амь эрсэдсэн шалтгааныг яг таг мухарлаж чадаагүй билээ.

Тусгай албадын мөрдөн шалгах ажлын тайлантай танилцаж дүн шинжилгээ хийсэн профессор В.Чуев техникийн гэмтэл, багийн гишүүдийн сахилга, харууллагаас тэс өөр, улс төрийн сэжигтэй таамаглал дэвшүүлж, батлахыг оролджээ. Үл үзэгдэх цахилгаан соронзон цацрагийн нөлөөлөл ямар ч радарт ажиглаж боломжгүй гэсэн нь олон хүнд үнэмшил бас эргэлзээ төрүүлсэн байдаг. Богино долгионы зэвсэг хэрэглэснээс үүдэлтэй гэсэн энэ хувилбар Чернобылийн атомын цахилгаан станцын сүйрэлтэй гинжин холбоотой гэсэн дүгнэлтэд хүрсэн нь эргэлзээг улам лавшруулж орхижээ. Харин үнэнд дөхөх шахсан магадлалтай өөр нэг хувилбар гаргасан хүн нь Санкт-Петербургийн профессор А.Симяков юм. Түүний дэвшүүлсэн таамаглал, осол болсон газарт явуулсан судалгаагаар орон нутгийн геофизикийн резонансын нөлөөлөл. Осол гарсан орой тэр цүлхэн болон Хар тэнгист геофизикийн резонанс илэрч байсан мэдээлэл тэмдэглэгдэн үлджээ. Ийм нөлөөллийн үед байгалийн давагдашгүй, үл мэдэгдэх үзэгдлийн явцад техникийн үйл ажиллагаа удирдаж байгаа хүн орчныг мэдрэх буюу орон зайн баримжаа алдах, байдлыг үнэн зөв үнэлэх, зохистой шийдвэр гаргах чадвараа алддаг. Энэ таамаглалд хүрээд ослын шалтгааныг олох эрэл мухардаж, хэрэг хаагджээ.

Хар тэнгисийн эрэг орчмын тодорхой газарт эртнээс олны ам дамжин хэлцэгддэг "гүйдэлтэй" хэсгүүд байдаг аж. Хөлөг онгоц сүйрсэн тэр цүлхэнд гэнэт асар өтгөн манан үүсдэг, яг тэр хэсэгхэн цүлхэнд живсэн 150 гаруй том, бага усан онгоц бий гэж яригддаг. Тиймээс уг цүлхэнг "Бага Бермудын гурвалжин", хөлөг онгоцны оршуулгын газар гэгдэх "Намибын эрэг" гэж нэрлэх болжээ. "Адмирал Нахимов" хөлөг онгоцны сүйрлийн учир шалтгааныг үнэн зөвөөр тодруулах гэж Оросын телевизийн ихэд алдаршсан "Зөн билгийн тулаан" нэвтрүүлэгт оролцогч зарим зөн билэгтнүүд далд чадвараа сорьсон ч удаатай. Тэдний гаргалгаа мөн л байгалийн үзэгдэлтэй холбоотой гэсэн дүгнэлтэд хүрсэн л байдаг. Зөвлөлтийн "Титаник" зөнгөөрөө живсэн үү, эсвэл...



хамгийн дээд бэлэг нь бохь. Тэмцээнд оролцохоор Оросоос өөр орон руу явсан тамирчид л анхлан жинс авчирсан гээд бод. Хил гаальд хөрөнгөтний бараа хориотой, шууд хураагдаж шатаагдана. "Том" Сүхбат хэмээн олноо алдаршсан нэрт тамирчин ярихдаа, Америкаас ирэхдээ таван давхар футволка, дөрвөн цамц давхарлаж өмсөнө, цээж эргэхгүй, мөн гурван давхар жинстэй өвдөг нугарахгүй ирдэг байлаа гэснийг олон хүн сонссон. Дарханы Орос клубт /Нийслэлд Ленин клуб гэдэг шиг/ насанд хүрэгчдэд зориулсан Чехийн кино гарч, билетийг зөвхөн орос хүмүүст зарж байснаас үймээн самуун дэгдэж, орос хүний амь эрсэдсэн хэрэг гарч, хоёр орны ах дүүгийн ган бат найрамдалд сав суулгасан үзэл суртлын бузар хэргийг мөрдөн шалгах аар нийслэлээс нисдэг тэрэгтэй эрхмүүд ирж байсан удаатай. Телевизийн цорын ганц сувгаар хэд хэдэн ангит польшийн "Голын тэртээх манан" киноны эхний анги гараад л хаагдсан. Учир нь, шалдан нүцгэн хүүхэн, шалиг завхай явдал ихтэй гэж.

1980 оны эхний дуулиан нь АНУ-ын Лэйк-Плэсид хотод зохиогдсон өвлийн олимпын наадмын хоккейн тэмцээний шувтаргын тоглолт байв. Зөвлөлтийн "улаан машин" гэгдсэн, ялагдашгүй баг, коллежийн оюутнуудаас бүрдсэн АНУ-ын багт 4:3 харьцаагаар хожигдлоо. Хоккейн спортыг ид хөгжүүлж байсан Дарханы залуус урвайж, Дарханд амьдарч ажилладаг оросууд "гашуудан" маргааш нь ажилдаа ирээгүй юм даг. Алдарт хаалгач Третьак, хоккейн домгийн домог Харламов, Петров, Михайловын гурвал ялагдсан нь шууд итгэхэд үнэмшиггүй, өвөл ч хаашаа, зун ч хаашаа гэдэг шиг сонин мэдрэмж төрүүлсэн, гэхдээ болоод өнгөрсөн бодит дуулиан болж үлдсэн дээ. Наяад оны залуус бидний дундаас АВВА зэрэг хөрөнгөтөн орны хамтлагийн пьанз хураагдаж, шилээ давсан үстэй залуус үсээ хайчлуулж бүр хусуулж, өргөн (трапец) өмднийхөө шуумгийг хяргуулж, хөрөнгөтний үзэл сурталд автсан хэмээгдэн ад үзэгдэж, нийгмийн тустай хөдөлмөрөөр шийтгүүлэн оршуулгын нүх ч ухаж байв. 80-аад оны эхэн үеийн залуусын спорт урлагаар ийм сонинтой. Харин нийгэм, улс төрийн хувьд намч, зарчимч хатуу байр суурьтай. Хүйтэн дайны оргил үе өнгөрсөн зууны 70-аад оны сүүлч, 80-аад оны эхний он жилүүд байлаа. Хөрөнгөтнүүд нэгэн аймшигтай бас гайхамшигтай зэвсэг

гэлтгүй орос орон даяар уй гашуудалд автлаа. ЗХУ-ын нам, засгаас ихээхэн анхаарал хандуулсан олимпын наадам ч тасалдаж мэдэх нөхцөл байдал үүсэж болохоор байв. Нам засаг, хууль сахиулах байгууллагаас олон нийтийг хамарсан оршуулга зохин байгуулахгүй байхыг хатуу анхааруулсан ч В.Высоцкийтэй салах ёс гүйцэтгэх ажиллагаа гурван өдөр үргэлжилж, 220 гаруй мянган хүн оролцсон нь социализмын өлгий оронд явагдсан олимпын наадмын нээлтийнхээс давсан үзүүлэлт байлаа.

Зөвлөлтийг он удаан жил тэргүүлсэн удирдагч солигдож, нийгмийн амьдралын зогсонги байдал хөл хөдөлгөөнд орж эхэлсэн үед ЗХУ ямар их хүчирхэг, найдвартай зэвсэгт хүчинтэй болохыг баталсан, эмгэнэлтэй хэдий ч эр зоригтой, эрс хатуу шийдвэртэй явдал тохиов. 1983 онд ЗХУ-ын агаарын илхийг нэвтэрсэн Өмнөд Солонгосын иргэний агаарын зорчигч тээврийн Боинг-747 онгоцыг Сахалины арлуудын өмнөд хэсэгт зөвлөлтийн сөнөөгч онгоцны пуужингаар устгаж, 269 зорчигч амь үрэгдсэн байдаг. Энэ хэрэг явдлыг АНУ, Япон, Өмнөд Солонгосын мэргэжилтнүүд яаралтай мөрдөн шалгасан ч энх тайвны бат бэх хана хэрэм мөргөөд л чимээ сураг алдарсан даг. Яг энэ он жилүүдэд ЗХУ-ын удирдагч ойр ойрхон гурвантаа солигдож, өөрчлөн байгуулалтын эцэг М.С.Горбачевийн зөөлрөлийн, эвлэрлийн эрин үе эхэлсэн юм.

Намайг ЗХУ-д суралцахаар очсон 1986 онд дэлхийн хэмжээний гэгдэх гурван том осол гарсан байдаг. Хоёр нь ихээхэн дуулиан дэгдээсэн билээ. Хүйтэн дайны гол өрсөлдөөн зэвсэглэлээр хөөцөлдөх гэсэн нэр томьёо байв. Энэ хийрхэл, нэгнийгээ давах гэсэн шунахайрлын үр дүнд дэлхийн бөмбөрцөг хэд дахин дэлбэлэх хүчин чадалтай цөмийн зэвсгийн цэнэгт хошуу үйлдвэрлэж, дараа нь устгах гэж үй олон гэрээ хэлцэл, хардлага сэрлдэг, үл ойлголцол гээд бөөн ажил болсон дог. Өөр нэг өрсөлдөөн нь сансрын уудмыг түрүүлж эзэмшиж, сансар судлалын үйл явц байлаа. Сансрын хөлгийг олон дахин ашиглах Сойтэс Шаттл төслийн хүрээнд бүтээгдсэн Чэллэнжер хөлгөөр анх удаа 7 хүний бүрэлдэхүүнтэй баг /2 эмэгтэй, 5 эрэгтэй/ 1986 оны 1 дүгээр сарын 28-нд хөөрснөөсөө хойш 73 секундын дараа 14000 метр өндөрт хүрээд, үдэн мордуулагчдын нүдний өмнө дэлбэрэн

АЗИЙН ОРНУУД ЦАГААН САРААР ЦАР ТАХЛЫН ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХААР АЖИЛЛАЖ БАЙНА

Дэлхий даяар коронавирусын халдвар газар авсаар байгаа

хязгаарлах гэсэн тус улсын Засгийн газрын бодлого юм.



тул улс орнууд Зул сар, Шинэ жил, Цагаан сар зэрэг олон нийтийг хамарсан баяр ёслолын өдрүүдийг хэрхэн эрсдэл багатай даван туулах талаар бодлого боловсруулан ажиллаж байна.

Өнгөрсөн жилийн мөн үе гэхэд Их Британид сургуулийн амралт тохиосноос мянга мянган аялагч гадаад улс руу зорчсон бөгөөд Италийн хойд нутгийн цанын баазад очоод ирсэн хүмүүс олон арван голомт үүсгэсэн аж. Мөн Канадад Талархлын баярын үеэр "COVID-19"-ийн халдварын тохиолдол хамгийн дээд цэгтээ хүртэл нэмэгдсэн байна. Энэ бол коронавирусын тархалтад баяр ёслол хэрхэн нөлөөлдгийг харуулж буй баримт юм.

Ази тивийн хувьд ихэнх улс билгийн тооллын шинэ жил буюу Цагаан сарын баярыг энэ жил 2 дугаар сарын 12-нд тэмдэглэнэ. Жил бүр энэ үеэр дэлхийд хамгийн их шилжилт хөдөлгөөн болдог. Ази тив даяар ойролцоогоор 1.6 тэрбум хүн гэртээ харьж, халуун ам бүлээрээ баяраа тэмдэглэн өнгөрүүлдэг гэсэн судалгаа бий. Өнгөрсөн онд гэхэд Хятадын Ухань мужаас дэгдсэн цар тахлын улмаас цагаан сарын үеэрх шилжилт хөдөлгөөнийг бүрэн хорьсон юм. Энэ жил ч мөн Азийн бүх улс өмнөх жилийн жишээ дагах бололтой. Тэр дундаа Хятад, Япон, Вьетнам, Өмнөд Солонгос зэрэг хүн ам ихтэй орнууд Цагаан сарын үеэр хүмүүсийн хөдөлгөөнийг зогсоохын тулд зарим зохицуулалтыг хийхээр ажиллаж байгаа аж.

Тухайлбал, "The New York Times" сонинд бичсэнээр Хятад улс ажилчдыг эл баяраар замд гарахаас урьдчилан сэргийлж хөл хорио, хязгаарлалт тогтоох зорилгоор гэртээ үлдвэл цалингийн урамшуулал олгох, үр хүүхэд, гэр бүлд нь мөнгөн тусламж үзүүлэх зэргээр өөрсдөд нь нөлөөлөхийг чармайж байна. Мөн хөдөө орон нутаг руу зорчиж байгаа иргэд нутагтаа очоод 14 хоног тусгаарлалтын дэглэмд шилжих ёстойг сануулж, энэ үеэр гарах байр, хоол, коронавирусын шинжилгээний төлбөрийг өөрсдөө төлөхийг анхааруулсан аж. Энэ нь угтаа том хотуудад бага цалинтай ажил хийдэг хүмүүсийн хөдөлгөөнийг

Эрх баригчдын хувьд энэ мэтээр том хотуудаас хөдөө орон нутаг руу зорчих хөдөлгөөнийг эрс хязгаарлахаар төлөвлөжээ.

Өөрөөр хэлбэл, алслагдсан суурин газруудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хангалттай хүртээж чадахгүйн дээр коронавирусын тандалт судалгааг байнга явуулаад байх боломжгүй учир иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс ийм бодлого баримталж байгаа гэдгээ мэдэгджээ. Одоогоор тус улсын цар тахлын дэгдэлт бусад орнуудтай жишихэд харьцангуй хяналтад байгаа бөгөөд олон том хотод амьдрал хэвийн үргэлжилж байгаа ч он гарснаас хойш шинэ голомтууд гарч, үе үе олон нийтийг түгшээсэн шинэ тохиолдлууд бүртгэгдэж байгаад тус улсын эрх баригчид санаа зовниж байна. Он гарснаар 54 тохиолдол шинээр нэмж бүртгэгдсэн учир Цагаан сарын баярын өмнө 50 сая иргэнийг вакцинжуулалтад хамруулахаар шийдвэрлэжээ. Мөн хяналтыг хэд дахин нэмэгдүүлж, Бээжин хотод ирж байгаа болон гарч байгаа хүмүүсээс гурав хоногийн давтамжтай шинжилгээ авсны дараа зөвшөөрлийн хуудас олгож байна. Баярын үеэр ажиллавал илүү цагийг нэг дахин нэмж цалин дээр бодож олгохыг эрх баригчид бүх ажил олгогчдод даалгажээ. Уг журамтай уялдаад баярын үеэр хүмүүсээ ажиллуулсан хувь хүн, аж ахуйн нэгжид Засгийн газраас урамшуулал олгохоор болсон байна.

Өмнөд Солонгосын хувьд иргэдийнхээ сэтгэл зүйд чиглэсэн хязгаарлалтын бодлого авч хэрэгжүүлж байгаа бололтой. Тухайлбал, "Hindustan Times" цахим хуудсанд бичсэнээр метро, автобусны зогсоолуудад "Та амны хаалтыг сонгох уу, эсвэл амьсгалын аппаратыг сонгох уу", "Хэрвээ та гэр бүлдээ коронавирусын халдвар тээгээд очвол Цагаан сарын хамгийн аймшигтай бэлэг тэр байх болно", "Аав ээждээ халдвар тарааж байгаа хүн эх орныхоо өмнө хамгийн гутамшигтай" гэх зэрэг сурталчилгааг байршуулжээ. Өмнөд Солонгосын эрүүл мэндийн ажилтнууд 2 дугаар сард коронавирусын халдвар нэмэгдэх магадлалтай байгаа тул хүмүүсийг олноор цугларахыг

хязгаарлах журмыг дор хаяж 14 хоног үргэлжлүүлнэ гэдгээ албан ёсоор мэдэгдлээ. Эрүүл мэндийн дэд сайд Кан Дотэ "Ирэх Ням гарагаас эхлэн хоёр долоо хоногийн хугацаанд тав ба түүнээс дээш хүн цугларахыг хориглож байна. Засгийн газрын шийдвэр гарсантай холбогдуулан Цагаан сараар гэртээ байхыг ард түмэндээ уриалж байна" гэжээ. Сүүл хотын эрх баригчид хоолны газруудад тавьсан хязгаарлалтаа нэмэгдүүлж, өглөө 10-аас 21 цаг хүртэл хүргэлтээр үйлчлэхийг зөвшөөрчээ.

Хүмүүсийг гэрт нь байлгах гэсэн энэ хатуу журам нь олон мянган бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хохироож байгаад Засгийн газар нь санаа зовж байгаагаа удаа дараа хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан илэрхийлж байна. Хэрвээ дахин нэг долоо хоногийн турш ажигласны дараа вирусийн тархалт намжвал зарим хязгаарлалтыг зөөлрүүлэх шийдвэр гаргах тухай тус улсын Эрүүл мэндийн дэд сайд Кан Дотэ нэмж хэлэв.

Вьетнам Улсын хувьд коронавирусын эрсдэлийг

Японы цагаан сар 1 дүгээр сард тохиосон бөгөөд баярын үеийг цар тахал нэмэгдэх хамгийн эгзэгтэй цаг гэж үзэж байсан. "Nikkei" цахим хуудсанд бичсэнээр тус улсын Ерөнхий сайд Ешихидэ Суга гадаад улсуудаас Япон руу нэвтрэх бүх нислэг, тээврийг хязгаарлаж, уг хоригийг Цагаан сарыг дуустал сунгахаа мэдэгдсэн. Тэрээр энэ тухай дурдахдаа "Япон улсад цар тахлын дэгдэлт саарахгүй байгаагаас үүдэн бүс нутгийн хэмжээнд бүх нислэгийг зогсоогоод байсан. Тэгвэл Ази тив даяар Цагаан сарын баяр болох гэж байгаатай холбогдуулан мөн л гадаад улсаас ирэх бүх ангиллын нислэгийг цуцалж байна. Энэ нь коронавирусын дэгдэлтийг саармагжуулах хамгийн боломжит хувилбар юм" гэжээ. Тус улсад одоогийн байдлаар 400 гаруй мянган тохиолдол бүртгэгдэж, зургаан мянга гаруй хүн нас бараад байна.

Улс орнуудын төр засаг хорио цээрийн дэглэмийг олон нийтийг хамарсан баярын үеэр улам чангаруулах бодлого барьж байгаа нь зарим талаар хүний эрхийг зөрчсөн мэт

байлгах арга нь урьдчилан сэргийлэлт, түүнтэй холбоотой хязгаарлалтууд юм. Тиймээс хүн төрөлхтөн хохирол бага амсахын тулд хөл хорионы дэглэм тогтоох, үүнийг иргэн бүр олонхийн сайн сайхны төлөө хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх шаардлагатай.

Эдүгээ бид цахимжсан иргэншлийг бүтээж, дижитал технологийн эрхшээлд орсон нь нэг талаасаа гэрээсээ ч гарах эрхгүй болсон энэ үед хэрэг болж байна. Өөрөөр хэлбэл, хиймэл оюун ухааны хөгжил хүний оршихуйд маш хурдтай нөлөөлж байгаагийн илрэл юм. Энэ тахал цахимжсан хүмүүнд байгалийн хуулийн сануулга болж байна уу. Магадгүй удаан хугацаагаар хорио цээр үргэлжилвэл цахим орчноос зугтах, уйдах үзэгдэл нэмэгдэж болох юм. Цаашид хувь хүмүүс болон улс орнуудын хооронд харилцан хүндэтгэл, ёс суртахуунлаг чанар нэн чухал гэдгийг цар тахал бидэнд ухааруулж байна. Хөл хорионд ороод хувь хүний эрх чөлөө, хүсэл хязгаарлагдахын хэрээр нийгмийн эв нэгдэл, хамтач үзэл, бусдын эрхийг хүндэтгэх, хэм хэмжээг чухалчлах хандлага нийтлэг болж байгааг ч дурдах нь зүйтэй гэж тэрээр нэмж хэлжээ.

Дэлхий даяар зочид буудал, зоогийн газар, нисэхийн салбар зэрэг уламжлалт аналогид технологид тулгуурласан



Цагаан сарын баяраар гэртээ харихаар 400 гаруй сая Хятад хүн замд гардаг

бууруулах үүднээс энэ сарыг дуустал бүх нислэгээ цуцалсан тухай Ройтерс агентлаг мэдээлсэн байна. Энэ нь Цагаан сарыг дуустал иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах гэсэн тус улсын Ерөнхий сайд Нгуен Супугийн хэрэгжүүлж байгаа бодлого гэж мэдэгдэв. Түүний хэлснээр "Манай улсын хамгийн чухал баяр Цагаан сар болох гэж байгаатай холбогдуулан зөвхөн шаардлагатай гэж үзвэл эрүүл мэнд, гадаад хэрэг, батлан хамгаалах, олон нийтийн аюулгүй байдал зэрэгтэй холбогдсон зөвшөөрсөн нислэгүүдээс бусад бүх нислэгийг цуцалж, арав хоногийн хугацаатай иргэдийн хөдөлгөөнийг бүрмөсөн хорьж байна" гэжээ. Вьетнам Улс нь Азийн бусад улсыг бодвол хорио цээрийн хатуу дэглэмийнхээ ачаар цар тахлыг богино хугацаанд хяналтад авч, ердөө 1513 халдварын тохиолдол бүртгэгджээ.

үйлдэл боловч нийт иргэдийн аюулгүй байдлын төлөө авч хэрэгжүүлж байгаа шийдвэр Гэдгийг ойлгох учиртай гэж Оксфордын их сургуулийн эпидемиологич, доктор Жэнгмин Чэн сануулав. Түүний үзэж байгаагаар халдвар авсан болон сэжигтэй тохиолдолд бүртгэгдсэн хүмүүсийн зорчих, оролцох, хөдөлмөрлөх эрх нь хязгаарлагдаж байна. Энэ бол олонхийн эрх ашиг, сайн сайхан байдал нь цөөнхийн эрх ашиг, сайн сайхан байдлаас илүү үнэ цэнтэй гэсэн үг. Аль ч улсын Засгийн газар шийдвэр гаргахын тулд зардал, үр ашгийн тооцоо хийж үздэг. Хорио цээрийг тогтоогүйгээс үүдэн гарах хохирол, зардал нь хорио цээрийг тогтоосон үеийн зардалтай харьцуулахад ямар байх вэ гэдгээр баримжаална гэсэн үг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, анхааруулгаас харахад хохирлыг хамгийн бага

бизнесүүд хамгийн түрүүнд хямралд өртөж байна. Харин дижитал технологид суурилсан салбарууд цар тахлын үеэр өдрөөс өдөрт хүрээгээ тэлж буй. Чухамдаа технологийн ачаар л бид бие биетэйгээ уулзаж, сэтгэл гутралд орчихгүй тахлын үеийг даван туулж байна. Гэрээсээ ажил эрхэлж, гар утсаар дамжуулан дэлхий ертөнцтэй холбогдож, тоон технологийн давуу талыг илүүтэй мэдэрч эхэллээ. Тиймээс цаашид цар тахлын дараах ертөнцөд технологийн компаниуд улам хүчирхэгжинэ гэж судлаачид үзэж байна.

Одоогоор олон зүйл тодорхойгүй байгаа ч коронавирусын дэгдэлт бидний амьдралын хэвшил, ажиллах хэв маяг, шашин шүтлэг, зугаа цэнгэлийг хүртэл бүрмөсөн өөрчилж чадна. Гэхдээ муу зүйл биш харин ч илүү сайнаар өөрчлөгдөх гол түлхүүр юм гэж шинжээчид үзэж байна.

Шинэ зэвсэг, техник

ОХУ байлдааны тэргүүн шугамд ялангуяа хот дотор үүрэг гүйцэтгэх экипажгүй хуягт машинуудыг хөгжүүлээд байна. Тэдний нэг нь тус улсын БХЯ-ны танилцуулсан дрон танк "Уран-9" юм. Энэ нь танк эсэргүүцэх пуужин, автомат их буу болон пулемётээр тоноглогджээ. Мөн гүйцэтгэж байгаа үүргээсээ хамаарч газар-газар, газар-агаар ангиллын пуужингуудаар тоноглогдох боломжтой. Оптик харааны сайжруулсан систем бүхий дулаан мэдрэх, лазер чиглүүлэгчтэйгээс гадна маш сайн цэцтэй болсон байна.

"Уран-9"-ийн цохилтын бүлэгт экипажгүй дөрвөн нэгж дрон танк, нэг нэгж явуулын удирдлагын станц, тээвэрлэх хүнд даацын автомашинаас бүрдэнэ.

Уг дрон танк нь зургаан замтай дугуй бүхий гинжит явах эд анги дээр суурилсан. Урт нь 5.12 м, өргөн нь 2.53 м, өндөр нь 2.5 м бөгөөд ойролцоогоор 10 тонн жинтэй.

Зэвсэглэлийн хувьд танк эсэргүүцэх "Атака" залуурт пуужинг хоёр талдаа суурилуулсан. "Атака" пуужингийн ашигтай тусгал нь 0.4 км-ээс 6 км бөгөөд 800 мм-ийн зузаантай хуягийг нэвтрэх тактик техникийн өгөгдөхүүнтэй аж. Түүнчлэн цамхагт явган цэрэг эсэргүүцэх 30 мм-ийн автомат их буунаас гадна 7.62 мм-ийн пулемэт суурилуулжээ. Үүнээс гадна 93 мм-ийн галаар шүршигч "Шмел-М" зэвсэгтэй. Мөн "Игла" газар-агаар ангиллын пуужин, "Верба" агаарын довтолгооноос хамгаалах зэвсэг, зургаа хүртэлх "Корнет-М" танк эсэргүүцэх пуужингаас сонгож

"УРАН-9" ДРОН ТАНК



тоноглож болдог.

"Уран-9" нь автомат болон гар удирдлагаар ажиллах горимтой. Автомат горимд операторын урьдчилан бэлдсэн замын маршрутаар явахдаа дайсныг автоматаар таних, илрүүлэх, хянах боломжтой. Харин гар удирдлагаар хөдөлгөөнт командын байрнаас 3 км хүртэлх зайнаас удирдана. Үндсэн дизель болон цахилгаан хөдөлгүүрийнхээ тусламжтай 35 км/ц хүртэл хурдлах чадвартай бөгөөд бартаат замд дунджаар 15 км/ц-аас илүүгүй явдаг байна.

ТАСС

Нүүрийг бэлтгэсэн ахмад М.МӨНХЗОРИГ

ҮХЭР ЖИЛИЙН ӨНТӨ

Энэ жил хаврын Тэргүүн сарын шинийн нэгэн буюу Сар шинийн баяр 2 дугаар сарын 12-нд тохиож байна. Зэвсэгт хүчний офицер, ахлагч, хугацаат цэргийн алба хаагчдын төлөөлөл хулгана жилийн ололт, амжилтаа дүгнэж, Цагаагчин хэмээх үхэр жилийн өнгө төрхийг ийн тольдлоо.

ЗЭВСЭГТ ХҮЧНЭЭ СУРТАЛЧИЛСАН КОНТЕНТИ БҮЛГЭЭХИЙГ ХҮСДЭГ

Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн харьяа Нисгэгчгүй нисэх системийн судалгаа, туршилтын төвийн механик хийцийн инженер, загвар зохион бүтээгч, дэслэгч Б.ЗОЛБООТ:

-Маш шинийг эрэлхийлсэн жил болж өнгөрлөө. Миний хувьд шинэ албан тушаалд томилогдож, ажлаа хүлээж авсан. Монгол Улсын Зэвсэгт хүчин нисгэгчгүй нисэх системийн туршилт, судалгааны төвтэй боллоо. Тус төвд ажиллаж байгаа залуус шинийг эрэлхийлж, оновчтой санал санаачилга гаргахыг зорьж ажилладаг. Энэ чанараараа бие биедээ маш ээргээр нөлөөлж чаддаг. Цар тахлаас үүдэлтэй хүндрэл бэрхшээл нэлээд байлаа. Хүн бүрийн хувьд тийм байсан байх. Гэхдээ төрийн үйлчилгээ, зарим албан байгууллагын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэн нь онцлог. Жишээлбэл E-mongolia.mn сайтаар дамжуулан төрөл бүрийн үйлчилгээг авах боломж бүрдлээ. Мөн "Zoom" аппликейшний тусламжтай хурлаа хийж, сургалт бэлтгэлээ явуулдаг боллоо. Олон хүн нэг дор цуглуулахгүйгээр царай царайгаа харж ярилцаж, санал бодлоо хуваалцах боломж бүрдсэн. Цэргийн алба хаагчдын хувьд сургалтын ийм арга барилд сайн дадлаа.

Үхэр жилийн өнгийг харахдаа нэн тэргүүнд цар тахал бүрэн дарагдаасай гэж хүсдэг. Мэдээж тэр үед хүн бүрийн ажиллах



таатай орчин нөхцөл бүрдэх байх. Энэ онд Ардын хувьсгалын 100, Батлан хамгаалах яамны 110, Зэвсэгт хүчний 100 жилийн ой тохионо. Гурван тэгш ой давхацсан жил болж байна. Эдгээр ойн босгон дээр албаа амжилттай үргэлжлүүлж байгаадаа ихэд олзуурхдаг. Би гэрэл зураг, мультимедиа сонирхдог. Өөрийнхөө нөөц бололцоогоор Зэвсэгт хүчин, ангиа сурталчилсан видео контент хийж, хүүхэд залууст хүргэхийг хүсэж байна. Төгсгөлд нь хүн бүр эрүүл саруул, ажил албандаа амжилт гаргаж, зорьсон бүхэндээ саадгүй хүрээсэй гэж ерөөе.

АМЖИЛТАА БАТЛАЛТАЖ, АХИУЛАХЫН ТӨЛӨӨ АЖИЛЛАНА



Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн Зэвсэг, техникийн албаны техникийн шалгах байрын дарга, ахлах механикч, сургагч ахлагч Д.САНГИАДОРЖ:

-Ангийнхаа "Тэргүүний ахлагч" болсон амжилтаар 2020 оныг үдлээ. Амжилт бүтээлээр арвин жил болж өнгөрлөө. 2020 оны төгсгөлд ангийн хамт олон маань манай гэр бүлд талархлын бичиг явуулсан нь их сайхан санагдсан. "Нөхрөө ажил албандаа хоёргүй сэтгэлээр зүтгэх нөхцөл бололцоог бүрдүүлж, ар талыг нь найдвартай даадаг талархаж байна" гэснийг эхнэр маань уншаад цэргийн хүний гэргий байх ямар сайхан юм бэ гээд өөрөөрө их бахархсан. Энэ дашрамд, ангийн удирдлага, нийт бие бүрэлдэхүүн болон гэр бүл, найз нөхдөдөө талархдагаа илэрхийлье. Цаашид үүнийг уламжлал болговол маш сайхан жишиг тогтоно гэж бодож байна. Цар тахлаас үүдэн ангийн үйл ажиллагаа, сургалт бэлтгэл онлайн хэлбэрээр явагдсан. Үүнийг их соргоогоор хүлээж авсан. Тун шинэлэг санагдсан.

Мэдээж иргэн хүнийхээ хувьд цар тахлын аюул халуур өнгөрч, өмнөх шигээ сайхан цаг ирээсэй гэж хүсдэг. Миний хувьд энэ онд гавьяаныхаа амралтад гарна гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Тиймээс 2021 онд өмнөх амжилтаа бататгаж, ахиулахын төлөө ажиллана. Удахгүй гарах үхэр жилд анги, хамт олны минь амжилт бүтээл ундраасай гэж хүсэж байна.

УЛС ОРНЫХОО ХӨТЖИЛ ДЭВШИЛД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛНА

Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн байлдагч Б.ТЭМҮҮЖИН:

-Би 2000 онд Улаанбаатар хотод айлын отгон хүү болон мэндэлсэн. Аав ээж, эгчийн хамт амьдардаг. Цэргийн албанд татагдахаасаа өмнө "Мандах" их сургуульд Санхүүгийн менежмент хөтөлбөрийн 3 дугаар курст суралцаж байсан.

Эгнээнээсээ 10 баатар төрүүлсэн алдар түүхтэй Маршал Х.Чойбалсангийн нэрэмжит Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлд цэргийн алба хааж байгаадаа туйлын их баяртай байна. 2020 он хүн бүрийн хувьд аюулт цар тахал болох "Covid-19"-өөс өөрийгөө болон гэр бүл, хайртай хүмүүсээ хамгаалсан хариуцлагатай жил болж өнгөрсөн. Түүнчлэн бид эрүүл байхын ач тус, байгаль дэлхийгээ хайрлах ухаан, зөв амьдралын хэв маягийг хэрхэн баримтлах гэх зэрэг олон зүйлийг ойлгосон. Миний хувьд хугацаат цэргийн албанд өөрийн хүсэлтээр татагдсан нь хамгийн зөв алхам байсан. Учир нь цэргийн албанд хүний амьдралд хэрэг болох олон чадварыг дарга нараасаа суралцаж, найз нөхөдтэйгөө хамт хөгжиж байна. Цэргийн алба хаасан нэг жил миний амьдралд тодоор үлдж, нэгэн гэрэлт хуудас нээх болно гэдэгт итгэдэг. Үхэр жилд цар тахал бүр мөсөн зогсож хүн зоно минь магнай тэнгэр, айх айдасгүй, энх тунх аж төрөх болтугай. Мөн хугацаат цэргийн



алба хаагчид бид улс орныхоо бүтээн байгуулалтад гар бие оролцож, хөгжил дэвшилд нь хувь нэмрээ оруулж, албаа амжилттай хаасан жил болно гэж бодож байна.

ЭСЭЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

ЗОРИЛГО:

Монгол Улсын Зэвсэгт хүчин, Зэвсэгт хүчний Ар талын түүхт 100 жилийн ойг тус тус тохиолдуулан Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд материал, техникийн хангалтын үйл ажиллагааг сурталчлан таниулах, хангалтын тогтолцоог боловсронгуй болгон хөгжүүлэхэд бие бүрэлдэхүүний оролцоог хангаж, идэвхийг өрнүүлэхэд оршино.

Зохион байгуулагч: Зэвсэгт хүчний Жанжин штабын Материал, техникийн газар

Сэдэв: Материал, техникийн хангалт, ирээдүйд

Хамрах хүрээ: Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн

Эссэг хүлээн авах хугацаа: 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 17.00 цаг хүртэл mtg.esse.2021@gmail.com цахим хаягаар хүлээн авна.

Тавигдах шаардлага:

Өгөгдсөн тодорхой сэдвийн хүрээнд Зэвсэгт хүчний материал, техникийн хангалтын өнөөгийн болон ирээдүйн тулгамдаж буй асуудлыг оновчтой тодорхойлох, хөгжүүлэх талаар өөрийн санаа бодлыг үндэслэлтэй, судалгаатай илэрхийлсэн байхаас гадна дараах шаардлагыг хангасан байна.Үүнд:

-Үндсэн сэдвийн хүрээнд бичигдсэн байх;

-Үндэслэл, судалгаатай байх;

-Төрийн болон албаны нууцын тухай хууль зөрчөөгүй, нууц материал ашиглаагүй байх;

-Өөрийн шинэлэг санаа бодлыг тодорхой илэрхийлсэн, дүгнэлттэй байх;

-Монгол хэлээр, 500 үгэнд багтаан зөв бичих дүрэм болон утга, найруулгын алдаагүй (Arial үсгийн фонт, үсгийн хэмжээ 11) бичсэн байх;

-Эссэг ирүүлэхдээ нэгтгэл, анги, салбарын дугаар, албан тушаал, эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, холбогдох утас, цахим хаягийг тодорхой бичсэн байна.

Шагналын сан: 1 дүгээр байр -1, өргөмжлөл, 500.000 /таван зуун мянга/ төгрөг;

2 дугаар байр -1, өргөмжлөл, 300.000 (гурван зуун мянга) төгрөг;

3 дугаар байр -1, өргөмжлөл, 200.000 (хоёр зуун мянга) төгрөг.

Ирүүлсэн эссэг шалгаруулалтын комисс шалгаруулна.

Шалгаруулах журам:

-Тавигдах шаардлагуудыг хангасан эсэх (20 оноо);


-Бүтээлч хандлага, дэвшүүлсэн шинэлэг санаа (40 оноо);

-Сэдэв, зорилго, агуулга, дүгнэлтийн уялдаа (40 оноо).

Лавлах утас: 88283581, 89093313, ДАТС-3521, 3569

ЗХЖШ-ЫН МАТЕРИАЛ, ТЕХНИКИЙН ГАЗРЫН ШТАБЫН ДАРГА, ХУРАНДАА З.БАЯНМӨНХ

Үндэсний бахархал **ӨВ СОЁЛ**



МАНАЙ АНГИУДЫН ДОТОР

Намын гишүүн Тойсон хэвлэл бүхнийг сайн уншдаг, Маршал Чойбалсангийн бага нас, Улсын баатар Олзвой, Бүх холбоотын эв хамт "Бо" намын ба СССР-ийн товч түүхийн зэрэг номуудыг уншиж, онц чухал зүйлүүдийг нь дэвтэртээ тэмдэглэж аваад байлдагч нартаа нөхөрлөлийн журмаар ярьж өгдөг болой. Өөрөө номыг ингэж уншиж судалдагаараа ахлах дэслэгч Намжилын ангийн онцчуудын нэгэн болжээ. Хадхүү.

Батлан хамгаалахын төв архивын сан хөмрөгөөс Улаан-Одон сонин. 1943.03.18. Дугаар 63 /1324/

ЦӨСИЙТ РАШААНААР УТААХ АРТА

Цөсний хүүдий нь лийр хэлбэртэй хоол боловсруулах эрхтэн бөгөөд хоол идэх үед агшиж, сунах хөдөлгөөн хийж, өөх тосийг шимэгдүүлэн холестеринг уусгах үүрэгтэй юм. Цөсийг угаахын өмнө урьдчилан эмчид хандаж эхөд харуулан, цөсний чулуугүй гэдгээ мэдсэн байх шаардлагатай.

Цөсийг угаахаас урд өдөр нь хөнгөн хоол идэж, маргааш өглөө нь босоод бие засаж, амаа сайтар угаах хэрэгтэй. Дараа нь өлөн элгэн дээрээ буюу 7-8 цагийн хооронд угаана. 200 гр "Кука курортная" эсвэл "Оргил" рашааны аль нэгд магни сульфат(25г) хийж найруулаад гашуун амтыг амтлахгүйгээр том балгаж ууна. Баруун хажуу буюу цөсний хүүдий оршдог талаараа хэвтэж, баруун хөлийг нугалж баруун хавирганы нуман дагуу бүлээн жин тавьж, 30-40 минут нумарч хэвтэнэ. Жингээ тавих явцдаа 500-600 гр рашаанаа бага дугаар ууж дуусгана. Рашаанаар урд өдөр нь бэлдэж, тагийг нь суллаж хийг нь гаргана.

Цөс угаасны дараа 3-7 хоног өөх тостой, хайрсан, хоносон хоол идэж болохгүй. Ясны шөл, бантан, ногооны зутан зэргийг идэж аажмаар ердийн хоолонд шилжинэ. Цөсийг угааснаар гадагшлах замыг нь цэвэрлэн цөсний ялгаруулалтыг идэвхжүүлж, хүүдий нь суларна. Улирал бүр, жилд хоёроос доошгүй удаа цөсөө угаах нь таны эрүүл аж төрөхөд тустай.

Хориглох заалт:

-Цөсний чулуутай, жирэмсэн, өндөр даралттай болон хэт бага даралттай, ходоод гэдэсний шархтай, элэг цөсний архаг үрэвсэл сэдэрсэн, өндөр настай хүмүүс цөсөө угаахыг хориглоно.

ЦТЭ-ийн сувилагч Л.ХАНДМАА, Ц.МӨНГӨНЦЭЦЭГ

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор
Хурандаа
САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

Эхийг "Соёмбо" сонини редактад бэлтгэж, "Соёмбо принтинг" хэвлэх үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламгыг хямд нийтэлнэ.
*Зар, рекламгыг үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сонини нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонини мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029